



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-11
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	

1.Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсох /Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/	13-57
2.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай	57-61
3.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	61-63 66-72
4.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	63-64
5.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	64-66
6.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох	72
7.“Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	73-76

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 01-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 19 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Дамдинням,
Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Ц.Туваан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Ганхуяг, Г.Мөнхцэцэг, Ш.Раднаасэд,
Ж.Сүхбаатар;

Тасалсан: С.Батболд, Г.Ганболд, Ч.Хүрэлбаатар;

Хоцорсон: Ц.Анандбазар- 04 минут, Э.Батиугар- 01 минут, Х.Булгантуяа- 15 минут, С.Ганбаатар- 18 минут, Д.Ганбат- 23 минут, Б.Дэлгэрсайхан- 07 минут, Б.Жавхлан- 05 минут, Д.Өнөрболор- 32 минут, Б.Саранчимэг- 25 минут, Н.Учрал- 16 минут, О.Цогтгэрэл- 05 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулав./10:22/

Нэг.Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсох /Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай нар байлцав.

Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 10 цаг 25 минутаас 10 цаг 39 минутад хуралдааныг даргалав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Т.Энхтүвшин, Б.Бат-Эрдэнэ, Ч.Ундрэм, Б.Батгөмөр, Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Б.Баярсайхан, Л.Энх-Амгалан, Т.Аубакир, Г.Тэмүүлэн, Ц.Идэрбат, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Ж.Батсуурь, С.Чинзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 59 минут үргэлжилж, 13 цаг 18 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Хоёр.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан референт Н.Монголмаа, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 10 минутаас 14 цаг 20 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: 1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” саналыг оруулж, 23 гишүүн дэмжиж, 56.1 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар Баагаагийн Баттөмөрийг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Энхбаярын Батшугарыг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:26/

Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Васгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн М.Уранбилэг, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ц.Баянмөнх, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын хэсгийн бүрэлдэхүүн дутуу тул уг асуудлыг хэлэлцэхийг түр хойшлуулав./14:34/

Дөрөв.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, мэргэжилтэн П.Түмэнбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	22
Бүгд:	44

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн М.Уранбилэг, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ц.Баянмөнх, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын эрх, үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/,” гэж, 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4, 5, 6, 7 дахь дэд заалт тус тус нэмэх:

“3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцны байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-т заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх тохиолдолд ерөнхий архитекторын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулах;

6/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.3-т заасан журамд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг хамруулах талаар тусгах;

7/Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг цахим платформд бүртгэлтэй зорчигч тээвэрлэдэг иргэн хамаарахгүй байхаар зохицуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 17

Бүгд: 45

62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 17

Бүгд: 45

62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг болон 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.2.4 дэх заалтын “аймаг,” гэснийг тус тус хасаж, 2 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн 19.1.6” гэснийг “23 дугаар зүйлийн 23.2.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 16

Бүгд: 46

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:10/

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 25
Бүгд: 48
47.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 26
Бүгд: 47
44.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 23
Бүгд: 46
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг түр хойшлуулав./15:41/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эмч, ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 21, 23 дугаар хороодын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын дэд дарга

С.Одонтуяагийн урилгаар Архангай аймгийн Их тамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн, Э.Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, мөн ерөнхий боловсролын сургуулийн 12а,б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, Нийслэлийн ерөнхий боловсролын “Гурван тамир” сургуулийн багш, ажилчид, “Хөгжилд эмэгтэйчүүд” зөвлөгөөнд оролцож буй Монголын эмэгтэйчүүдийн холбооны Баянхонгор, Говь-Алтай аймгийн салбар зөвлөлийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Н.Учрал, П.Анужин нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн 143, 151 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 43 минут үргэлжилж, 72 гишүүнээс 51 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 19 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

1 дүгээрт, Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 5 төсөл байгаа.

2 дугаарт, Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсоно. Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар. Өвөлжилтийн нөхцөл байдал авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл сонсоно.

3 дугаарт, Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай асуудал

4 дүгээрт, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

6 дугаарт, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг, анхны хэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, Хууль, тогтоолын төслийг эцэслэн батална.

8 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл сонсох байсан.

Өнөөдөр үг хэлэх гишүүн байхгүй байна. Нэрээ татсан байна.

Ингээд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалангаас. Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. 26 07 тоот албан тоот бичгийг танилцуулъя.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ гадаадад томилолтоор ажиллаж байгаа тул Улсын Их Хурлын чуулганы 23 оны 12 дугаар сарын 01-ний

өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хувьд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийн товьыг хойшлуулж өгөхийг хүсье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан гэсэн байна. Энэ мэдээллийг хойшлууллаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Энэ бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална. Гишүүд суудлаа эзлээрэй. Хууль эцэслэн батлах санал хураалт явуулах учраас.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хууль эцэслэн батлах санал хураалтыг тохиромжтой шаардлагатай цаг үед явуулж болно гэж заасны дагуу түр хойшлуулаад энэ цаг үеийн шинжтэй мэдээллээ сонссоны дараа санал хураалт явуулъя гэж бодож байна.

Ийм учраас энэ Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаанд зэрэгцээ хурал яваад байгаа учраас нөгөө нийслэлийн Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг барилгажуулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа учраас зэрэгцээ эцэслэн батлах санал хураалт явуулж болохгүй гэж үзээд энэ асуудлыг хойшлуулж, шаардлага хангасан үед, ирцийн шаардлага хангасан үед санал хураалт явуулахаар шийдвэрлэлээ.

Ингээд цаг үеийн шинжтэй мэдээллийг сонсоно.

Өвөлжилтийн нөхцөл байдал авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан хийнэ. Индэрт урьж байна.

Ажлын хэсгийг оруулъя.

С.Амарсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд салбар яамдууд, аймаг, нийслэл, төв, орон нутгийн хэмжээнд холбогдох арга хэмжээг авч бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлын тухай мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар.

Энэ жил Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй хувьд зудын өндөр эрсдэлтэй гэдэг тооцооллыг мэргэжлийн байгууллагууд гаргасан. Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 10 аймгийн 22 сум цагаан зудтай, 8 аймгийн 26 сум цагаанаар зудархуу нөхцөлд шилжсэн байна.

Өнгөрсөн зун гантай байсан говийн болон баруун бүсийн нутгаар зудын эрсдэл их зэрэглэлд байна. Зунилага сайн байсан ч энэ намрын эхний цас ахиу орсон төвийн болон зүүн бус нутгаар мөн эрсдэл ихтэй гарсан нь ихэнх нутгаар өвөлжилт, хаваржилт хүндрэх нөхцөлийг үүсгээд байна.

Монгол Улсын хэмжээнд өнгөрсөн зун агаарын температур олон жилийн дунджийн орчим, харин Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгорын зарим аймаг, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар гандуу байлаа. Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацын судалгаагаар нийт нутгийн 48,5 хувь бэлчээр хүрэлцээтэй, 31 хувьд 1-3 дахин, 6,7 хувьд 3-5 дахин, 13,8 хувьд бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн байна.

Энэ жил улсын хэмжээнд нийт 190 мянган малчин өрхөд 69,1 сая мал өвөлжиж, 17,2 сая толгой малыг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх урьдчилсан тооцоолол бий. Мөн 18,8 мянган малчин өрхийн 7,8 сая мал отроор өвөлжиж,

хаваржих зохион байгуулалт хийгдсэн нь өмнөх оныхоос 1,9 саяар буурсан байна.

Улсын хэмжээнд МАА-н салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг малчдын өвс, тэжээл бэлтгэл, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлт, ус, хашааны хүрэлцээ хангамж, малчин өрхийн бэлтгэл зэрэг үндсэн үзүүлэлтээр дүгнэхэд 87,5 хувьтай хангагдсан байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар 2024 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд бүх төрлийн малын махны экспорт, импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Өнөөдрийн байдлаар 70 мянган тонн мах, махан бүтээгдэхүүнийг экспортлоод байна. Үүний 40 хувь нь буюу 28 мянган тонн нь дулааны аргаар боловсруулсан мах бөгөөд түүхий мах руу шилжүүлэн тооцвол 106,5 мянган тоннд хүрсэн байна. Нийт махны экспортын 11 хувийг үхрийн мах, 36 хувийг адууны мах, 20 хувийг хонины мах, 33 хувийг ямааны мах эзэлж, үүнээс 86 хувийг БНХАУ, 1 хувийг ОХУ, 8 хувийг Иран, 2 хувийг Хонконг, 2 хувийг бусад улсад тус тус экспортлосон байна. Түүнчлэн 23 он гарснаар нийт 106,4 мянган толгой бог малыг экспортлоод байна.

Нийслэлийн хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан 8 мянган тонн махыг бэлтгэн нөөцлөх ажил үргэлжлэн хийгдэж байна. Энэ хүрээнд Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг баталснаас гадна мах бэлтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, санхүүжилтийн эх үүсвэр болон зээлийн хүүгийн хөнгөлөлт, үйл ажиллагаа явуулах схем зураглалыг гарган санхүүжилтийн гэрээний нөхцөлийг Монгол банктай хамтран шийдвэрлэлээ.

Мөн Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн экспортлож байгаа 44 ААН-тэй бодлогын гэрээг байгуулж, экспортлосон махны тоо хэмжээний 10 хувьтай тэнцэх хэмжээний үхэр, хонины махыг бэлтгэн дотоодын зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсаас БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох бүртгэлтэй 18 ААН байгаа бөгөөд тус улсын Гаалийн ерөнхий газар нь 23 оны 10 дугаар сард Монгол Улсад мал төхөөрөх, мах боловсруулах 4 Аж ахуйн нэгжийг бас шинээр нэмж бүртгэн импортын эрх олгосон байна.

Монгол Улсын хүн амын тэн хагас нь оршин сууж буй нийслэлийн хүн амын өвлийн улирлын махны хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “өвлийн идэш” арга хэмжээг энэ оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд 11 байришилд зохион байгуулж байна.

Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар мэдээлье.

Монгол Улсын эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах, ажлын явцад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагууд зохион байгуулалт хийн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар ДЦС-уудын үндсэн тоноглол болох 52 зуух, 39 труба генератор ажиллаж байна. Системийн горим ажиллагаа хэвийн байна гэж үзэж байгаа.

Эрчим хүчний салбарын үйлдвэр, ААН-ийн хэмжээнд өнөөдрийн байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангах, засвар шинэчлэлийн ажил дунджаар 93,6 хувьтай байна. Үүнээс дулааны цахилгааны станцууд 89 хувь, дулааны

станц дулааны сүлжээ 95 хувь, цахилгаан дамжуулах түгээх сүлжээ 93 хувь, нүүрсний уурхайнууд болон Тавантолгой түли компанийн 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

2023-24 оны өвлийн ачааллын үед төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал 1567мвт хүрэх төлөвтэй байгаа нь өмнөх оны өвлийн оргил ачааллаас 93мвт-аар буюу 6 хувиар өсөхөөр байна. 2023 оны 11 дүгээр сарын 23-наас 24-ний өдөр гадна агаарын температур өнгөрсөн оны мөн үеэс 8-11 градусаар хүйтэн байсан бөгөөд тухайн үед эрчим хүчний системийн ачаалал 1483-1506мвт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 207мвт-аар өссөн бөгөөд цаашид 1600мвт-аас дээш гарч болзошгүй байна.

Өвлийн их ачааллын горим ажиллагааны үед ДЦС-ууд ямар нэгэн бэлтгэл тоноглолгүйгээр бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа бөгөөд үндсэн тоноглолын болзошгүй гэнэтийн зогсолт, тасралт, саатлын үед тухайн нэгж тоноглолын хүчин чадлаар хэрэглэгчдийг хязгаарлах арга хэмжээ авч болзошгүй байна.

Шатахууны нөөц хэрэглээний талаар

Оросын Холбооны Улсын ЗГ 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1537 дугаар тогтоолоор дэлхийн улс орнуудад нийлүүлэх шатахууны экспортдоо тодорхой хугацаагаар хязгаарлалт хийсэн. Манай улсын хувьд Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулсны үр дүнд дээр дурдсан шатахууны хязгаарлалтад орохгүйгээр экспортоор шатахуун хүлээн авах зохицуулалт хийж, улмаар 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс экспортын ачилт хийгдэж эхэлсэн. 23 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрийн хооронд импорт хийгдээг үед энэ үеийг өмнө нь бүрдүүлсэн нөөцөөрөө бас хангаж ирсэн.

Дизель түлшний талаар

Манай улсын дизель түлшний сарын дундаж хэрэглээ 92-95 мянган тонн байна. 23 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 28-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 102,6 мянган тонн дизель түли импортоор орж ирснээс Оросын Холбооны Улсын Роснефть компаниас 57,4 мянган тонн, Нефть хими сервис компаниас 17,3 мянган тонн, бусад нийлүүлэгчдээс 26,5 мянган тонн, БНХАУ-аас 6,1 мянган тонн тус тус импортолсон байна.

Импортоор орж ирсэн 102,6 мянган тонн дизель түлшийг боомтоор нь ангилж үзвэл, Сүхбаатар боомтоор 87,8 мянган тонн, Эрэнцав боомтоор 3,5 мянган тонн, Замын-Үүд боомтоор 6,1 мянган тонн, Цагаан нуур боомтоор 4,5 мянган тонн, Боршоо боомтоор 705 тонн тус тус оруулж ирсэн байна.

Түүнчлэн БНХАУ-аас 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр 3500 тонн дизель түли орж ирснээс гадна, 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр БНХАУ-аас импортлох 31,5 тонн дизель түлшний захиалгын төлбөрийг баталгаажуулсан. Үүнээс эхний ээлжийн 2500 тонн нь 7 хоногийн дотор хилээр орж ирэх төлөвтэй байна.

Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 279 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 03 тоот албан даалгавар, УОК-ын албан даалгавар, хуралдааны тэмдэглэл зэргээр өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Аймаг, сумын аюулгүй нөөц бүрдүүлэлт 78,5 хувьтай бэлтгэгдсэн байна. МАА-н салбарын өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан махны экспортод квот тогтоохгүй байх, өвсний экспортыг 23 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс хязгаарлах, малын тэжээлийн экспортыг 23 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 24 оны 03 дугаар сарын 10-ны

өдрийг хүртэл хязгаарлах зэрэг шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Мал, махыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр “өвлийн идэш” арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мах ханган бэлтгэн нийлүүлэх ААН-үүдтэй цаашид зохион байгуулалтын ажлыг улам эрчимжүүлэхээр зохих байгууллагууд уялдаа холбоогоо ханган ажиллаж байна.

Энэ жил тэжээлийн ургамлын тариалалтад зориулан үрийн болон техникийн дэмжлэг үзүүлж, өвөлжөө, хаваржаанд тариалах сургалт явуулсан. Үүний үр дүнд улсын хэмжээнд 111 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалж, 240 мянган тонн ногоон тэжээл хурааж авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 40 хувиар илүү байна.

Өвөлжилтийн нөхцөл хүндэрсэн үед шатахууны хангамжид хүндрэлтэй асуудал үүсэж байгаа ч Монгол Улсын Засгийн газар, Уул уурхайн яам зэрэг газар асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

Төвийн бүсийн нэгдсэн системийн оргил ачааллыг тохируулах зорилгоор 80мвт-ын хүчин чадалтай, 200мвт-ын цагийн багтаамжтай батарей хуримтлуурын станцыг 23 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс ажиллагаанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Амгалан дулааны станцын 116мвт-ын хүчин чадалтай шинэ зуухны өргөтгөлийг 2024 оны 01 дүгээр сард ажиллагаанд оруулахаар Улаанбаатар хотын зүүн бүсийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байгаа тул малчдыг мал махаа эдийн засгийн эргэлтэд оруулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссоос уриалга гарган, Засгийн

газраас холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Эрчим хүч дулааны эх үүсвэрийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, мал, махыг бэлтгэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад стандартын шаардлагыг нэн тэргүүнд тавьж ажиллахыг холбогдох яам, агентлагт үүрэг болгон хяналт тавин ажиллаж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Одонтуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Жамбалын Ганбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Гомбожавын Ариунбуян ОБЕГ-ын дарга, Аюушжавын Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Түвшинсайханы Баярхүү УОК-ын нарийн бичгийн дарга, Батмөнхийн Насантогтох Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн байна уу? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Чулууны Хишигдалай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, Гэлэгжамцын Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Бүртгэе. Цэрэнпунцаг гишүүнээр, Чинзориг гишүүнээр тасаллаа.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Д.Тогтохсүрэн, С.Чинзориг нарын урилгаар Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эмч, ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгддээ ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Асуулт, үг хамт байгаа. Даваасүрэн гишүүн асуулт асууж үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе. Юуны өмнө бас Их Хурлын удирдлагуудын зүгээс энэ өвөлжилтийн талаар бас тодорхой арга хэмжээ авч, мэдээлэл хийгээч ээ гэсэн саналыг бас хүлээж авч, өнөөдөр мэдээлэл хийлгэж байгаад талархаж байна. Ер нь өвөлжилтийн байдал эрт хүндэрчихлээ. Зарим сумд бол маш их хэмжээний цас ороод мөстөөд, мал бэлчих бололцоогүй болсон. Өвөлжилт хүндэрсэн сумд нь өвөлжилт гайгүй байгаа сумд руугаа орчхож байгаа учраас үнэхээр бэлчээрийн асуудал маш хүнд болж эхэлж байна.

Манай аймгийн хувьд Жаргал, Цэцэрлэг, Цагаан-Үүр гэсэн сумд бол хүнд болсон. Эдгээр ялангуяа Жаргал, Цэцэрлэгийн малчид бусад сум руугаа отроор ороход бол нэлээн хүндрэлтэй байдал бол үүсээд байгаа юм байна. Тийм учраас бас энэ отрын асуудлыг сайн зохицуулж өгөхөд манай Онцгой байдал анхаарах ийм шаардлага байх шиг байна.

Цаашидаа яаж хүндрэхийг бол хэлэхэд маш хэцүү байна. Малчдын хувьд бол ялангуяа энэ зудад өртсөн байгаа сумдын иргэдийн хувьд үнэхээр хүнд байна. Байнга утсаар ярьж байна, хэлж байна. Тэгэхдээ нээрээ яамаар юм, маш л хэцүү ийм нөхцөл байдал бол орсон байна. Тийм учраас тэр хэлээд байгаа ялангуяа мах авах тухай асуудлыг нэлээн сайн зохион байгуулж өгөх ийм шаардлага байх шиг байна. Малчид арай гайгүй байгаа дээр нь харин эрт бас хүндэрсэн учраас тарган байгаа малаа нядлах ийм

арга хэмжээнүүдийг авч эхэлж байна. Тэгэхээр энэ чиглэлд нь анхаарах, 1 дүгээрт.

2 дугаарт, тэгээд хавтгайдаа хүндрээд эхлэх юм бол тэжээл гэдэг юм уу өвсөөр хангана гэдэг бол хүндрэлтэй байдаг юм билээ. Тэгэхээр энэ чиглэлээр яах ёстой юм гэдгийг бас нэлээн судалж үзээд, манай ОБЕГ бас тодорхой арга хэмжээнүүдийг авах шаардлага бол бас гарах байх. Энэ чинь яг хүйтний эрч бол чангарчхаагүй шүү дээ. Одоо 12, 1 сар хүйтний эрч чангараад ингээд ирэхийн үед энэ нэг нүүдэллэсэн, оторлосон малд маш хүнд болно. Хавар дээр нь бас хүндэрчих юм бол бүр малын хорогдол нэмэгдэх ийм нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Тийм учраас урьдчилсан тодорхой арга хэмжээнүүдийг л зохион байгуулалтаа сайн авах хэрэгтэй байна. Өвөлжилт хүндрээгүй сумд руу отроор ороход нь яаж зохион байгуулах вэ, хаана хаана хаанахын малыг оруулах вэ гээд ийм арга хэмжээнүүдийг орон нутгийн онцгой байдалтайгаа хамтраад, ХАА-н байгууллагуудтайгаа хамтраад хийх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Тэгээд нөхцөл байдал хаана хаанаа тодорхойгүй байгаад байна шүү дээ. Бид нар яах вэ, зүгээр цаг уурын хувьд нэг сарын прогноз гаргах байх. Тэгэхдээ л бас эрсдэлтэй, яаж ч цаашидаа бол хүндэрч мэднэ. Тийм учраас болзошгүй хүндрэлийг тооцоод, төлөвлөөд ингээд ажиллах ийм шаардлага үүсэж байна. Тийм учраас ер нь энэ ямар ямар арга хэмжээнүүдийг авах юм гэдгийг хэдүүлээ сайн ярилцаад тэгээд Засгийн газрын зүгээс, Их Хурлын зүгээс арга хэмжээнүүдээ авч эхэлмээр байна. Магадгүй малын хөлийн татварыг нэг жилээр хойшлуулах уу, яах вэ? Тийм ээ.,

Яагаад гэвэл малчдын орлого бол хүндэрч байгаа юм байна лээ. Нөгөө арьс шир тэгээд малаас гарч байгаа энэ бүтээгдэхүүнүүдийн үнэ нь байхгүй, махны үнэ уначихсан ийм үед орлого хүнд

учраас нөгөө өвс, тэжээлээ бэлдэж чаддаггүй, өвс тэжээл нь асар өндөр үнэтэй болчихсон байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ ямар арга хэмжээнүүд авах вэ гэдэг дээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун. Мах бэлтгэл, малын хөлийн татвар, орон нутагтаа тогтоож бол болж байгаа шүү дээ. Сумын түвшинд, тэглэж болж байгаа, цас зудтай үе гээд л тэглэчхэж байгаа юм.

Х.Болорчулуун: Сая Даваасүрэн гишүүн асуулаа. Малын хөлийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг бас ярилцъя гэсэн саналыг тавилаа. Малын хөлийн татварыг орон нутаг, аймаг, сумд өөрсдөө шийдэж байгаа. Сумын иргэдийн хурал шийдэж байгаа. Тэр зудтай сумд малын хөлийн татварыг хэвээр нь байлгах уу, хөнгөлөх үү гэдэг нь бол сумын эрх мэдлийн асуудал гэдгийг бас хэлэх байна.

Мах бэлтгэлийн талаар ярилаа. Цас зуд болж магадгүй бас нэлээн дийлэнх газар бас нэлээн цагаан зудархуу байх учраас малчид мал махаа нэлээн хийж байна. Махны үнэ бас нэлээн уналттай байна. Нийслэлийн нөөцийн махыг бэлдэхийг 24 оны 01 сарын 01-нээс нийслэлд өөрөө хариуцахаар болсон. Урьд нь бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцдаг байлаа шүү дээ. Мах бэлтгэл дээр нийслэл, энэ жил гэхэд 42 тэрбумыг нөөцийн мах бэлтгэл дээр тавьсан байгаа. Тэр хэмжээндээ махыг худалдаж авч, нөөцийн мах бэлдэнэ гэдгээ хэлье. Он гараад ч гэсэн бас нөөцийн мах үргэлжилж бэлдэнэ.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Энэ өвөлжилт хүндрээд ирэхээр бас малаас гадна яг тухайн орон нутгийн малчид нөгөө малаасаа холдож чадахгүй. Тэгээд нөгөө сэтгэл санааны дарамтаасаа болоод

өвчлөлт бас их гардаг юм. Тэгэхээр энэ чиглэлээр манай жишээлбэл эрүүл мэндийн салбар ямар арга хэмжээ авъя гэж бодож байна. Нөхцөл байдал бол цаашидаа хүндэрнэ шүү. Тийм учраас тэр улсууд чинь малаа яая гээж байгаа, мал дээрээ байгаад байдаг, тэгээд сум орж чаддаггүй, тэгээд өвчлөх ийм асуудал нэлээн гардаг. Энэ чиглэл дээр эрүүл мэндийн салбар ер нь яаж анхаарах вэ?

Г.Занданшатар: Эрүүл мэндийн сайд Содномын Чинзоригийг дуудъя. Содномын Чинзориг сайд чуулгандаа ирье. Шадар сайд Амарсайхан Эрүүл мэндийн сайдаа дуудна. Яагаад өнөөдөр цаг үеийн шинжтэй асуудал хэлэлцэж байхад энэ Эрүүл мэндийн сайд чуулгандаа ирдэггүй юм. Ажлын хэсгээс эрүүл мэндийн салбарын хүн байна уу?

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар БГД-ийн 21, 23 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Баянголчууд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Төрөлх үү, би чинь 77 дугаар сургууль төгссөн юм байгаа юм. Баянголын уугуул иргэн. Баянголчууддаа хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Содномын Чинзориг сайдыг хүлээж байна. Сарангэрэл сайд Чинзориг сайдыг дуудъя. Намайг дуудаад ирэхгүй юм байна, Чинзориг сайдыг 10 минут хүлээж байна. Содномын Чинзориг сайдыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр дуудаж байна. Чинзориг сайдыг ирэхгүй бол цалинг нь хасах шийтгэл оногдуулна.

Сайнбуянгийн Амарсайхан сайд хариулъя.

Дэгийн тухай хуулиар хариуцлага тооцох ямар зохицуулалт байна, аваад ирээч.

С.Амарсайхан: Даваасүрэн сайдын асуусан энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар ЭМЯ, аймаг, орон нутгийн эрүүл мэндийн газрууд, холбогдох байгууллагууд хамтарч ажиллаж байгаа. УОК-ын хуралдаанаар бас салбарын сайд нарт үүрэг даалгавар өгсөн.

Салбар хоорондын уялдаа холбоог хангах, ялангуяа энэ өвөлжилтийн хүндрэлтэй нөхцөлд иргэд, малчдыг отор, нүүдлээр явахаас гадна мөн бусад цаг үед ч гэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр түргэн шуурхай хүргэх, нэн ялангуяа хэвтэрт болон бас хүнд өвчтэй, эмчилгээнд байдаг иргэдэд эм тариа, эмчилгээ оношилгооны үйлчилгээг цаг алдалгүй хүргэхтэй холбоотой зохион байгуулалтын ажлыг хийж ажиллах, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Амарсайхан сайд аа, яг өөрийн чинь хэлээд байгаа шиг тэр нөгөө нэг очиж хүрч үйлчлэхэд зарим сум, Цэцэрлэг энэ тэр бол нөгөө эмнэлгийн тэрэг нь муудчихсан. Тэгээд нөгөө цастай зузаан хөрс нь энэ тэр хатуурчихсан газар энэ тэр лүү бол явж чадахгүй, хүрч чадахгүй болчихоод байгаа юм байна лээ. Одоо л гэхэд тийм болчихоод байгаа юм байна лээ.

Тийм учраас тэр машин тэрэгний асуудлуудыг нь та бүгд бас энэ яг зуд бүр хүндэрчихсэн байгаа сумдын хувьд бас нэг анхаараад, түлш шатахуун дээр нь дэмжих боломж байдаг юм уу, үгүй юү? Одоо чинь нөгөө түлш шатахуун өндөр болчихсон. Тэгээд нөгөө түлш шатахууны зардлаа дийлэхгүй болчихоод байгаа юм байна лээ. Энэ чиглэл дээр бас

ЭМЯ-тай холбогдоод та бүгд анхаараач ээ гэж би хэлэх гээд байгаа юм.

Г.Занданшатар:
Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би 1, 2 зүйл хэлээд орхиё.

1 дүгээрт, Хэнтий аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ганхүлэг, Идэрбат гишүүн бид хэд сумуудаараа саяхан зүүн тал, хойд талын сумдуудаар яваад ирсэн. Удахгүй 12 сарын 7, 8 гээд ингээд наад талын сумд, урд талын сумдаараа явна. Байдал нөхцөл туйлын хүнд байна.

Тойргоос сонгогдсон гишүүний хувьд хэлэхэд бол манай Хэнтий аймаг 2 жил дараалан энэ ган зудын байдалтай байгаа. Зундаа бэлчээрийн ургамал төдийлөн сайн гарахгүй, намар хадлангийн шим тэжээл тааруу, мал тэр чинээгээрээ махан тарга энэ өвлийг давах хэмжээний тарга хүч авч чадаагүй. Ийм байтал энэ жилийн ган зуд, юу зудын байдал бол маш эрт эхэлчихлээ. Та бүхэн маань мэдэж байгаа байх. УОК дээр ч нэлээн яригдсан. Тэгэхээр энэ дээр нэг хэд хэдэн арга хэмжээг их яаралтай авмаар байгаа юм.

1 дүгээрт, энэ зуд турхны асуудал бол тухайн малчны асуудал, эсвэл орон нутгийн асуудал, эсвэл УОК-ын, онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагуудын ажил гээд орхиж болмооргүй байгаа юм. Их Хурал, Засгийн газар, онцгой комисс, орон нутаг их сайн хамтарч ажиллах хэрэгтэй байгаа юм. Орон нутгийн улсууд бол бид мэднэ шүү дээ.

Яг бодит байдал дээр бол ингээд нэг намын ажил, сонгуулийн ажил болох юм бол эргээд тойроод ингээд хаалга үүдээ онголзуулаад яваад байдаг. Эс үгүй бол нэг ой болох юм уу ямар нэгэн тэмдэглэлт үйл явдал болох юм бол хандив туслалцаа нэхээд бүр нэр усыг нь

гаргачихсан ингээд яваад байдаг. Гэтэл яг ийм хүнд нөхцөл байдалд энэ хөдөөгийн малчин түмэндээ туслах энэ ажлыг цогцоор нь хийх хэрэгтэй байна. Яагаад би энэ үгийг хэлж байгаа вэ гэхээр зэрэг энэ өдрүүдэд орон нутгийн ИТХ хуралдаж, орон нутгийнхаа төсөв төлөвлөгөөг баталж байгаа юм. Энэ төсөв төлөвлөгөөгөө Засгийн газрын авч хэрэгжүүлэх гэж байгаа ажил, УОК-оос авч хэрэгжүүлэх гэж байгаа ажилтай уялдуулах хэрэгтэй.

Үүний цаад талд ААН байгууллагууд, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагууд хамтарч ажиллах хэрэгтэй байгаа юм. Хүн болгон эрвийх дэрвийхээрээ ингэж оролцож байж энэ өвөл, хаврын хүндрэлийг бол ард нь гаргах ийм ажил хийхгүй бол малчин хөдөөгийн цасан далай дунд цөөхүүлхнээ ингээд хэдэн малын захад байж байгаа малчин хүн гэдэг бол дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу ийм хөр цасны хайриу тун хүнд байна шүү.

Тийм учраас I дүгээрт, энэ шатахууны хангалт дээрээ онцгой анхаарах хэрэгтэй байна. Хөдөө орон нутагт чинь нөгөө нэг хэдэн порттерууд нь зайлуул чирч хулдраад л нөгөөдхөө хөдөлгөж байж л өвс, тоос эсвэл нэг жаахан мал мах, шөлөө зах зээлд хүргэх гээд ингээд явдаг. Одоо хөдлөх юу байхгүй, бензин шатахууны дутагдалтай.

Дээрээс нь өвөл хүндрэх гээд байгааг тэртээ тэргүй ойлгомжтой байгаа учраас жалга судгаар малаа үхүүлж хаяж байсанд орвол эртхэн эргэлтэд оруулъя, бойлье, нядалъя гээд ингээд нядалдаг. Тэрийг нь зах зээлд хүргэх тэр нь хязгаарлагдмал.

Өвс, тэжээлийн асуудал маш хүнд байгаа шүү. Энэ өвлийн бэлтгэл өвс тэжээл, түлш түрүүн Даваасүрэнгийн хэлдэг тэр эрүүл мэндийн асуудал. Энэ хүнийхээ эрүүл мэнд, амь нас энэ байдлыг хэдүүлээ сайн анхаарч арга хэмжээ

авахгүй бол болохгүй байна шүү. Нэг ийм хэд хэдэн юман дээр би зүгээр асуугаад байх юм алга. Санал ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Содномын Чинзориг сайд цаг үеийн шинжтэй асуудлаар асуулга тавьж, Улсын Их Хурлын гишүүдээс малчдын эрүүл мэнд, энэ цас зодны нөхцөлд эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар асуулт асуух үед байгаагүй учраас сануулж байна.

Асуултад хариулна. Асуултад Содномын Чинзориг сайд Цэрэнпилийн Даваасүрэн сайдын асуултад хариулна. Гишүүний асуултад хариулна.

С.Чинзориг:

Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Би сая чуулгандаа байж байгаад гаднаас нэг зочид орж ирсэн учраас нэг зураг авхуулъя гээд гарчихсан хооронд ийм асуудал болжээ.

Яах вэ, ер нь улирлын томуугийн дэгдэлт бас нэлээн хүндрэх төлөвтэй байна. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийг тодорхой шалгуур, хүчин зүйлсүүдээр дүгнэдэг 5 бас ангилаар бол авч үздэг. Одоо надад байгаа мэдээллээр томуу, томуу төст өвчний дэгдэлт 2 дугаар шатын түвшин буюу идэвхжилийн үе шатдаа байна гэсэн ийм мэдээллийг бол мэргэжлийн байгууллагууд надад өгч байгаа.

Цаг үеийн өвөлжилтийн асуудал хүндэрч байгаатай холбоотойгоор орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн сайдын албан даалгавар гаргаад өвөлжилт хүндэрсэн үед малчдад ялангуяа хөдөөгийн иргэдэд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Чинзоирг сайд гүйцээж хариулъя. Ахиад I минут.

С.Чинзориг: Цаг хүндэрсэн үед хөдөөгийн малчдад эмнэлгийн тусламж,

үйлчилгээ чанартай шуурхай хүргэхтэй холбогдуулаад албан даалгавар гаргаад биелэлтийг нь хянаж шалгаж ажиллаж байна. Онцгой комисс дээр нэг асуудал яригдсан. Энэ цаг хүндэрсэнтэй холбоотойгоор гаднын аймагт болоод аймаг дотроо сум хооронд отроор өвөлжих малчдын судалгааг бас яаралтай эрүүл мэндийн байгууллагуудад гаргаж өг гэсэн ийм асуудлыг ярьж байгаа. Тэгээд Онцгой комиссын дарга, Онцгой комиссын удирдлагуудад бас чиглэл өгсөн. Энэ нэгдсэн мэдээлэл гараад ирвэл бид нар аймгийн нэгдсэн эмнэлгүүд, сумдын нэгдсэн эмнэлгүүдэд бас үүрэг чиглэл өгөөд отроор явж байгаа малчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ чанартай хүртээмжтэй хүргэх талын бас арга хэмжээг авна.

Нэг асуудал, хүндэрч байгаа асуудал. Энэ цаг үе өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагууд бас судалгаа авч үзсэн. Эмнэлгийн түргэн тусламжийн унаагүй ерөөсөө огт унаагүй болчихсон байгаа нэг 50 сумын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Архангайчууддаа, төгсөгчдөдөө гэгээн дурсамж өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Эргэн дурсахуйн их уулзалтад нь Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс өндөр амжилтыг хүсье.

Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Өвөлжилтийн байдал ер нь хүндэрч байна. Ер нь цаашдаа ч гэсэн улам хүнд болох ийм магадлалтай болчихлоо. Тэгэхээр бид бас одооноос эхлээд нэлээн

арга хэмжээ авахгүй бол хоцрох ийм аюултай байж байна. Ялангуяа энэ жил малчид маань их хэмжээгээр малаа заазалж байна. Тэгээд малчдын юу гэдэг юм малын үнийг унагахгүй байх талаар Хүнс, хөдөө аж ахуйн яам ямар арга хэмжээ авч байгаа вэ? Ялангуяа энэ дулааны аргаар боловсруулж байгаа мах бол олон үйлдвэрүүд байж байгаа шүү дээ. Тэгээд эд нар бол гадагшаа экспортлоод гаргахад бол малынх нь үнэ, хани өсөлттэй байж байгаа. Харин малчдаас авахдаа хямд үнээр авч байгаа. Тийм учраас миний юу гэж бодоод байна гэхээр энэ дулааны аргаар боловсруулж байгаа махны үйлдвэрүүддээ хангалттай хэмжээний зээл өгөөд, ингээд махны үнийг бас тогтвортой худалдаж авах ийм арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн яам бас зохион байгуулах хэрэгтэй байна.

2 дахь асуудал. Түрүүн Даваасүрэн сайд асуусан. Чинзориг сайд аа, энэ хөдөө орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагынхаа томилолтын зардлыг, бензин шатахууны зардлыг нэг хангалттай тавьж өгөөч. Тэгээд л асуухаар л ерөөсөө бензин шатахуун байхгүй, томилолт байхгүй, эм тариа байхгүй гэдэг л ийм асуудал тавиад байгаа юм. Тэгээд энэ тал дээр та бүхэн маань нэг онцгой анхаарч өгөөч гэдгээ.

3 дугаар асуудал бол энэ бид нар их олон жил ярьсан даа. Одоо бид нар энэ нэг Оросын Холбооны Улсаас энэ таваарын улаан буудай оруулж ирдэг асуудлаа нээж өгмөөр байна. Малчид маань юу ярьж байна вэ гэхээр тэжээл олдохгүй байна, хивэг олдохгүй байна, үнэтэй байна гэдэг асуудлыг л яриада байна шүү дээ. Тэгээд дотоодын энэ юу гэдэг юм гурилын үйлдвэрүүд чинь юу гэдэг юм хивгээ гадагшаагаа экспортлоод байна.

Тийм учраас Оросын Холбооны Улсаас орж ирэх энэ улаан буудайн хоригоо цуцлаач. Ядаж 04 сарын 01 хүртэл цуцлаад энэ улаан буудай оруулж ирэх ийм бололцоо боломжийг нь нээгээд, энэ хивгийнхээ үнийг, тэжээлийнхээ

үнийг унагах ийм арга хэмжээ зохион байгуулахгүй бол одоо байгаа энэ дотоодоос хураасан улаан буудайны нөөц чинь бол хүрэхгүй юм байна лээ шүү. Тийм учраас энэ дээр нэг онцгой анхаарах хэрэгтэй байна гэдгээ бас хэлмээр байна.

4 дүгээр асуудалд бол энэ Уул уурхайн сайдаас асуухад бол бензин шатахуунаа юу гэдэг юм эхний ээлжид энэ хөдөө орон нутаг руу хуваарилах, ялангуяа энэ хилийн боомтууд руу хуваарилах, мөн юу гэдэг юм, энэ экспортод гаргаад валют оруулж ирж байгаа энэ уул уурхайн энэ компаниуддаа эхний ээлжид хуваарилах ийм арга хэмжээг аваач. Ингээж ажиллавал бид нарын эдийн засаг бас унахгүй байх. Мөн малчид маань юу гэдэг юм сум эд нар бензин шатахуунтай байх ийм бололцоо боломж байна.

Тийм учраас бас энэ орж ирсэн бензин шатахуунуудаа бас эрэмбэлж хуваарилах тал дээр бас нэлээн онцгойрч, онцгой анхаарах, хандуулж ажиллаач ээ гэж байна.

Өвс тэжээлийн үнэ чинь ер нь ингээд тогтвортой байх юм уу? Одоо өсөөд байна шүү дээ. Ялангуяа энэ говийн бүсэд юу гэдэг юм газар тариалан гэж юм байхгүй. Тийм учраас энэ говийн бүсэд өвсний үнэ, тэжээлийн үнэ асар өндөр үнэтэй байж байна шүү дээ. Тийм учраас үүнийг юу гэдэг юм энэ Улсын онцгой комиссоос гэдэг ч юм уу энэ говийн бүсүүд рүү хуваарилж байгаа өвс, тэжээлийнхээ үнийг бас нэг тогтвортой хуваарилах, ялангуяа сум, орон нутагт хүргэж өгөх энэ ажлыг сайтар зохион байгуулаач ээ л гэж хүсмээр байна.

Тэгээд мөн юу гэдэг юм УОК-т хэлэхэд энэ Замын-Үүдээс Сайнианд, Сайниандаас Айраг хүртэл энэ авто зам чинь мөстөлт ихтэй биш үү. Тэр чигээрээ л мөс байж байна. Ялангуяа говьд өдөртөө цас нь хайлаад, оройдоо мөс болж ингээж хөлдөөд, зам бол явахад маш хүндрэлтэй байж байна. Нөгөө гаднаас орж ирдэг импортын ачаа

эргэлт чинь, хүнсний бараа, тоног төхөөрөмж чинь, гадагшаа гарч байгаа мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур чинь гарахгүй болчих вий. Тийм учраас Дорноговь аймгийн онцгой байдлын газарт ядаж нэг ... /минут дуусав/

Г.Занданишатар: Эхлээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд хивгийн экспортыг хориглох асуудал. 2 дугаарт чинь 100 мянган тонн улаан буудай хүнсний ангиллаас тэжээлийн ангилал руу шилжсэн байгаа шүү дээ. Тийм ээ, түүнийгээ яаж зохистой хуваарилах ёстой юм. Малын тэжээлийн асуудал, улаан буудайн импортын асуудлуудтай холбоотой асуудлыг хариулна.

2 дугаарт нь түли шатахуунтай холбоотой асуудал. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд хариулна.

Х.Болорчулуун: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Мал махны үнэ унаад байна. Ер нь тэгээд унахгүй байх талаар, ер нь мал махны экспортын талаар, энэ яам ямар арга хэмжээ авч байна гэж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хувьд мал махыг экспортлох талаар ямар нэг хориг, квот байхгүй, бүх төрлийн маханд квотыг байхгүй болгосныг бүгд мэдэж байгаа.

Мөн мал махыг экспортод гаргахад ялангуяа махыг 10 гаруй хоногоор 310 хэдэн цагаар бараг хөөцөлдөж, 6, 7 газраас зөвшөөрөл авдаг ийм хүнд сурталтай байсан. Үүнийг бол нэг цонхны бодлогод шилжүүлсэн, өдрийн 8 цагтаа багтааж экспортод гарах энэ зөвшөөрлөө авч байгаа гэдгийг бас хэлэх байна.

Махыг гадагшаа гаргахдаа манай махыг түүхийгээр нь, тэр чанасан байдлаар нь, мөн амьдаар нь бүхий л төрлөөр нь гаргах бодлогыг бол дэмжиж байгаа. Үүний үр дүнд өнгөрсөн 22 онд 16 мянган тонн мах экспортод гарсан бол

одоогийн байдлаар 70 мянган тонн мах экспортод гараад байна. 4 дахин их.

2 дугаарт, мал мах бэлтгэхэд 6 хувийн хөнгөлөлттэй зээл, мал махны чиглэлээр бизнес эрхлэгч нарт, аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа. Энэ дээр энэ чиглэлийн бизнес эрхлэгч нар өндөр хүүтэй банкны зээл авахгүйгээр ажиллаж байгаа. Ийм учраас боломжийн хэрээрээ энэ мал махны үйлдвэрлэл, бизнес эрхлэгч нар бол зээлээ аваад байгаа. Ялангуяа нийслэл дээр энэ жил гэхэд 48 тэрбум хөнгөлөлттэй зээлийн төсөв тавигдсан. Үүнийг авч хэрэглэж байгаа гэдгийг бас хэлье. Он гараад ч гэсэн хөнгөлөлттэй зээл үргэлжилж явагдана.

Тэгжээл, хивэг олдохгүй байна гэж. Гурилын үйлдвэрүүдээс бол хивэг нэг жилдээ 60-70 мянган тонн гардаг. Тэгээд бусад дагнасан тэгжээл үйлдвэрлэлийн бэлтгэдэг үйлдвэртэйгээ нийлээд ер нь 100 орчим тонн хүч тэгжээл гарч байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар экспортод гарч байгаа нь 20 хувь буюу 20 мянган тонн хивэг тэгжээл экспортод гараад байна, 20 хувь нь. Гэхдээ манайд тэгжээлийн үнэ бас тодорхой үнэд орлоо. Энэ жил. Хятад Өвөр Монголоос үнэтэй байна шүү дээ. Тэгжээлийн үнэ. Хивгийг 12 сарын хивэг тэгжээлийг 12 сарын 10-наас 03 сарын 10 хүртэл гадагшаа экспортод гарахыг нь хориглоод байна, одоогоор.

Г.Занданшатар: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар хариулна.

Ж.Ганбаатар: Энхтүвшин даргын асуултад хариулъя. Сая бас Амарсайхан даргын сайдын бас хариултад нь гарсан. 102 мянган тонн дизель түлш орж ирсэн. Сарын хэрэглээнээсээ өндөр, эхний бараг нэг 25 хоногийн байдлаар шүү дээ, 11 сарын 01-нээс 25-ны хооронд. Тэгээд яг хаашаа зарцуулагдаад байна гэдэг асуулт гарч ирж байгаа. Тэгэхээр хамгийн гол зарцуулж байгаа газар бол уул уурхайн

салбар өмнөх онуудад бол нэг үсрээд л нэг 30 мянган тонныг сардаа хэрэглэдэг байсан бол одоо хамгийн багадаа 50 мянган тонныг хэрэглэдэг болсон уул уурхайн салбар. Энэ ерөөсөө хамгийн гол дутагдаж байгаа гол энэ юу, нийлүүлэлт хэвийн мөртөө хэрэглээ даваад байгаа гэдэг дээр хамгийн гол нь уул уурхайн салбарын энэ экспорт нэмэгдсэнтэй холбоотойгоор та бол сайн мэдэж байгаа. Бид бол нэг үсрээд л 32 сая тонн нүүрс экспортолдог байсан бол одоо 62 сая тонн нүүрс экспортолж байгаа. Та бас эртээр Байнгын хороо дээр хэлж байсан. Дарханы сав бүс нутгаас бид нар эсонш болоод бусад металлуудыг, баяжмалуудыг бид машинаар, өмнө нь бол вагоноор экспортолдог байсан бол дандаа автомашин авто замаар экспортод гаргаж байна. Энэ өөрөө бас хэрэглээнд нэлээн нөлөөлж байгаа.

Үүнийг тэгээд яаж шийдвэрлэх гэж байгаа талаар Засгийн газар ямар арга хэмжээ авч байна гэвэл бид БНХАУ-аас Евро ангиллын дизель түлш импортлож байгаа. Өмнө нь бол ер нь огт импортлодоггүй байсан үнийн зөрөөнөөс болоод, одоо бид бол ер нь хамгийн багадаа 5 мянгыг импортлодог байсан бол энэ сараас эхлээд бид 30 мянга, 20 мянга, нэг сард 25 мянга, 2 сард 20 мянгийн захиалгаа өгсөн байгаа. Энэ юугаар дизель түлшээр бид уул уурхайн компаниудаа бол хангана.

Оросын Холбооны Улсаас импортлож байгаа дизель түлшээрээ бид иргэдээ бусад хэрэгцээтэй газруудыг, колонкуудыг ийм төлөвлөгөөтэй бол ажиллаж байна. Тэгээд ер нь бол Дизель Түлш 92 дээр бол асуудлууд бол байна. Энэ бол тэгээд зовлонгоо яриад байвал зөндөө л. Би зөндөө хариулсан учраас бас давхардуулаад яах вэ.

Ер нь асуудал бол Оросын Холбооны Улсын өвлийн түлшний хувьд бол бас Оросын Холбооны Улсын бас дотоод хэрэглээ өөрөө бас дутагдалтай. Алс бөглүү нутгуудад нь бол бас л Монголтой адилхан асуудлууд бол байна.

Энэ асуудал бол энэ 12 сарын 10 гээд жигдэрчих болов уу гэж Оросын Холбооны Улсаас хэлж байгаа. Тэр тохиолдолд Ангарскийн үйлдвэрээс ачилт нэмэгдэнэ. Бид ямар ч байсан энэ ойрын үед энэ дизель түлшний асуудлыг жигдрүүлэхээр ажиллаж байна. Тэгэхдээ хоногоос, өдрөөс өдөрт бол асуудал дээрдэж байгаа.

Тэгээд бид бол 2 хөршөөсөө хоёулангаас нь дизель түлш экспортолж байна. Таны асуултад голлон хариулахад бол уул уурхайн салбарт бид Орос юу, БНХАУ-аас экспортолж байгаа евро 5 ангиллын дизель түлшийг цаашидаа хэрэглэнэ. Говийн бүс болоод Эрдэнэт үйлдвэр ч гэсэн ер нь цаашидаа бол дандаа Евро 5 стандартын энэ төрийн өмчит томоохон компаниудыг бол манай яамнаас бодлогоор бол шахаж байгаа. Евро 5 стандартын дизель түлш хэрэглэхийг шахаж байгаа.

Улаанбаатар хотын тээвэрт ч гэсэн Евро 5 стандартын энэ сайн чанартай дизель түлшийг хэрэглэх ёстой, үүнийг ч гэсэн бид бодлогоор бас хэлж байгаа. Хариулт дууслаа.

Г.Занданшатар: Ер нь шатахууны хангамж, дизелийн хангамжийн асуудал бол нэг талаасаа манай эрэлт хэрэгцээ өссөнтэй холбоотой юм байна лээ шүү. Одоо 60 сая тонн нүүрс экспортлоход бараг 2 дахин, 1,5 дахин их нүүрс экспортлоход дагаад дизелийн түлшний хэрэглээ 1,5 дахин өссөн байна лээ. Үүнээсээ болоод захиалга нь дутуу, дээр нь тээвэрлэлтийн асуудал. Тэр Разноображинский билүү Ангарскээс биш тээвэрлэлтийн ийм нэг асуудлууд гараад үүнээс болоод энэ доголдол үүссэн. Үүнийг бол ойрын хугацаанд тогтворжуулахаар ажиллаж, ойрын хугацаанд үндсэндээ дизелийн түлшний хангамж тогтворжиж байгаа гэдгийг хаана хаанаа анхаарьал зохино. Тэгэхгүй бол уул уурхайн том компаниуд чинь нөөцлөөд, 92 энэ тэр нэг банкаа л дүүргэнэ.

Дизель түлшний чинь нөөцлөх хэмжээ, уул уурхайн том компаниудын хэрэглээ өндөр учраас үүнээсээ шалтгаалсан ийм хомсдолууд бас олон шалтгаантай байгааг эдийн засаг, төлөвлөлтийнхөө үүднээс энэ яамд анхаарч, урьдчилж захиалгаа тэрэнтэй нийцүүлж өгч ингэж нийцүүлж яахгүй бол тэгээд дараа нь үүнийгээ янз бүрээр тайлбарлаад байж болохгүй юм байна лээ. Үүнийгээ бол хаана хаанаа анхаарч ажиллах хэрэгтэй.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхтайваны Бат-Амгалан нарын урилгаар БЗД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Чинбатын Ундрам гишүүн асуулт асууж, байж байгаарай. Ундрам гишүүнийг дараа нь үгийг нь өгье. Хариултыг гүйцээж Сайнбуянгийн Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Өвөл энэ хүндрэл бэрхшээлийг даван туулахад УОК, Засгийн газар, холбогдох яамдууд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллаж байгаа. Энэ оны 07 дугаар сарын 04-нөөс эхлээд Ерөнхий сайдын албан даалгавар, Шадар сайдын албан даалгавар, түүний хэрэгжилтийг аймаг, орон нутагт хангуулахтай холбоотой бүхий л чиглэлээр, дээр нь малчид, иргэдэд өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангах, урьдчилан сэргийлэхтэй холбоотой цаг агаарын мэргэжлийн байгууллагуудын мэдээ мэдээллүүдийг байнга хүргэж ирж байгаа.

Мөн зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа. Түүрүүн хэлсэн, хивэг, тэжээлийн экспортыг түр ирэх

оны ,3 дугаар сар хүртэл зогсоосон. Аймаг, орон нутгийн удирдлагуудын аюулгүйн нөөцөө бүрдүүлэх асуудлуудыг УОК дээр шуурхай итаб байгуулагдаж, орон нутгийн шуурхай итабуудтай хамтарч ажиллан хяналт тавьж ажиллаж байгаа.

Замын нөхцөл байдал бас Дорноговь аймгаас хүсэлт ирсэн, УОК судалж байгаа юм. Шийдвэрлэх талаас нь анхаарч байгаа юм. Гэхдээ УОК замын байгууллага биш, АЗЗА зам засварын компаниуд гээд арчилгааны компаниуд гээд бий. Улсын хэмжээнд. Энэ компаниуд тэр замынхаа аюулгүй байдлыг хангах ёстой. Зам, тээврийн яам хяналтаа тавих ёстой, Авто тээврийн үндэсний төв гэж бий. Одоо манайд нэг буруу хандлага яваад байгаа юм. Гэнэт байж байж байгаад цас зуд өвөл болохоор УОК-оос аймаг, сумдууд нь машин нэхдэг, хөрөнгө мөнгө нэхдэг ийм хандлага бий. Мэдээж тусална. Гэхдээ энэ байгууллага хандивын байгууллага биш.

Аймаг, орон нутгийн удирдлагуудын хүлээсэн үүрэг гэж бий. Сум, орон нутгийнхаа төсөвт энэ асуудлуудаа шийдэх ёстой, салбарын яамдууд гэж бий. Яамд хоорондын уялдаа холбоогоо хангаж энэ асуудлуудаа шийдэхгүй бол зун болохоор бүх зовлонгоо мартдаг. Өвөл ганц удаа болж байгаа зуд анхны удаа тохиолдож байгаа юм шиг эмнэлгийн тусламж үйлчилгээ хүргэх болохоор УОК-ын машин өгөх ёстой гэж Засгийн газраас нэхдэг. Энэ хандлагаа ер нь аймаг, орон нутаг гэдгийг бас боль оо гэж байгаа юм.

Ер нь мэдээж дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Малчид маань амаргүй хүнд нөхцөлд байгаа. Бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлэхээс гадна энэ мал, махны хангалт, нийлүүлэлтийг бодлогоор дэмжих, орон нутагт явуулаар бой, нядалгааны цэгүүдийг ажиллуулах, хот, суурин газар луу татаж авах, хадгалах, нөөцлөх, агуулахуудын үйл ажиллагааг нь жигдрүүлэх, шаардлагатай хөрөнгө

мөнгөний болон зарим бодлогын дэмжлэгийг үзүүлэхээр Засгийн газар дээр ярилцаж байгаа.

Ирэх 7 хоногт бас Засгийн газрын хуралдаанаар зарим асуудлуудыг оруулж шийдвэрлэнэ. Аймаг, орон нутгийн удирдлагууд удахгүй төсвөө батална. УОК-оос бас тодорхой үүрэг даалгавар өгсөн байгаа. Төсвөө батлахдаа сум, орон нутагтаа шаардлагатай тэр бензин тос, машин техникийн асуудлуудаа шийдвэрлэ ээ гэж УОК-оос зарим аймаг, орон нутгуудад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан бензин, тосны асуудлуудыг шийдвэрлэж өгч байгаа. Хөрөнгө мөнгөний тусламж үзүүлж байгаа.

Энэ өвс, тэжээлийн ханган нийлүүлэлт дээр бас энэ аймаг, орон нутаг Засгийн газар анхаарахаас гадна манай малчид энэ өвөлжөөнийхөө стандартыг сайжруулж, малыг өвөл дулаан эрсдэлгүй, өвөлжүүлэх тал дээр сэтгэлгээний болон зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх цаг болчихсон. Яг энэ байдлаараа энэ цаг агаарын уур амьсгалын өөрчлөлтөөс эхлээд энэ өвөл, зун тохиолддог зуд, үер, бороо усны асуудлууд цаашаа улам нэмэгдэнэ. Энэ бүхэн дээр бүх салбар, бүх шатанд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Т.Энхтүвшин: Би нэг юм асуугаад байгаа юм л даа. Энэ дулааны аргаар боловсруулж байгаа махны үйлдвэрүүдэд тодорхой хэмжээний зээл олгооч. Дулааны аргаар боловсруулаад гаргаж байгаа махны үнэ, ханиш чинь бол буухгүй байгаа шүү дээ. Урд талдаа үнэтэй байж байгаа. Тийм учраас малчдын гар дээр байгаа махыг энэ дулааны аргаар боловсруулж байгаа үйлдвэрүүд дээр л худалдуулж авч өгөөч ээ гэдэг л ийм асуудал тавиад байгаа юм. Ийм бололцоо болно.

2 дугаарт, энэ Оросын Холбооны Улсаас орж ирж байгаа энэ оруулж ирэх энэ улаан буудайгаа яаралтай оруулж ирээч. 04 сарын 01 хүртэл ч гэдэг юм уу оруулж ирээч. Энэ гурилын үйлдвэрүүдэд хангалттай нөөцийг бий болгоод энэ хивэг, тэжээлээ олноор үйлдвэрлэе л дээ. Үнийг нь унагая л даа. Одоо малчдын хандлагыг өөрчилнө гээд яриад яах юм. Өвөл болоод зуд болчхоод байна шүү дээ. Энийгээ дулаан болоход энэ асуудлаа ярьж эхэлье. Энэ бол ярьж байгаа нь зөв. Одоо бол бид нар яаж өвс тэжээлээр хангах вэ? Яаж малчдынхаа эрүүл мэндийг анхаарах вэ? Яаж юу гэдэг юм ... /минут дуусав/

Г.Занданшатар: Сайнбуянгийн Амарсайхан сайд хариулна. Шадар сайд хариулъя.

С.Амарсайхан: Малчдын асуудлыг онцгой анхаарч байгаа. Энэ өвөлжилтийн хүндрэл малчдын асуудал биш. Монголын асуудал. Бидний амь амьжиргаа, хувь заяа, улс орны ХАА, эдийн засгийн гол салбарын асуудал. Малчид маань алс хязгаар нутаг, хөдөө зэлүүд газарт эзэн нь болж, бидний өмнөөс үүрэг, хариуцлага үүрч энэ улс орноо манаж байгаа хүмүүс. МАА-н салбараа нуруундаа үүрч яваа хүмүүс. Тийм учраас УОК-оос өнгөрсөн 7 хоногт уриалга гаргасан. Бүх нийтээрээ малчдаа дэмжье. Бүх талын дэмжлэг тусалцааг үзүүлье гэж, 1 дүгээрт.

2 дугаарт, Засгийн газар малчдын энэ мал махыг худалдан авах, ханган нийлүүлэх, үнэ өртгийг буулгахгүй байх тал дээр тооцоо судалгааг хийж, ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар тодорхой шийдвэр гаргана.

3 дугаарт нь, ер нь энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ саяын яриад байгаа асуудлыг өнөөдөр ярьж байгаа асуудал биш.

Г.Занданшатар: Энхтүвшин гишүүн ээ, хариултаа сонс. Содномын Чинзориг сайд асуултад хариулна.

С.Чинзориг: Цаг, өвөлжилт хүндэрч байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудад бас онцгой анхаарч, албан даалгавар гаргаад, хэрэгжилтээ хангаж ажиллаж байгаа. Томилолтын зардал, шатахууны зардал, эмийн зардал гээд ингээд гишүүд яриад байх юм. Одоо чинь манайд ЭМД-ын сангаас чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар явж байгаа шүү дээ. Тэгээд эрүүл мэндийн байгууллагууд тарифаараа зардлаа аваад тэгээд ямар зардалд нь эхний ээлжид санхүүжилт олгох вэ гэдэг шийдэх бүрэн эрх нь эрүүл мэндийн байгууллагуудад байгаа.

2 сумын эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой 2 бодлогын өөрчлөлт бол хийж байгаа. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, сумын эрүүл мэндийн байгууллагууд үлдэгдэл санхүүжилттэй гарвал тэрийг нь бас төвлөрүүлэн татдагийг больсон. Өөрсдөө захиран татах эрхийг нь нээж өгсөн.

2 дугаарт, бид нар 01 сарын 01-нээс бүсийн коэффициент хийх ийм зохицуулалт цоо шинээр хийнэ. Ингэснээрээ алслагдсан хүн ам цөөтэй сумдын эрүүл мэндийн байгууллагаа дэмжих ийм бас бодлого бол явуулна.

Г.Занданшатар: Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна.

Ч.Ундрам: Манай тариаланчдын нөхцөл байдал маш хүнд байна. Цаг агаарын нөхцөл байдлаас үүдээд ургац бага гарсан, ургац алдсан. Дээрээс нь шатсан ургац, бас соёолоод ингээд гурилын үйлдвэрийн чанар шаардлагыг хангахгүй, зарагдахгүй юм болсон байна л даа. Тэгэхээр түрүүн бас Их Хурлын дарга хэлж байна. 100 мянган тонн улаан буудай хүнсний ангиллаас тэжээлийн ангилалд орсон гээд.

Нөгөө талд бас тэжээл хэрэгтэй байгаа малчид зөндөө байна. Тэгэхээр энэ дээр Хөдөө аж ахуйн яам яг ямар бодлого

барьж байгаа юм бол оо? Манай тариаланчид чинь бас л энэ Монголын ард түмнийг талх, тариатай байлгаж байгаа хүмүүс. Тэгээд давагдашгүй хүчин зүйлээс болоод бас хүнд байдалд орчихсон байна. Тэгэхээр энэ дээр яг явуулж байгаа нарийн бодлого байгаа байх гэж найдаж байна. Энэ талаар сонсмоор байна.

Г.Занданшатар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун хариулна.

Х.Болорчулуун: Ундрaм гишүүний асуултад хариулъя. Энэ жил улсын хэмжээнд сүүлд яг авсан ургацын хувьд сайн ургац авсан, ургац алдаагүй. Сүүлийн 9 жил аваагүй ургац авсан. Нэгж га-аас 14 центрийн ургац авсан байгаа. Гэхдээ улаан буудай гэхэд 435 мянган тонн, гэхдээ бас 9 сарын үргэлжилсэн эхний хэдэн хоногийг олон хоногийн борооны улмаас тэжээл рүү ангилал доошоо буурч, хүнсний улаан буудайнд шилжсэн байгаа. Энд бол 100 орчим мянган тонн улаан буудай шилжсэн гэсэн ерөнхий судалгаа дүгнэлт гараад байгаа. Одоо 30 хувь нь гэсэн үг л дээ. Эндээс тэжээл үйлдвэрлэгдэж байна.

Ер нь газар тариалангаа дэмжих бодлогыг яам явуулж байгаа. Урьд өмнө хямдыг нь хямдыг нь гээд гаднаас намрын ургацтай зэрэгцүүлээд будаа оруулж байгаад газар тариаланчдыгаа хүнд байдалд оруулдаг байсан. Ялангуяа 20-21 оны өвөл 220 мянган тонн будаа буюу гаднаас нийт гурил хийх будааныхаа 70 хувийг гаднаас оруулж ирж нөөцөллөө гэсэн байдлаар яахад газар тариаланчиддаа нэлээн хүнд цохилтыг өгсөн байгаа. Тэр эдийн засгийн цохилт бол өнөөдрийг хүртэл бас сайн сэргээгүй байгаа. Үүний улмаас тарих талбайн хэмжээ нь буурч эхэлсэн. Хэрвээ бид нар дотооддоо тариалан үйлдвэрлэхгүй бол хоолоороо стратегийн бүтээгдэхүүнээ гаднын хараат болно.

Өнөөдөр ОХУ ч гэсэн юу нөөц нь 10 саяд тонноос доош орж ирвэл гадагшаа гурил будаа экспортлохгүй гэсэн Засгийн газрын шийдвэр гарсан байна лээ. Тэгэхээр бид нар яг цагаа тулахаар бол аль ч улс орон нөгөө амь амиа бодно гэгчээр л өөрийгөө л бодно шүү дээ. Тэгэхээр бид дотооддоо бол стратегийн бүтээгдэхүүнээ сайн үйлдвэрлэдэг, тэрийг дэмжих бодлого байх хэрэгтэй. Гэхдээ чанаржуулагч улаан буудайг бол тодорхой хэмжээгээр квотоор оруулж ирнэ ээ, тийм. Тэгж байж бас энэ нэг чанарт тэнцэхгүй улаан буудайгаа ч гэсэн холих байдлаар энэ гурил үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжих ийм бодлоготой ажиллаж байна гэж хэлье.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Зочид танилцуулчихъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрaм, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг явж байгаа шүү.

Б.Баттөмөр: Энэ өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой асуудлуудыг яах вэ, жил бүр ингээд ярьдаг. Энэ жилийн хувьд бас онцгой байгаа юм байна. Шаардагдах арга хэмжээнүүдийг авах юм байна гэж ингэж ойлгож байна. Ер нь энэ том зургаар нь энэ Монгол Улсын хөгжлийн энэ өвөлжилттэй холбоотой, хөдөөгийн хөгжилтэй холбоотой асуудлуудыг том зургаар нь л авч үзэх ёстой юм байгаа юм л даа. Дэлхий нийтээр гандаж байна гэж байгаа юм. 2,5 хэмээр дулаарах юм бол олон хот

далайн ёроолд орно гээд л ингээд байгаа юм. Манайх чинь 4,2-5,2 хэмээр дулаарчихсан явж байгаа шүү дээ. Тэгээд ийм нөхцөлд бол энэ цөлжилт, ган гэдэг юм л үүсээд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ юуг хэлэх гэж байна гэхээр энэ Монголын бүх газар, бүх ус бол төвийн бүх ус бол Сэлэнгэ мөрөн гээд Байгальд цутгачихдаг. Зүүн тийшээгээ Хэрлэнд цутгаад Далайн нуурт аваачаад Хятадад нийлүүлэгчдэг. Эд нар дээрээ энэ хөв цөөрөм байгуулъя гэдэг юмыг л их олон жил яриад л ерөөсөө ажиллуулахгүй байгаа. 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд миний санаачилгаар ингэж яг оруулсан юм. Төсөв дээр бол юу ч байхгүй. Тэр гаднын зээл тусламжаараа хийх нь ямар юм байдаг юм. Төсөвт бол юм байхгүй. Тэгээд энэ юу вэ гэхээр энэ Гэгээ нуур гэж тэр Тайшир уулсын цахилгаан станцыг байгуулсан тэр орчин үнэхээр бидэнд оруулж байгаа шүү дээ. Тэнд бол усны шувуу цугладаг болчихсон, загас үржчихсэн, маш их хур тунадас ордог болчихсон, экологийн маш сайн орчин бүрдсэн байгаа шүү дээ. Тэгээд ийм туршиллагуудыг л энэ гол мөрөн дээрээ энд хөв цөөрмөө байгуулъя. Шаардлагатай бол тэр хөв цөөрөм дээрээ бол УЦС байгуулчих. 20-30 цэг дээр УЦС том цахилгаан станцууд, том жижгийг байгуулах боломж байдаг гэж ингэж сонсож байсан. Тэгээд энэ асуудлаар бодмоор байна л даа. 1 дэх асуудал.

2 дахь асуудал энэ малын өвчлөл. Одоо энэ чинь энэ судалгаан дээр бол 637 өрхийн 276 мал өвчтэй, тэр Африкт гардаг өвчин хуртэл Монголд л гардаг юм байна л даа. Тэгээд малаа эрүүлжүүлэх чиглэлээр ер нь ямар юмнууд хийгдээд байна. Юу хийгдэж байна? Энэ их чухал асуудал шүү. Ер нь гадагшаа мах экспортолж л байгаа юм байна. Тэгэхдээ манай Монгол малын махыг өвчтэй гээд, тэр эрсдэлтэй ангилалд нь оруулчихсан байдаг юм байна лээ.

Энэ манай малчид байгалиас хэт хамааралтай байгаа. Өвс ургавал мал нь өнтэй өвөлжинө, өвс ургахгүй бол

байхгүй. Тэгэхээр үүнийг цаашидаа эрчимжүүлэх асуудал хамгийн чухал бодлогын асуудал. 21 дүгээр зуунд манай энэ малчдын амьдрал ер нь ямар байх ёстой юм бэ? Энэ чинь ОУБ-ын гаргасан судалгаагаар ядуурал хотынхоос хөдөөгийнх нь 4 дахин их байна. Өвчлөл нь 1 дахин ихсэх ийм магадлалтай гээд гарчихсан байгаа. Тэгээд ер нь энэ хэтийн чиглэлдээ ер нь юу бодож байна? Юу бодох юм 21 дүгээр зуунд малчид ингээд гэртээ ингээд иймэрхүү яг ийм нөхцөлд байх уу? Ямар бодлого байдаг юм бэ? Малчдын амьдралыг тэр чанарыг дээшлүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг ашиглаж малчдадаа туслах, дэмжих энэ чиглэлийн бодлогууд ер нь ямар юм байдаг юм бэ?

Сүүлчийн асуулт энэ эрчим хүчтэй холбоотой. Суурилагдсан хүчин чадлаасаа 6-7 хувь илүү байгаа юм. Чойжилсүрэн сайд аа, та эхний 10 сарын байдлаар таны гаднаас авч байгаа эрчим хүч 22,5 хувиар нэмэгдчихээж. Энэ юунаас болж байна? Нөгөө Бөөрөлжүүт, нөгөө энэ Тавантолгойн станцуудын чинь тендерүүд нь юу болж байна? Дулаан бол энэ дээр ч үсэг алга. Суурилагдсан хүчин чадлаасаа 7, 8 хувиар давчихсан байгаа. 480-аад аж ахуйн нэгжүүд дулааны техникийн нөхцөл авахаар хүлээгдэж байгаа. Энэ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулах уу? Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Баттөмөр гишүүн ээ, энэ өнгөрсөн жилтэй харьцуулахад 2023 онд импортолсон цахилгаан эрчим хүчний хэмжээ нэмэгдсэн. Та зөв ярьж байна. Манай хэрэглээ нэмэгдээд байна. Өнгөрсөн жил жишээлбэл чадлын хувьд хамгийн дээд талынх нь 84мвт-аар нэмэгдэж байсан бол сая 11 сарын 23, 24-ний өдрүүдэд тэр өнгөрсөн жилийнхээ мөн үетэй харьцуулахад 207, 203мвт-аар нэмэгдэж байгаа.

Тийм учраас энэ чадлын хэрэглээ ч нэмэгдэж байгаа, энергийн хэрэглээ ч нэмэгдэж байгаа учраас Оросын холбооны Улсаас импортлож байгаа эрчим хүчний хэрэглээ бол нэмэгдсэн нь үнэн. Гэхдээ мөнгөн дүнгээр бол жоохон хэмнэсэн. ОХУ-д рублийн хани жooхон суларсантай холбоотой. Мөнгөн дүнгээрээ хэмнэсэн, биет хэмжээгээр бол нэмэгдсэн үнэн.

Бөөрөлжүүтийн цахилгаан станц 2024 оны 3 дугаар улиралдаа багтаж эхний 150, 1 дүгээр блок 150мвт-ыг ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй. 2025 оны 2 дугаар улиралдаа багтаж 2 дахь 150 блокыг ашиглахаар ийм хувийн хэвилийн цахилгаан станцын ажил сайн явж байгаа.

Тавантолгойн цахилгаан станцыг 300мвт-ын хүчин чадалтайгаар тендэр зарласан. 7 сарын 27-ны өдөр 2 оролцогч орж ирсэн. Харамсалтай нь энэ 2 оролцогч маань хоорондоо шүүхийн маргаан үүсчихсэн, шүүх дээр асуудал явж байгаа. Иймэрхүү байдалтай байгаа.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын тухайд зээлийн тусгайлсан хэлэлцээрийг байгуулаад дуусаж байна. 2024 оны 3 дугаар сараас эхлээд ажлыг эрчимжүүлэх талаар гүйцэтгэгч компанитай бид нар өдөр тутам харилцаатай явж байгаа. Иймэрхүү байна.

Дорнодын цахилгаан станц 50мвт-ын ашиглалтын өргөтгөл энэ ондоо бараг орж чадахааргүй болж байх шиг байна. 2024 оны 1 дүгээр улиралд ашиглалтад авахаар төлөвлөж байна. Нэг дэх өдөр яг газар дээр нь манай дэд сайд, манай Бодлогын хэрэгжилтийн газрын дарга Насантогтох дарга энд сууж байна. Энэ 2 яг газар дээр нь очиж үзэхээр ингээд төлөвлөөд өчигдөр бид нар уулзалтыг хийсэн, гүйцэтгэгч компанитай, иймэрхүү байдалтай байгаа.

3 дугаар станц, 4 дүгээр станц, 2 дугаар станцууд хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа. Өвөлд эрчим хүчний салбар энэ жилдээ бэлтгэл ажил 97 орчим хувийн гүйцэтгэлтэй бэлэн болсон байгаа.

Г.Занданшатар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун. 89. Мал эмнэлгийн газрын дарга.

А.Нарантуяа: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Ингээд Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд бол 5 гоц халдварт өвчин, вирусээр үүсгэгддэг 5 гоц халдварт өвчин эргэлддэг. 1 дүгээрт нь шүлхий, бог малын мялзан, сүүлд шинээр гарсан арьс товруутах өвчин, гахайн африкийн мялзан, хонины цэцэг гээд. Энэ 5 өвчнөөс нэг өвчний вакциныг л Монгол Улс Био үйлдвэрлэлдээ үйлдвэрлэж байгаа. Хонины цэцэг өвчнийг. Бусад төрлийн вакциныг бол гадаадын үйлдвэрлэгч орноос худалдан авдаг.

Тэгээд та бүхэнд бас тоон мэдээ танилцуулъя. 22 оны 01 сарын байдлаар 16 аймгийн 91 сумд 151 голомт. Энэ бол шүлхий өвчин голомтлоод, нийтдээ 204 сумд 461 голомт байсан. Одоогийн байдлаар 23 онд халдварын голомт бүрэн байхгүй гэсэн мэдээллийг бол Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгуулагад мэдээлсэн байгаа. Тэгээд олон улсын худалдааны хорио цээрт яаралтай мэдээлэх 2 гол өвчин бол бог малын мялзан, шүлхий өвчин байгаа. Бог мал малын мялзан өвчин болохоор одоогоор Сүхбаатар аймгийн Онгон, Баяндэлгэр, Өвөрхангай аймгийн Сант, Баянгол сумд хязгаарлалтын дэглэм дэгдсэн. Ерөнхийдөө бол Булган аймагт 1 тохиолдол илэрсэн. Тэгээд энэ өвчнөөр бол эрсдэл 1 өндөр байна. Яагаад гэхээр шилжилт хөдөлгөөн, өвлийн энэ нөхцөл байдалтай холбогдуулаад шилжилт хөдөлгөөн ихсээд, малын өвчин дахин дэгдэх аюултай учраас УОК-т бид нар яамны зүгээс болон Мал эмнэлгийн

ерөнхий газраас танилцуулаад тэмдэглэлд тэмдэглүүлсэн байгаа.

Мөн үхрийн арьс товруудах өвчин бол Дорнод аймгийн Чулуун хороотоор дамжиж орж ирээд энэ жил бол үсрээд Булган аймгийн Сэлэнгэ сумд гарсан. Тэгэхээр энэ өвчний магадлал эрсдэл бол бас Монгол оронд байгаа. Тэгээд өнөөдөр бол ерөнхийдөө Мал эмнэлгийн ерөнхий газар өвчний нөхцөл байдлыг хяналтдаа авсан учраас харилцагч орнуудын хувьд хэдийгээр бид нар Дэлхийн мал амьтан, эрүүл мэндийн байгууллагад эрүүл гэсэн статусаа аваагүй ч гэсэн бид нар бол 2 орны мал эмнэлгийн байгууллагын хооронд гэрээ хэлэлцээр, протокол дээр тохирсон учраас өнөөдөр 70 мянган тонн мах гараад, дахиж авах эрсдэл юу хүсэлт их ирж байгаа. Тэгээд тодорхой мэдээллийг бас Мал эмнэлгийн ерөнхий газраас танд танилцуулж болно. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууя. Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Асуусан асуултаасаа хэд хэдэн асуултууд хариулт авсангүй. Тухайлбал 21 дүгээр зууны энэ зуунд энэ Монголын малчид ер нь амьдрал ямар байх ёстой, ямар хэв маягтай байх ёстой юм бэ? Яг өнөөдрийнх шиг ингээд байх уу, яах вэ. 21 дүгээр зуунд амьдарч байна шүү дээ. Шинжлэх ухаан технологийн ололт. Яг энэ яаж амьдрах ёстой юм бэ гэсэн юман дээр би хариулт авч чадахгүй л байна л даа.

Дараагийн асуудал энэ хөв цөөрөмтэй холбоо. Монгол Улс газрын нөгөө гадаргуу дээр өндөр байрладаг, бүгд гадагшаа урсаад явж байна. Монголдоо энэ усаа үлдээе ээ л гэсэн ийм л юм л яригддаг. 30 жил яригдаад байгуулсан тэр Гэгээн нуурыг л нэг байгуулсан, өөр юм байхгүй. Одоо энэ Эрдэнэбүрэн дээр нэг байгуулагдаж магадгүй. Тэгэхээр энэ чиглэлд юу боддог юм бэ, манай ХААЯ, энэ усны бас бодлого

бол танайд байдаг юм байгаа биз дээ? Энэ дээр ямар бодлого байна? Энэ дээр нэмж хариулж өгөөч.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Би Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Баттөмөр гишүүн 21 дүгээр зуунд яг энэ чигээрээ мал махаа бэлтгээд, борлуулаад ингээд байх юм уу гэж асууж байна. Ямар өөрчлөлт оруулах вэ гэж. Ер нь ингээд бэлчээрээр явуулж байгаад урсгалаар нь явуулж байгаад экспортод гаргана гэдэг асуудал үнэхээр олон улсад үндсэндээ хориотой байдаг. Яагаад гэвэл бэлчээрийн мал тэр чигээрээ бол бас хяналтад бүрэн орох чаддаггүй. Тийм учраас өнөөдөр манайх махаа урд хөршид ялангуяа чанаж гаргаж байна шүү дээ. Энэ чанаж гаргаж байгаа мах ч гэсэн лангуун дээр байгаа жижиглэнгийн махнаас хямдхан байна. 3,5-4,5 доллароор гаргаж байна.

Бид тэгэхээр цаашидаа яг олон улсын стандарт шаардлагыг хангасан мах экспортод гаргая гэвэл мөн олон улсын импортлог ... /минут дуусав/

Г.Занданшатар: Болорчулуун сайд гүйцээж хариулъя.

Х.Болорчууун: Олон улсын шаардлагаар мал махаа гаргая гэвэл юм уу импортлогч улсуудын шаардлагын дагуу мал махаа гаргая гэвэл эрүүл байлгах ёстой. Ийм учраас мал амьтны дэглэм бүхий эрүүл бүс мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс мөн хамгаалагдсан аж ахуйг байгуулж байж үнэ цэнтэй. 2 дахин үнэтэй 7-8 долларын ийм махыг бол гадагшаа зах зээлд гаргах ийм боломжтой. Энэ бол олон улсын шаардлага нь ийм байдаг.

Тэгэхээр энэ тал дээр бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бодлогоор ажиллаж байгаа. Одоо хуульдаа бас өөрчлөлт оруулчихлаа. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд

өөрчлөлт орууллаа. Мал, амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх энэ хуульд бас өөрчлөлт орууллаа. Мөн стандартыг хамгаалагдсан аж ахуйн стандартыг батлуулах гэж байна. Энэ байдлаар бас бодлого болгон ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Мөн Засгийн газрын тогтоол гарсан. Энэ дээр бас 5, 6 аймгийг мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс болгохоор зарласан. Энэ хавраас эрчимтэй ажил эхэлнэ ээ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол орны ихэнх нутгаар цасан бүрхүүлтэй болж, өвөлжилт хүндэрсэн ийм цаг үед УИХ дээр энэ өвөлжилтийн асуудлыг хэлэлцэж байна. Энд 2, гуравхан асуудал дээр бид анхаарлаа хандуулах ёстой. ЗГ, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, энэ чиглэлийн байгууллагууд гэж ингэж бодож байна. Малчдын махны асуудал. Мал борлуулах асуудал дээр онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Ялангуяа алслагдсан баруун аймаг түүний дотор Ховд аймагт энэ махны асуудал хамгийн хүнд. Энэ малчдын амьдралын эх үүсвэрт маш дарамт учирсан ийм байдал бий болж байгаа юм. Энэ зарим хүмүүс ийм нэг ноцтой асуудал яриад байх юм.

Энэ дулааны аргаар боловсруулсан мах боловсруулсан үйлдвэрүүд зээл өгье гээд байгаа юм. Энэ чинь дандаа цаана нь Хятад хүмүүс байгаа шүү дээ. Тэгээд энэ ямар бодлого явуулах гээд байгаа юм бэ. Үүний оронд энэ малчдынхаа махыг борлуулах дээр тодорхой ЗГ шийдэл гарга аа. Олон 10 мянган малаа нядалчихсан өнөөдөр аргаа алдсан энэ малчдын асуудал дээр тодорхой шийдвэр гаргая. Төр энэ дээр анхаарах ёстой гэж бодож байна. Энэ дулааны аргаар боловсруулдаг махны үйлдвэр явуулдаг нэг ч Монгол хүн байхгүй шүү дээ. Тэгээд Хятадуудыг ингэж бодлогын маягаар энд ярьж

орүүлж ирж байгаа нь харамсалтай байна шүү гэдгийг энд тэмдэглэж хэлье.

Дараагийн асуудал. Энэ бензин, шатахууны хомсдол өнөөдөр Монгол Улсад хамгийн аюултай асуудлын нэг болсон. Өвөлжилт хүндэрсэн байдаг, хөдөө орон нутагт шатахуун байхгүй ийм асуудал дээр, манай Ганбаатар сайд их ажиллаад байгаа. Олон талаас нь зүтгээд л байгаа, хөөрхий. Энэ хүнийг бас үгүйсгэхгүй. Тэгэхдээ энэ дээр энэ бид нар нэг тодорхой бодлого явуулъя. Өнөөдөр энэ иргэд шатахуун нөөцлөөд л байна гэж байна. Энэ үнэн л байх л даа. Тэгэхдээ энэ том том компаниуд чинь өнөөдөр ерөөсөө хөл гараа хөдлөхгүй байна шүү дээ.

Тэр Оросын хараат байдаг юм уу, яадаг юм. Энд энэ том том компаниуд ерөөсөө энэ Засгийн газартайгаа хамтарч ажиллахгүй байна, ард иргэдтэй хамт ажиллахгүй байна. Тийм учраас энэ бензин, шатахуун импортлодог тэр тусгай зөвшөөрлийг иргэд нь, аж ахуйн нэгжүүд нь энэ бензин шатахуун оруулж ирэхийг зөвшөөрье. Энэ төрөөс. Одоо Оросын нутаг дээр зөндөө олон тийм шатахуун хувь, хувьсгалаар оруулаад ирье гэсэн зөндөө иргэд байна шүү дээ. Энд нь чөлөөтэй оруулж ирье. Тэгээд л тэнд импортлогч орны тэр бичиг баримтыг нь үндэслэлээр оруулъя. Ингэж байж бид бүх олон талаар хамтарч ажиллаж шийдэх гэж боломж байна.

Нөгөө талаараа өнөөдөр энэ газар тариалангийн асуудал, малчдын өвөлжилтийн асуудал, гурил тэжээлийн асуудал онцгой асуудлын нэг болчихоод байна. Энэ гурил гурилан бүтээгдэхүүн, өвс тэжээл, энэ гаалийн татвар нэмэгдсэн өртгийн албан татвараа тэглэе. Ингэж байж бид нар энэ эрсдэлээс даван туулна шүү дээ. Ялангуяа энэ Аубакир гишүүн энэ тэр энд бас анхаарал хандуулаарай. Энэ баруун аймаг, Цагаан нуураар бид энэ гааль НӨАТ-ыг чөлөөлж, энэ гурил түүнчлэн

өвс, тэжээл оруулахад ЗГ энэ дээр шийдвэр гаргая, хамт. Ингээж байж бид нар орохоос биш бид энд нэг хөөрхий гээд л ийм юм яриад л хүн хүч чинь хүрэхгүй ээ. Хөрөнгө мөнгө чинь хүрэхгүй ээ. Энэтэй бол санал нэг байгаа. Үүнийг ЗГ яаралтай шийдэж, энэ эрсдэлээс гарах асуудал цаг үе болсон асуудал шүү гэдгийг энд хэлье.

Дээр нь энэ малыг эрүүлжүүлэх асуудал байгаа. Өнөөдөр энэ Болорчулууныг нэг ээмэг гээд л нэг шоолоод байсан чинь яг үнэн шүү дээ, амьдрал дээр. Энэ малаа эрүүлжүүлэхгүйгээр, малаа бүртгэлжүүлэхгүйгээр бид 1кг ч мах гаргаж чадахгүй шүү дээ. Олон улсын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12а, 12б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагчдадаа сурлага хөдөлмөр, спортын өндөр амжилт хүсэн ерөөе. Цагааннуур сумын.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн хэзээ ирж байна? Энэ ирцэд байхгүй байгаад байх юм, ирцэд байгаа юу, ирцэд байгаа юу? Ирцдээ бүртгүүл, ирцдээ бүртгүүл. 1 цаг 40 минут хоцорсон байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирцээ уншуул, картаа уншуул.

Жамбалын Ганбаатар сайд хариулна.

Ж.Ганбаатар: Адъяаа гишүүний асуултад хариулъя. Бензин, шатахууны асуудал бол байгаа, таны ярьж байгаа бол зөв байгаа, бензин шатахууны асуудал бол байна. Оросын Холбооны Улсын нийлүүлэлт бол хэвийн байгаа

шүү. Нийлүүлэлт бол хэвийн хэмжээнээсээ илүү нийлүүлж байгаа юм. Гэхдээ манай дотоод хэрэглээ бол өссөн байгааг бас Их Хурлын дарга бас сая хэллээ. Тэгээд энэ дээр ямар бодлогоор ажилласан юм бэ гэвэл бид 9 сард, 8 сард 140 мянган тонныг давж нөөцөлсөн. Тэгээд тэр 9 сарын 21-нд гарсан тэр тогтоол бид нарт мэдэгдэхгүй л дээ. Тэр тогтоол.

Дэлхий нийтэд тавьж байгаа тэр Оросын Холбооны Улсын дизель болоод 92-ын хориг, тэр л 21 хоногийн тэр бид нар огт нэг ч шатахуун бензин импортлоогүй, тэр нь тэрнээс л бид хүртэл гарахгүй байгаа. Үүнийг тэгээд ойрын хугацаанд гаргахын төлөө л явж байна. Та нийлүүлэлтийн асуудлыг бол Ганбаатарын тоог бол гаалийн юундаа тоотой мөргүүлээд харчхаж бол болно. 102 мянган тонн дизель түлш, 56 мянган тонн 92 орж ирсэн байна.

Монгол Улс ер нь ойролцоогоор нэг 3 мянган вагон сардаа бол хэрэглэж байгаа. Тэр тусгай зөвшөөрлийн хувьд бол тэр хамгийн гол тавигддаг шаардлага бол аюулгүй байдал шүү. Аюулгүй байдал. Аж ахуйн нэгжүүдэд хамгийн гол тавигддаг шаардлага. Тусгай зөвшөөрлийн хувьд бол. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн тоо бол их олон байгаа. Тэгэхдээ бас дуртай болгон нь тэгж хөрөнгө мөнгө болоод аюулгүй байдал талаасаа бол бас УУЯ бодлогын хувьд анхаардаг гэдгийг бас танд хариулъя.

Засгаас явуулж байгаа бодлого бол ганц Оросын Холбооны Улсаас биш ялангуяа уул уурхайн бүсийн хэрэглэгдэж байгаа энэ өсөн нэмэгдэж байгаа шатахууныг БНХАУ-аас нийлүүлэх бодлого барьж байна. Та бас сонссон байх. Сардаа 1, 2 гуравхан мянган тонныг авдаг байсан бол 31500, нэг сард 25000, 2 сард 20 мянга. Энэ тоонууд Засгийн газрын бодлогыг бас танд илэрхийлж байгаа байх гэж хариулъя. Дууслаа.

Г.Занданишатар: Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр өнгөрсөн жил өвөлжилт хүндэрсэн, өвөлжилт хүндэрсэн энэ хавар өвөл манай Шадар сайд Ховд аймагт очоод хэд хэдэн аймаг, сумуудаар яваад 20, 30, 20, 30 тонн тэжээл өгөөд тэгээд тэр 20, 30 тонн тэжээлээ буянтан өгч байгаа юм шиг өгчихсөн. Тэгэнгүүт цаана нь тэр 30 тонн тэжээлийг чинь сумын айл болгонд нэг ганцхан шуудай тэжээл очдог. Түүгээрээ хэдэн мал тэжээх вэ дээ. Ингээд дууссан. Тэгэхээр энэ дээр бас энэ жил бас нэлээн хариуцлагатай байж асуудалд хандахгүй бол болохгүй.

2017-18 оны шилжих жил өвөлжилт хүндэрсэн. Тэр жил яасан байна гээд өвөлжилт хүндрэх юм байна гээд Засгийн газраас 40 тэрбум төгрөг гаргаад 8 аймагт 5, 5 тэрбум төгрөгөөр ер нь бол ингээд тэжээл аваад нийлүүлээд, өөрөөр хэлбэл Ховд аймагт 14 мянган төгрөгийн үнэтэй тэжээл хивгийн тэжээл байна. Тэрийг бүтэн өвөлжингөө хаваржингаа нийлүүлэх юм бол 13 мянгаар нийлүүлэх юм бол эндээс зээл ав гээд. Ингээд тэрний дагуу нийлүүлээд тэр хаваржингаа хүмүүс малаа тэжээгээд ингээд ондоо сайн орсон ийм туршилага байгаа. Тийм учраас энэ тал дээр Шадар сайд бас хариулт өгөөд ямархуу арга хэмжээ энэ өвөлжилтийн бэлтгэл ажил хангаж юу яах вэ. Нөөцийн тэжээлээс бүх малчдыг бүгдийг нь хангах боломж ерөөсөө байхгүй. Татвар төлөгчдийн мөнгөөр бас ингэж хамаагүй зарцуулж болохгүй. Тийм учраас тэд нарт хямдхан тэжээл авчрах тэр боломжийг хангах талаар ЗГ ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдгийг бас 1 дүгээрт хэлээд өгөөрэй.

2 дугаарт нь, улаан буудай, гурил, тэжээл энэ тэр бүгдээрээ Оросын Холбооны Улсаас зөв зүгээр гарч байгаа. Харин гурил, наранцэцэгийн тос 2 ерөөсөө 0 хувийн татвартай гарч байгаа. Бусад бүх бараанууд бүгдээрээ онцгой татвартай гарч байгаа. Өөрөөр

хэлбэл, экспортын татвартай гэсэн үг. Жишээ нь улаан буудай өнөөдрийн байдлаар 4500 төгрөгийн рублийн нэг тонн татвартай байж байна. Тэрэнтэй адилхан өнөөдрийн байдлаар хивэг 5,5 хувийн экспортын татвартай байна, Оросын Холбооны Улсаас гарахад. Гурил тэгэхэд 0 байна.

Тэгэхээр ингээд би сарын өмнө хэлж байсан. Ховд аймгийн иргэд 120 мянган төгрөгөөр гурил идээд байна. Гэтэл Оросын Холбооны Улсаас 56 мянган төгрөгөөр гурил оруулж ирээд 1 дүгээр гурил оруулж ирээд өгөх боломж байна. Тэгээд өнөөдөр ингээд 56 мянга байсан чинь өнөөдөр 61 мянга болчихлоо, яагаад 61 мянга болчихож байгаа юм бэ гэхээр энэ рублийн ханиш 33 төгрөг байж байгаад 38 болчихож байгаа байхгүй юу. Тэгээд 1 шуудай гурил чинь мянган рубль гэхээр нэг 5 мянган төгрөгөөр нэмэгдчихэж байна. Тэгээд хүмүүс тэнд байна шүү дээ. Тийм ээ. 61 мянган төгрөгөөр гурил идэх боломжтой байж байхад яагаад ингээд энэ ЗГ энэ гурилын импортыг хаачхаад, өөрсдийнхөө өндөр үнэтэй гурилыг ид гэж ингээд дайраад байгаа юм бэ. Энэ чинь болохгүй шүү дээ.

Буудай бол жишээ нь энд Улаанбаатар хотод орж ирэх юм бол 1 тонн буудай 1150 төгрөгөөр орж ирж байна. Яагаад гэвэл экспортын татвар өндөр, Оросууд яаж байна гэх дээр аль болох эцсийн бүтээгдэхүүнээ татваргүй гаргана гэдэг ийм бодлого баримталчихсан юм байна. Тийм учраас нөгөө түүхий эд дээрээ дандаа онцгой татвар тавиад ингээд явж байгаа. Наран цэцгийн үр одоо юу байдаг юм, улаан буудай энэ тэр дээрээ. Тийм учраас эцсийн бүтээгдэхүүн болсон гурил нь ингээд яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод Алиакагийн 1 дүгээр гурил байна шүү дээ, тийм ээ, 62 мянган төгрөгөөр ирэх ийм боломж байна. Дээрээс нь нэг компаниуд нь жоохон ашгаа нэмэх байх. Ийм боломж байж байхад чинь Ховд аймагт яг адилхан үнээр очдог байхгүй юу даа. Наашаа 5 рублиэр вагоноор тээвэр хийдэг Ховд руу,

автомашинаар 5 рублиэр тээвэр хийдэг яг адилхан. Тэгээд ингээд өнөөдрийн байдлаар 61 мянган төгрөг, нэг ашгаа нэг гурил дээр нэг шуудай дээр 2 мянга, 3 мянган төгрөг л нэмдэг юм. Илүү нэмдэггүй юм. Тэгээд 65 мянган төгрөгөөр Ховдын иргэд Алиакагийн 1 дүгээр гурилыг идэх ийм бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун хариулна.

Х.Болорчулуун: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ялангуяа манай Ховд аймгаас сонгогдсон гишүүд бас баруун аймагт гурил энэ харьцангуй, бусад газраас үнэтэй байна гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэр үнэн. Баруун аймагт ялангуяа Хөвсгөл, Увсад гурилын үйлдвэрүүд байсан, хуучин. Одоо бол амаа барьчихсан байгаа, хаалгаа барьчихсан байгаа. Тэгэхээр төвийн болон зүүн аймгуудыг бодвол баруун аймаг 20 хувийн өндөр үнэтэй гурил хэрэглэж байгаа нь үнэн. 50 кг-ийн гурил Төвд болон зүүн аймгуудад 100 мянган төгрөг байхад, баруун аймагт 120 мянга байгаа, тийм. 25 кг-ийн гурил тэр хэмжээгээрээ 20 хувийн үнэтэй байгаа. Тэгэхээр бас үүнийг яам бас бодлогоор ярилцаж байна. Бид Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл энэ 7-нд хуралдана. Үүгээрээ бол бас баруун 3 аймгаар гурил оруулах асуудлыг бас бодлогын шийдвэрээ гаргах гэж байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ ажлын өндөр амжилтыг гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан.

С.Амарсайхан: Өнгөрсөн жил бас өвөлжилт хүндэрсэн. Гэхдээ бүр ялангуяа баруун аймгуудад. Тэгээд баруун аймгуудад болон говийн бусад энэ зүүн аймгуудад ч гэсэн нөхцөл байдал хүндэрсэн. Тэр үеэр Ховд аймагт бид бас 800 тонн тэжээл нийлүүлсэн. Энэ жил ч мөн ялгаагүй хүндэрч байгаа аймгуудад өвс, тэжээлийн үнийг хямд, хүртээмжтэй байлгах тал дээр УОК, Хүнс, хөдөө аж ахуйн яам, холбогдох байгууллагууд аймаг орон нутагтай хамтраад нэлээн нарийн тооцоо судалгаануудыг гаргаж байгаа. Ялангуяа тэжээл манай улсын хэмжээнд хэчнээн тонн байгаа юм. Аль аль аймагт хэчнээн хэмжээтэй байгаа юм. Үнэ өртгийг яаж малчдад хүндрэлгүйгээр, дарамтгүйгээр түргэн шуурхай хүргэх, тээвэрлэлтийн зохицуулалтуудыг нь хийх юм гээд нэлээн ажлууд хийгдэж байгаа. Тэгээд ирэх 7 хоногт Засгийн газрын хуралдаанаар бас тодорхой асуудлууд орно. Зөвхөн тэжээлийн ч гэлтгүй бас энэ гурилын үнийн асуудлууд яригдаж байгаа.

Тэгэхээр энэ гурилын экспорт, импорттой холбоотой тодорхой бодлого шийдвэрүүдийг гаргаж, үнэ өртгийг бууруулах, хангалт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, махны хангалт, нийлүүлэлт, худалдан авалтын үйл ажиллагаа дээр ч гэсэн мах боловсруулах үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийг малчидтай холбож, аймаг орон нутгаар нь бүсчилсэн, явуулын маягаар худалдан авалт, ханган нийлүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, үнийг бууруулахгүй байх тал дээр зохион байгуулалтын ажлууд болон зарим санхүүгийн эх үүсвэрүүдийг хүртэл хангах тал дээр ажлууд судлагдаад явж байгаа.

Ирэх 7 хоногоос бас Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тодорхой шийдлүүдийг гаргах тал дээр Болорчулуун сайд бас холбогдох

байгууллагуудтай ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Амарсайхан сайд аа. Танай Цаг уур шинжилгээний газрын даргыг өчигдөр залгаад утсаар холбогдоогүй. Өнөөдөр, өчигдөр 2 би өөрөө залгаад холбогдсонгүй. Энэ малчдад энэ өвөлжилтийн нөхцөл байдлын талаар энд мэдээлэл хийж өгч байвал сайн байгаа. Асуултууд хариулахад. Тийм учраас яаралтай дуудаж энэ өвлийн цаг агаарын нөхцөл байдлын талаар энэ малчдад ниргэсэн хойно нь хаширдаг биш, ниргэсэн хойно нь хаширдаг биш энэ цаг агаарын төлөв байдал, гэнэтийн цочир шуурганы талаар мэдээлж байгаа мэдээллийн цахим системийн талаар, энэ нөхцөл байдлынхаа талаар мэдээлэл өгч баймаар байна. Яаж малчдад энэ мэдээллийг өгч байх юм. Үүнээс чинь болоод олон малчид төөрч, амь насаар эрсдэж байна шүү дээ. Болсон явдлын хойно биш өмнө нь урьдчилан сэргийлэх асуудал чухал. Тэгээд 2 өдөр холбогдох гээд дөнгөж сая би холбогдлоо, ир гэж дуудлаа. Тэгээд ирж мэдээлэл өгч.

Хамгийн гол нь энэ дэлхий даяар цаг агаарын урьдчилан прогнозын чанар сайжирчхаад байхад үүнийг урьдчилж мэдээлдэг, энэ 12 сард юу болох гээд байгаа юм, 1 сард юу болох гээд байгаа юм, хэдийд шуургатай юм, малчдадаа мэдээлж байх хэрэгтэй шүү дээ. Хэзээ хотлуулах ёстой юм. Тийм учраас энэ талаар саяын асуултууд чинь бас уялдана.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Пүрэвдорж: Оросын Холбооны Улсын үнэ, татвартай холбоотой мэдээлэл бол 7 хоног тутам надад ирж байгаа. Ер нь би бас нөгөө Махны холбооны тэргүүний хувьд энэ талаар бас санаа зовдог. Тэгэхээр өнөө ер нь бол 3, дөрөвхөн бүтээгдэхүүн эцсийн бүтээгдэхүүн. Тийм ээ. Экспортод татваргүй байгаа. Тэрний нэг нь бол

гурил наран цэцгийн тос байхгүй юу даа. Бусад нь бол бүгдээрээ татвартай байгаа. Жишээ нь хивэг өнөөдрийн байдлаар 5,5 хувийн экспортын татвартай байна. Тэгээд өнөөдрийн байдлаар бол 1кг хивэг 8 рублийн үнэтэй байна.

Тэгээд дээрээс нь тээврийн зардал 5 рублиэр Ховдод ирнэ. Мөн түүнчлэн 5,5 хувийн экспортын татвараа энэ тэр нэмээд, ингээд Монгол Улсын гаалийн татвараа нэмээд, тэр машин нь Оросын холбооны машин шууд Ховдод буулгачихдаг юм. Ингээд яг 15 мянган төгрөгөөр 1 шуудай хивэг, 1 шуудай хивэг Ховд аймагт ирж байна. Манай Ховдын бизнесменүүд бол 1 шуудай хивэг дээр 1 мянган төгрөг л нэмдэг ... /минут дуусав/

Г.Занданиатар: Үг хэллээ.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Л.Энх-Амгалан: Би сая тойргийнхоо 22 сум дээр. Улсын Их Хурлын гишүүний хувиар үг хэлж байна. Тийм. 22 сумаар явж иргэд сонгогчидтой уулзаж, энэ өвөлжилтийн байдалтай бас уулзалтууд хийгээд ирсэн. Тэгээд Улсын Их Хурлын даргад бас талархаж байна. Яг энэ өвөлжилтийн асуудлаар цаг алдалгүйгээр нөгөө ниргэсэн хойно нь хаширахаг биш яг цаг алдалгүйгээр өнөөдөр ингэж сонсож, авах арга хэмжээнүүдийг бас Засгийн газарт үүрэг чиглэл болгож байгаад би их талархаж байгаа юм.

Тэгээд мэдээж гол асуудал нөгөө онигоо байдаг. Нөгөө өвөл болохоор хүйтэн болно гэдэг шиг энэ жил бол үнэхээр зуд болж байна. Энэтэй бид нар хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгээд мэдээж Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа, Онцгой комиссоос хэрэгжүүлж байгаа манай Шадар сайдын манлайллын доор хэрэгжүүлж байгаа сайн арга хэмжээнүүд байна. Сайн арга хэмжээнүүд.

Сая малчдын дунд яригдаж байгаа асуудал энэ тэжээл, хивгүүдийг экспортод гаргаад байна. Үүнийг түр зогсоож өгөөч ээ гэсэн. Үүнийг зогсоочихлоо, бид нар. Арьс шир үнэд орохоо больсон. Ингээд энэ экспортын хориг байсан гэдэг асуудал байсан. Энэ экспортынхоо хоригийг бид нар зогсоочихлоо. Сая бол Болорчулуун гишүүн нэг малчдын чихэнд чимэгтэй үг дуулгаж байх шиг байна. Хөдөөгийн иргэдэд. Гурилынхаа үнийг чөлөөлнө өө, импортыг оруулж ирнэ ээ, зөвшөөрнө өө гэж. Өрсөлдөөнийг үүсгэнэ ээ гэдэг чимэгтэй үг хэлж байх шиг байна, тийм ээ. Гэх мэтчилэн. Зөвхөн баруун аймаг биш ээ бас энэ чинь бүх аймгуудад байгаа асуудал байгаа юм. Тэгэхээр иймэрхүү чимэгтэй юмнууд байна. Гэлээ гэхдээ бид нар бас нэг ингээд тайвширч болмооргүй байна.

Ингээд яг энэ отрын бүс нутгийн асуудлууд, энэ отор нүүдэл хийж байгаа, аймаг дотроо отор нүүдэл хийж байна. Завханаас Хөвсгөл рүү орж ирж, отор нүүдэл хийж байна. Тэгэхээр энэ отор нүүдэл хийж байгаа, отор нүүдэл хүлээж авч байгаа энэ аймаг, сумын энэ төлөвлөлтүүдийг их сайн хиймээр байна, Шадар сайд аа, маш сайн хиймэр байна. Тэгээд үүнийгээ дагасан энэ өвс, тэжээлийн энэ асуудлуудыг, хангалттай асуудлуудыг нь малчдад их тодорхой тоонуудыг бид нар хэлмээр байна. Жишээ нь сая Болорчулуун сайд хэлж байна шүү дээ. Энэ намар улаан буудай нь 100 мянган тонн улаан буудай тэжээлийн ангилалд орчихсон, 100 мянган тонн. Одоо тэгвэл үүнийгээ ерөөсөө аймаг, аймагтаа хуваарилаад, тэгээд л өгчихмөөр байна. Тэгээд иргэд энэ малчид хойтон намар 1 дүгээрт, хөнгөлөлттэй үнийн асуудал ярьж байгаа юм. 2 дугаарт, төлбөрийн нөхцөлийн асуудал ярьж байгаа юм. Тэгээд яг үнээ яг ийм үнээр өгнө, төлбөрийн нөхцөл нь яг ийм байна гээд. Ингээд асуудлыг их ойлгомжтой болгоод өгөх юм бол бас их том дэмжлэг болохоор байна, Шадар сайд аа.

Тэгээд эрүүл мэндийн асуудал дээр яг үндсэндээ энэ отор нүүдэл хүлээж авч байгаа энэ сумууд, энэ багийн эмч нарын ачаалууд бас их хүндэрсэн байна. Үнэхээр хүрэлцэхгүй байна. Ганц муу мотоциклтой хаанаа ч явж хүрч чадахгүй. Тэгээд эмийн эргэлтийн сан гэдэг юм нь байхгүй болчихсон, өртэй байдаг юм байна шүү дээ, дандаа, тэр эмийн эргэлтийн сан нь дандаа өртэй байдаг, эм байхгүй, тариа байхгүй ийм болчихсон байгаа. Тэгэхээр Чинзориг сайд бас үндсэндээ сая 50 сумыг нэлээн онцгойлон анхаарах. Тэр унааны асуудлууд, эм тарианы асуудлууд, эмч нарын магадгүй эмч нарыг зохион байгуулж энэ юу зуд турхан багатай байгаа багийн эмч нарыг тэр зуд турхантай байгаа, дахиад зуд турхнаас орж ирж байгаа тэр хөдөө өөр аймгаас орж ирж байгаа, өөр сумаас орж ирж байгаа, тэр ачаалал үүсгэж байгаа тэр сумууд дээр бид нар ингээд тийм зөв зохион байгуулалтууд хийх ийм зайлиггүй шаардлагууд үүссэн байна л гэж хараад байгаа юм.

Тэгээд энэ мал эмнэлгийн асуудлыг бид нар ер нь тогтолцооны хувьд нэг харахгүй бол Болорчулуун сайд аа. Малаа эрүүлжүүлж байж экспортод гаргана гэсээр байгаад нөгөө бухын доодхыг харж үнэг турж үхнэ гэдэг шиг л хэдэн малчид маань үнэгүй мал малладаг л болчихоод байна шүү дээ. Тэгэхээр мянга гаруй нэг хувийн малчид, хувийн мал эмнэлгийн асуудал байна. олон жил энэ тарифаар ингээж санхүүжүүлж үйлчилгээ хийж явна гэсээр байгаад эд нар маань ингээд хад мөргөөд уначихсан. Энэ жил нэг тариф нь жаахан нэмэгдсэн юм шиг байна. Гэлээ гэхдээ энэ мал эмнэлгийн асуудал малын эрүүл мэндийн асуудлыг нэгэнт л мал төрд байгаа учраас энэ 1 мянга гаруй малын эмч нарыг ядахдаа саяын нөгөө мал юуных малчдын НДШ-ийн 50 хувийг төр 5 жил хүртэл даахаар болж байгаа шүү дээ. Тэр хүрээнд хамруулж өгөхгүй бол энэ чинь яг л аль ч малчдад үйлчилгээ хүргэдэг ийм хүмүүс байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлуудыг бид нар энэ

цогцоор нь оруулж ирж шийдэх ийм асуудлууд байна.

Мэдээж Ганбаатар сайдын хувьд бол би ойлгож байна ... /мминут дуусав/

Г.Занданшатар: Тэгээд ер нь Засгийн газрын хуралдаан дээр өвөлжилтийн асуудлаа сайн ярьцааж бай. Тэгээд энд, тийм. Сайнбуянгийн Амарсайхан сайд товч хариулъя.

С.Амарсайхан: Энх-Амгалан сайдын сая ярьсан асуудлууд чухал. Энэ отор нүүдлээр явж байгаа малчид, иргэдийг аймаг, сум дамжихад нь ямар нэгэн байдлаар саад тотгор учруулахгүйгээр гарч байгаа, орж байгаа бүртгэл хяналтыг сайн хийж, малын хөлийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээс гадна малын мал сүргийн хорогдлоос урьдчилан сэргийлэх, малчдын эрүүл мэнд, тусламжийн үйлчилгээг хангах, хоол хүнс хүргэлт, нийлүүлэлтийн төдийгүй энэ тээвэрлэлтийн асуудал дээр ч гэсэн анхаарах.

Ямар байдлаар ажиллахыг УОК-оос аль эрт аймаг, орон нутгийн удирдлагууд, холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар болгож, бас төлөвлөлтийг нь хийлгэж, зохион байгуулалтаар нь хангаж, УОК-ын дэргэдэх шуурхай штабаас бас хяналт тавьж ажиллаж байгаа.

Малчид отор нүүдлээр явахад бас хоорондоо аймаг, орон нутаг нь хүлээж авна, авахгүй гэдэг эсвэл бэлчээртэй холбоотой маргаан үл ойлголцол гардаг. Ийм зүйл байдаг. Тэгэхээр энэ дээр маш нарийн зохион байгуулалттай цаашид анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Аймаг орон нутгийн удирдлагууд дээр ч гэсэн үүнийг бас зохион байгуулалтыг нь хянаж ажиллаж байгаа.

2 дугаарт, энэ бусад эрүүл мэнд, энэ мал эмнэлгийн салбарын үйл ажиллагаа дээр үнэхээр анхаарал хандуулахаасаа өөр аргагүй болсон. Мал эмнэлгийн ажилтан, албан хаагчдын

дутагдалд орсон, зохион байгуулалт бас тийм ч сайн биш байгаа. Нөгөө талаасаа анхаарах асуудлууд бас аймаг, орон нутагт бий. Хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, цаашидад энэ малын тарилгыг хүртэл мэргэжлийн түвшинд хийдэг байхгүй бол буруу зөрүү хийхээс эхлээд ийм асуудлууд байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ дээрээ бас анхаарч ажиллаж байгаа гэж бодож байгаа.

Ер нь зүгээр бид ингээд нэг өвөл асуудлуудыг яриад дуусах биш цаашидаа энэ цаг уурын өөрчлөлттэй холбоотой өсөн нэмэгдэж байгаа гамшиг, аюулын тоо улам нэмэгдэнэ. Дэлхийн энэ гамшигийн эрсдэлийн үнэлгээнд 2030 он гэхэд өнөөдөр тохиолдож байгаа гамшигийн хэмжээ 40 %-аар нэмэгдэнэ гэж байгаа юм. Тэр дундаа цаг уурын өөрчлөлтөөс үүдсэн аюулт үзэгдлүүд 3 дахин нэмэгдэнэ гэж байгаа юм. Энэ өнгөрсөн зун бидний тулгарсан, бидэнд тулгарсан энэ үер усны асуудлуудаас эхлээд одоо энэ зуд турхны асуудлууд гээд улам жил ирэх тусам л хүндэрнэ.

Тэгэхээр энэ цөлжилт, хуурайшилтыг бууруулах, бэлчээрийн доройтлыг багасгах, нүүдлийн МАА-гаа эрчимжсэн МАА-тай хослуулж цааш нь авч явах, тэгээд аймаг, орон нутагт тэжээл энэ бордоогоо тарьж ургуулахад нь Хүнс, хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам бас хамтарч судалгаа хийх асуудлуудыг хийж байгаа. Үүнийгээ бас эрчимжүүлэх шаардлагатай байгаа гэдгийг бас хаана хаана ойлгож байгаа учраас энэ чиглэлийн ажлуудаа ер нь энэ цаг уур, орчны шинжилгээний байгууллагын үнэлэлт дүгнэлтүүд, мэргэжлийн байгууллагын зөвлөмж зөвлөгөөн дээр үндэслээд, эрдэмтэн судлаачдынхаа оролцоотойгоор хийж бид энэ МАА, ХАА-н салбар байгаль орчны асуудлуудаа цогцоор нь харахгүй бол тэр хүрээнд бас малчдадаа зөвлөж, тусалж энэ өвөлжөөгөө өөрчлөх, шинэчлэх, цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдуулж эрсдэлийг

багасгах ажлуудыг хийх зайлиггүй шаардлага бас байгаа.

Онцгой байдлын байгууллагын дэргэдэх Гамшигийн судалгааны үндэсний хүрээлэн дээр зарим судалгаа, төсөл, хөтөлбөрүүдийн урьдчилсан төлөвлөлтүүд бас хийгдээд явж байгаа. Үүнийг ХААЯ-тай хамтарч бас аймаг, орон нутгийн удирдлагуудтайгаа ярилцаж, сум, аймгуудад хэрэгжүүлэх ажлуудыг бид цааш нь эрчимжүүлэх ажлууд бас байна.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энхамгалан гишүүн тодруулж асууна.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр Шадар сайд аа. Ерөнхийдөө энэ сумын аюулгүй нөөцийн өвс, тэжээлүүдээ үндсэндээ энэ малчдад хөнгөлөлттэй үнээр өгөөд дууссан байна, дууссан байна, сумууд. Тэгэхээр энэ дээр бид нар даруйхан арга хэмжээ цаг алдалгүйгээр даруйхан арга хэмжээ авахаас өөр гарц ерөөсөө байхгүй харагдаж байна, 1 дүгээрт.

2 дугаарт, би бас энэ манай сайн туршлага байна. Шадар сайд аа. Жишээ нь манай Жаргал сумын засаг дарга Бямбажав гээд Засаг дарга үндсэндээ яг энэ отроор өвөлжих, хаваржих энэ малчин өрхийнхөө маш дэлгэрэнгүй судалгааг гаргаад, тэгээд маш нарийвчилсан ийм зураглал гаргаад, тухайн тэр отор нүүдлийг хүлээж авч байгаа сумуудтайгаа эрүүл мэндийн үйлчилгээг нь яах юм, мал эмнэлгийн үйлчилгээнүүдийг нь яах юм, боловсролын үйлчилгээнүүдийг нь яах юм, тийм ээ, тэр бензин шатахуун, дизелийн хангалтын асуудлуудыг яах вэ гэх мэтчилнээр ингээд нарийн зураглал гаргаж ажиллаж байгаа ийм сайн туршиллагууд бас байна. Тийм учраас яг энэ өвөлжилт хүндэрсэн энэ аймаг, сумын Засаг дарга нарыг бас үүрэгжүүлж яг энэ чиглэлээр арга хэмжээ авч чадах юм бол бид нар үүсээж болох эрсдэлээс ... /минт дуусав/

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Өнөөдөр Завхан аймгийн нийт газар нутгийн 80 гаруй хувьд нь цасан бүрхүүлтэй. Манай аймгийн дийлэнх сумдаар бол өвөлжилт нэлээн хүндэрсэн байна. Тэгээд надаа нэг хэд хэдэн тодорхой асуулт байна. Энэ асуултдаа тодорхой хариулт авмаар байна.

1 дүгээрт нь, энэ цаг агаарын урьдчилсан төлөв байдлыг малчид, иргэд, тээвэрчдэд түгээх, дамжуулах тал дээр ямар шинэлэг арга байна? Энэ огт сүлжээгүй отор нүүдлээр явж байгаа малчдад энэ цаг агаарын мэдээг яаж дамжуулах юм бэ? Сая Төв аймгийн Эрдэнэсант сумд маш аюултай цасан шуурга болж, энэ олон айл хайртай хүмүүсийнхээ амь насыг ингээд алдсан, энэ тохиолдолд цаг агаарын мэдээ бас төдийлөн сонсоогүй байсан гэсэн. Ийм зүйл ингээд ярьсан байгаа. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

2 дугаарт нь, энэ малтаад идэх өвс байхгүй, ган болчихсон энэ сумууд дээр яаж анхаарч ажиллаж байгаа юм бэ. Энэ хөрлөсөн цасыг малтаад, зам гаргах бэлчээр гаргах ийм боломж байна уу? Энэ тал дээр судалж үзсэн үү? Мөн Завхан аймгийн хэмжээнд өнөөдөр дизель түли, А-92 бензиний нөөц багатай байна. Өвөлжилт хүндэрч байгаа аймгууддаа бензин, шатахууны тусламж, дэмжлэг энэ хүрэлцээг яаж шийдэж байгаа юм бэ?

Энэ сумдын эмнэлэг, онцгой байдлын алба туулах чадвар сайтай техник хэрэгслээр ерөөсөө хангагдаж чадаагүй байна. Тэгэхээр би нэг энэ ер нь бүх гишүүдийг энэ дээр нэг анхаарлаа хандуулж өгөөч. Энэ Төрийн хэмнэлтийн хуулиар орон нутагт машин, техник хэрэгсэл худалдаж авахыг нь хориглочихсон байгаа. Үүнээс болоод сум, орон нутгийн эмнэлэг, сум, аймаг, орон нутагт машин техникийн хүрэлцээ ерөөсөө байхгүй байна шүү дээ. Ялангуяа

энэ хангайн бүсэд байдаг манай Завхан аймаг шиг ийм алслагдсан багтай, ийм өргөн дэлгэр уудам нутагтай ийм газар төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэхийн тулд төрийн албан хаагчид өөрсдийнхөө хувийн машин, техникийг хэрэглэж байна. Ингэж явж байгаад ямар нэгэн асуудал болох юм бол хэн хариуцах юм. Тэгээд зарим газар ийм хувийн машинтай, машинаа цасанд ингээд суулгаад явж байх тийм хүрэлцээтэй ч газар алга. Тийм учраас нэг санаачилга гаргаж байна. Энэ Төрийн хэмнэлтийн хууль дээрээ эргэж хараад, өвөлжилт хүндэрсэн энэ онцгой байдалд орон нутгийг нь, орон нутагт нь, энэ эрхийг нь өгөх энэ ажлыг УИХ, ЗГ даруй хамтарч шийдмээр байна гэсэн ийм зүйлийг хэлмээр байна.

Мөн сая Болорчулуун сайд 12 сарын 07-нд болох хурлаараа баруун аймгуудад өндөр үнэтэй гурил хэрэглэж байгаа энэ асуудлыг шийднэ гэлээ. Тэгээд баруун аймагт чинь Завхан аймаг байгаа шүү, Болорчулуун сайд аа. Би өнгөрсөн жил Туваад очиж 50кг гурил 60 мянган төгрөг байгаа. Үнэхээр дотоодоосоо энэ асуудлыг шийдэж чадахгүй юм бол Арц суурь боомтоор гурил авах квотыг нь өгчхөөч ээ. 60 мянган төгрөгөөр 50 кило гурил авах энэ боломж нь байгаад байна шүү дээ гэдэг энэ асуудлыг салбарын сайдын хувьд танд бол би албан ёсоор тавьсан байгаа. Тэгээд үнэхээр энэ 2 асуудлынхаа аль нэгийг шийдэж, энэ өвөлжилт хүндэрч байгаа аймгууддаа, ядаж малчид, иргэддээ, хотын болон бусад аймгуудын худалдан авч байгаа үнээр энэ гурилаа борлуулмаар байна гэдэг зүйлийг бол бас албан ёсоор хэлье гэж бодож байна.

Мөн тун удахгүй дараагийн 7 хоногт Монгол Улсын Шадар сайд, ОБЕГ-аас Завхан аймгийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах гэж байгаад бол маш баяртай байна. Тэгээд тэр газар дээр нь очиж танилцахдаа бодит байдлыг бас нүдээрээ харж бас үр дүнтэй шийдвэрүүдийг бас гаргах байх гэж

бодож байна. Тэгээд энэ миний асуусан асуултуудад хариулт өгөөч, тэгээд тодруулж асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Амарсайхан сайд. Сайнбуянгийн Амарсайхан Шадар сайд хариулна.

С.Амарсайхан: Завхан аймаг өнгөрсөн жил зудтай байсан. Энэ жил хамгийн их цас орсон бас зудын нөхцөл байдал амаргүй тал руугаа шилжсэн. УОК, Засгийн газраас өнгөрсөн энэ 07 дугаар сарын 24-нд өвс 0 тэжээлийн нөөцөө бүрдүүлэх үүрэг даалгаврыг өгсөн, төлөвлөлтүүдийг хүргүүлсэн. Харамсалтай нь аймаг, сумдын хэмжээнд аюулгүй нөөцөө хангалтгүй бүрдүүлж авсан. Зун бас гантай байсан. Өвсний аюулгүй нөөц 41 хувьтай, тэжээлийнх 20 гаруй хувьтай байна гэдэг ийм мэдээлэл ирсэн. Энэ чиглэлээр бас арга хэмжээ авах, шаардлагатай зохион байгуулалтыг хийх ажлууд бас ид өрнөж байна.

Аймаг, орон нутгийн удирдлагууд төсөв, хөрөнгөө бүрдүүлж байгаа, төсвөө батална. Зарласан тендер нь маргаантай болсон, Завхан аймаг. Түүнээс үүдээд тэжээлийн өвсний нөөцүүд дутуу бүрдсэн гэж ойлгож болно. Одоо төсвөө батлахдаа дотоодын бас энэ нөөцөө бүрдүүлэх дээр аймгийн удирдлагууд төсөвтэйгөө уялдуулж асуудлуудаа 1 дүгээрт, шийдвэрлэх шаардлага бий. Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зарим дэмжлэг тусалцааг аймгуудад үзүүлнэ, 1 дүгээрт.

2 дугаарт, хэмнэлтийн хуультай холбоотойгоор аймаг, орон нутгуудад үүсэж байгаа хүндрэлүүд бий. Сая Баярсайхан гишүүн хэллээ. Хэмнэлтийн хуулиар өөрсдөө автомашин авах болон шинэчлэх эрхийг нь хаагаад хаячихсан. Энэ дээр Их Хурал дээр ярьж байж бас нэг зарим арга хэмжээнүүдийг авахгүй бол түүрүүн би хэлсэн. Зуд болохоор Засгийн газраас аймаг, сумууд нь машин нэхдэг, өөрсдөө зарим нь боломж

байдаггүй. Зарим аймгууд нь ойн арга хэмжээ гээд хэдэн тэрбумаар тэмдэглээд байдаг хэрнээ өөрсдөө сумуудаа машинаар хангадаггүй. Тэгээд өвөл болохоор жинхэнэ малчдаа, машинаа санасан хүмүүс гарч ирдэг гэдгийг бүгдээрээ бас харж байгаа. Тэгэхээр ийм асуудал дээр аймаг, орон нутаг ч анхаарах хэрэгтэй. Яамууд ч анхаарах хэрэгтэй. УОК-оос зарим зарим шаардлагатай машин техникүүдийг нь шийдвэрлэж өгч байгаа. Гэхдээ бүх аймгуудад шийдвэрлэх ямар ч боломж байхгүй.

3 дугаарт нь, энэ Цаг агаар, орчны шинжилгээний байгууллагаас гаргаж байгаа цаг агаарын аюулт үзэгдэл, болзошгүй байгалийн гамшигтай холбоотой мэдээ мэдээллүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр, сум, аймаг, орон нутгаар, багийн түвшинд хангалттай дамжуулж байгаа. Иргэд, малчид маань хангалттай авч байгаа, мэдээллээ авч байгаа хэдий ч гэсэн амьжиргааных нь эх үүсвэр болсон мал сүргээ хаяхгүй, орхигдуулахгүй, шуурганд уруудуулах ийм эрсдэлтэй нөхцөл байдлууд бас байсаар байна. Энэ дээр малчдаа буруутгах ямар ч боломж байхгүй. Насаараа тэжээсэн амьжиргааных нь эх үүсвэр болсон мал сүргээ эсэн мэнд өвөлжүүлэхийн тулд өөрсдийгөө эрсдэлд оруулж байгаа тохиолдлууд цөөнгүй байгаа.

Тэгэхээр бид энэ баг, сумын түвшинд малчдадаа зөвлөмж, зөвлөгөөгөө өгөх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өөрөө өөрсдийгөө болон өрөөл бусдыг эрсдэлд оруулахгүй байх гэдэг ийм тал дээр онцгой анхаарал хандуулахыг бас хүсэж байгаа, уриалж байгаа. Нэг хүн төөрч ор сураггүй алга болоход араас нь гэр бүл, ах дүү, амраг садан нь бүр цаашилах юм бол аймаг, орон нутгийн ард түмэн, ард иргэд, албан байгууллагынхан гэж яваад нэг хүний биш нэлээн хэд, олноороо эрсдэлд орох ийм нөхцөл байдлууд ч бий. Тийм учраас энэ цаг агаарын байгууллагын мэдээллийн сэрэмжлүүлгийг бид өдөр тутам, цаг

тутам өгч байгаа. Энэ тал дээрээ бас хаана хаанаа анхаарах асуудлууд бий.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун ХХААХУ-ийн сайдад хариулъя.

Х.Болорчулуун: Баярсайхан гишүүн асууж байна. Баруун 3 аймаг гэлтгүй манай Завхан аймаг бас гурил, будаа үнэтэй байгаа. Төвийн болон зүүн аймгийг бодвол, тийм учраас энэ Завханы Оросын Холбооны Улстай хиллэдэг боомт, Арц суурь боомтоор гурил, будаа оруулахыг бас анхаараач гэсэн асуудлыг тавьж байна. Энэ асуудлыг бас 7-ны хурлаараа бид нар бас хэлэлцье гэдгийг бас хэлэх байна.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Баярсайхан: Тэгэхээр өнөөдөр зайлиггүй энэ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7 дахь хэсэгт заасан энэ заалтаа ЗГ, Их Хурал эргэн харж, орон нутаг өөрийн төсөв хөрөнгөөрөө машин, техник хэрэгсэл худалдаж авах энэ эрхийг нь нээж өгч чадахгүй бол ЗГ эсвэл онцгой байдлаас бүрэн хангах ийм л хэмжээнд хүрээд байна. Ноднин жилээс хойш энэ асуудал маш их тавигдсан. Манай Завхан аймгийн хэмжээнд 17 сумд сумын эмнэлгийн ЭМТ машин байхгүй, бүр төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх ямар ч боломж байхгүй ийм нөхцөл байдал үүсээд байгаа. Тэгэхээр энэ дээр Их Хурлын дарга бас энэ гишүүд мөн Засгийн газрын гишүүд анхаарч энэ Төрийн хэмнэлтийн хуулийнхаа энэ зүйл, заалтыг өөрчлөх энэ шийдвэрийг бүгдээрээ хурдан гаргацгаая. Тэгэхгүй бол энэ өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдалд бид нар өөр шийдэх гарц байхгүй юм байна шүү гэдгийг онцгойлон хэлж байна.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Энэ Баярсайхан гишүүний хэлдэг бас үнэн. Үнэхээр энэ Төрийн хэмнэлтийн хуулиар бүх газрын дарга нар машин унахыг хориглосон байгаа. Улаанбаатарт байгаа тэр яам, тамгын газар, агентлагуудын тэр газрын дарга нар, дэд сайдууд нь тэр машин унахаа больё л доо. Хөдөө орон нутгийн манайх өргөн уудам нутагтай, ХАА-н газрын даргыг хүртэл машин унахыг хориглочихсон байгаа шүү дээ. Тэгэхээр яаж ажлаа хийх юм бэ. Зөвхөн ширээний ардаас ажил хийж болохгүй шүү дээ, энэ хөдөө орон нутаг чинь. Тэгэхээр Төрийн хэмнэлтийн хуулийг бас эргээж харж, энэ асуудлыг өөрчлөхөд бас ЗГ бас анхаарах хэрэгтэй. Бид нар бас анхаарахын төлөө ажиллалаа гэдгийг хэлэх байна.

Г.Занданшатар: Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Шадар сайд Амарсайхан цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулж, нэн яаралтай журмаар боловсруулаад оруулж ирэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ сумын Засаг дарга ч гэсэн хөдөө ажлын бензин норматив тэгээд л малчдаар ч явах бололцоо энэ тэр хязгаарлагдсан, халамж үйлчилгээ, эрүүл мэнд бүх юмнууд хязгаарлагдсан, цас зудын нөхцөл байдалтай тохиромжгүй юм байна гэдгийг хөдөөгийн сумын дарга нар сая маш их ярьж байна лээ. Үүнийг судлаад яаралтай шийдвэрлэх шаардлагатай.

Тлеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Гишүүд бүгдээрээ л хэлж байна даа. Ялангуяа алслагдсан аймгийн гишүүд бүгдээрээ тойрог дээрээ очоод ажиллаад ирсэн. Улаанбаатар хоттой харьцуулах юм бол гурил болоод малын тэжээлийн үнэ үнэхээр харьцангуй байгаа юм. 1700км-т газар энэ өвлийн хүйтэнд тээвэрлээд очсон гурилаа хямдхан өг гэж бизнес эрхлэгчдэд хэлэх боломж байхгүй. Гарц байгаа юм, Болорчулуун сайд аа. Сая бас та бүхэн маань бас таатай мэдээ хэлж байна. Энэ өвлийн энэ хүнд хэцүү цаг үед

байдаг юм уу, Оросын талаас импортоор орж ирэх гурил, хивгийн үнийн энэ гаалийн татвар, НӨАТ-ын асуудлыг бас засгийн хурал дээр та нар нэг яаралтай авч хэлэлцээч. Улаанбаатар хотод 80 мянган төгрөг байгаа гурил чинь үндсэндээ алслагдсан аймгуудын бүр цаад талын сумууд дээр 140, 150 мянган төгрөг хүрсэн байна шүү дээ. Гурил. 1700км газар Улаанбаатар хотоос тээвэрлэж ирж байхаар тодорхой хэмжээний тохируулга хийгээд цаад талын ойрхон 600, 650км-т байдаг Горнотоос Барнаул чиглэлээс нэг 50, 60 мянган төгрөгт ороод ирчих бололцоо байгаа харагдаад байгаа юм. Одоо энэ өвлийн энэ хүйтэн хүнд хэцүү цагт мал нь ч тэжээл байхгүй, иргэд нь ч үнэтэй гурил идсэн нэг ийм нөхцөл байдал байгаа юм. Сая бүгдээрээ Засгийн газрын гишүүд бас ярилцаж байх шиг байна. Таатай мэдээнүүд байна. Сая Адьшаа гишүүн бас хэллээ. Энэ Ховдоос гарсан гишүүд Баян-Өлгий аймаг бид нар чинь адилхан л зовлонтой л байдаг юм. Ний нуугүй хэлэхэд. Бямбацогт гишүүн удаа дараа ярьж байгаа энэ асуудлыг.

Тийм учраас энэ гурил, хивгийн импортын татвар болоод энэ татвар, гааль, НӨАТ-ын татварыг хөнгөлөх асуудлыг яаралтай Засгийн газрын хуралдаан дээр оруулж ирээд тодорхой хугацаанд нэг тохируулга хийгээд өгөөч ээ гэж. Эхний 1 дүгээр асуудал байж байгаа юм.

2 дугаар асуудал маань Алтанбулаг болоод бусад Оростой хиллэдэг хилүүд маань цаанаасаа Оросын талаасаа иргэдэд нэг шуудай гурил нэг 2 ширхэг 9-ийн тос аваад ороод ирэх боломж өгөөд байдаг. Энэ Боомтын сайд энэ дээр алга байна. Энэ Баян-Өлгий аймагтай хил залгадаг тэр Косагашийн хилтэй хилийн нөхдүүдтэй бас яримаар байгаа юм. Өмнө нь бол нэг машин дотор 2, 3 шуудай гурил оруулаад зөвшөөрөөд байдаг байсан бол одоо Оросын тал таг хорьчихсон. Ганцхан манайтай хил залгадаг Косагашийн боомт. Үүнийг бас Боомтын сайдад Болорчулуун сайд аа,

Засгийн газрын гишүүний хувьд Бямбацогт сайд та нар маань бас энэ асуудлыг засгийн хурал дээр яриад өгөөрэй гэж.

Энэ Болорчулуун сайд аа, 3 дахь асуудал маань махны экспорт бол чөлөөтэй болсон. Өнгөрсөн оны 11 сарын 24-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор хонь, ямаа, адуу 3-ыг квотгүй болгосон байж байгаа. Одоо ерөөсөө ганцхан шалтгаалж байгаа зүйл бол бизнес эрхлэгчид маань хүлээн авагч буюу импортлогч улсын талтайгаа хорио цээрийн асуудлыг тохирох юм бол Монголын тал бүх зүйл нээлттэй байгаа. Сая энэ өнгөрсөн 7 хоногт ХААЯ дээр мал махны экспортын нэг цонхны үйлчилгээг нээсэн байгаа. Энэ маань бизнес эрхлэгчдэд олгосон энэ махны экспортыг дэмжих Засгийн газрын хийсэн том ажлуудын нэг ээ. ЗГ болоод энэ төр засаг нь л махаа экспортлохгүй байгаа юм шиг ойлгогдоод байна. Тийм юм ерөөсөө байхгүй.

Сая энэ өнгөрсөн оны 11 сард гаргасан Засгийн газрын тогтоолоор адуу, хонь, ямаа 3 квотгүй болчихсон. Ганцхан хүлээн авагч буюу тэр импортлогч улсын хорио цээр дээр асуудал үүсэж байгаа юм. Энэ юуг харуулж байна гэхээр бид нар нэгэнт л хөрш зэргэлдээ улсуудынхаа хорио цээрийн стандартыг Монголд нутагшуулах асуудлыг яаралтай авч судлах хэрэгтэй. Бид нар ганцхан Хятад руу л гаргаж байгаа. Ний нуугүй хэлэхэд. Одоо багахан хэмжээгээр Узбекистан, Казахстан, Орос руу, Япон руу бага гарч байгаа. Гол импортлогч Хятад улсынхаа хорио цээрийг Монгол Улсад нутагшуулах асуудлыг судлах хэрэгтэй. 3 дахь асуулт ийм асуулт, санал байна гэж.

Өнгөрсөн зун сая Амарсайхан сайд хэллээ. Өнгөрсөн зун үндсэндээ баруун аймгаар 2 зун дараалаад ган гачиг болчихсон. Бэлчээр байхгүй, өвс тэжээлийн нөөцийг орон нутаг маань тодорхой хэмжээнд бүрдүүлсэн боловч

хангалттай биш байгаа. Одоо аймгууд төсвөө ярьж байгаа энэ үед үүнийгээ ... /минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэлсэн үү? Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Аубакир гишүүний асуултад хариулъя. Ер нь импортлогч орны тэр хорио цээрийн асуудлыг, стандартыг Монголд нутагшуулж шаардлагыг нь хангаж ингэж махаа гаргая гэсэн асуудал тавьж байна. Олон улсын шаардлага нь тийм л дээ. Хятад улстай манайх үхэр, хонины махыг ихэвчлэн дулааны аргаар буюу чанаж гаргаж ийм экспортод гаргаж байгаа. Хятад улс 2016 оноос хойш, 16 оноос хойш экспортод гарах манай Монголын аж ахуйн нэгжүүдийг бол нэмэгдүүлээгүй байсан. Энэ жил харин 4 аж ахуйн нэгжийг бол нэмэгдүүлж хуучин 16 байсан одоо энэ 20 ААН Хятадад экспортод махаа гаргахаар ийм байдалтай байгаа.

Цаашидаа бид өшөө 20 биш, өшөө 40, 50 аж ахуйн нэгжийг махны бизнес эрхлэгч үйлдвэрүүдийг Хятадын зах зээлд гарахад нь дэмжиж ажиллах ёстой. Өвөр Монголд болсон Экспо-ны үеэр Хятадын Худалдааны дэд сайдтай би уулзсан. Энэ асуудлаа хөндөж тавьсан, анхаарч ажиллая гэсэн. Яг тэрнээс хойш бас анхаарч ажиллаж байгаа нь манай талд ч гэсэн манай яаманд бол мэдэгдсэн.

Бид одоо ХХААХҮЯ, ЭМЯ хамтарсан бүх махны үйлдвэрүүдэд аттестатчилал хийгдэж байгаа. Ингээд олон улсын шаардлагыг хангасан стандартын шаардлагад бүрэн нийцсэн ийм махны үйлдвэрүүдийг бол бид нар бүгдийг нь урагшаа болон бусад улсууд руу Хятад болон бусад улс руу экспортод гаргах асуудлыг тавина гэдгийг бас хэлье.

Одоо махны квот байхгүй болсноороо ялангуяа нэг цонхны бодлогоор үйлчилж байна. Хөнгөн

шуурхай. Энэ жил 70 мянган тонн мах экспортод гараад байна. 18 онд Монгол Улс түүхэндээ 70 мянган тонн мах гаргасан юм, хамгийн дээд үзүүлэлт юм билээ. Тэрийг энэ жил эвдэж бараг 80 мянга дөхсөн экспортод мах гарах болов уу гэсэн ийм ерөнхий төсөөлөлтэй байгаа гээд бас хэлье.

2 дугаарт, тэр энэ тэжээлийн талаар ярилаа. Тэжээл орж ирэхэд ямар нэг хорио байхгүй. Импортоор орж ирэх нь. Нийт 37 мянган тонн тэжээл одоогийн байдлаар импортоор аваад байна. Ялангуяа Оросын Холбооны Улсаас. Экспортод манайх урагшаа гаргах Хятад руу гаргахдаа бол 20 мянган тонн тэжээл экспортод гаргаад байна.

Г.Занданшатар: Аубакир гишүүн 1 минут тодруулж асууя.

Т.Аубакир: Махны экспорт дээр яах вэ, чанасан чанаж гаргах технологиор гаргаад байгаа л даа. Энэ чинь юу гэж байгаа юм гэхээр нөгөө хүлээн авагч улс маань Монголоос орж ирж байгаа махыг тэдэн градус чанаж болгож авахгүй бол нөгөө хорио цээрт нийцэхгүй байна л гэж үзээд байгаа юм л даа. Миний хэлж байгаа зүйл бол ерөөсөө тэдний энэ хорио цээрийнх нь стандарттай нь манайх зэрэгцүүлчих юм бол ялгаа байхгүй болчих юм л даа. Эргэлзээ байхгүй болчих гээд байгаа юм.

Тийм учраас нэгэнт л бид нар зах зээлээ түшиглээд тэдний зах зээлд тохируулж стандартаа батлаад, судлаад баталбал яасан юм бэ гэсэн саналыг хэлээд байгаа юм. Тэгээд энэ сум, орон нутгуудын бас энэ унааны асуудал үнэхээр энэ хэмнэлтийн хуультай холбоотой, сая хурлын дарга маань Шадар сайдад үүрэг өгч байх шиг байна. Бас үүнийг оруулахгүй бол нээрээ л хөдөө явган нүцгэн хаана хүрэх вэ дээ, энэ зуд зурхантай, энэ хүнд хэцүү үед. Тийм учраас энэ хэмнэлтийн хуулийн асуудлыг бас анхаарах нь зөв байх гэж хэлье.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Энэ мал махны импорт дээр бол олон улс маш өндөр хорио цээр тогтоодог. Яагаад гэвэл хүнсний гол зүйл мах гэдэг болбол. Тийм учраас янз бүрийн тэр махаар дамжиж, хүнсээр дамжиж өвчлөл бий болох вий гэсэн байдлаас бол хорио цээрийг өндөр тогтоодог байгаа юм. Энэ олон улс бол явал, ямар шаардлагатай гэхээр мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс мөн тусгаарлагдсан хамгаалагдсан аж ахуйгаас л мах авах ийм шаардлага тавьдаг. Үүнийг үнэндээ өнөөдрийг хүртэл манай ХАА-н салбарт хэрэгжүүлээгүй л ирсэн байхгүй юу. Бэлчээрийн МАА-гаар л тэр чигээрээ яваад байдаг дангаараа, тэгсэн мөртөө махаа экспортолъё л гэж яриад байдаг. Бид энэ шаардлагын дагуу ажиллах ёстой, ажиллаж эхлээд байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулаад, өвөлжилтийн нөхцөл байдал бас сайнгүй байгаатай уялдуулаад нэг хэд хэдэн саналуудыг бас хэлье гэж бодож байна. Ерөнхийдөө хөдөө орон нутагт бас нэг малчдыг зовоож байгаа өвөлжилттэй холбоотой нэг хэд хэдэн асуудлууд байгаа.

Мэдээж 1 дүгээрт, энэ дизель түлшний хангамж нийлүүлэлтийн асуудлууд байна.

2 дугаарт, энэ өвс, тэжээлийн үнэтэй холбоотой асуудлууд

3 дугаарт, мал махны борлуулалттай холбоотой төрөөс тодорхой зохицуулалт хийх энэ асуудлууд байгаа. Би энэ дээр нэг 2, 3 саналыг хэлье гэх гээд байгаа юм. Тэгэхээр та бүхэн бас нэг анхааралтай тэмдэглэж аваад, энэ асуудлууд дээр ажил хэрэгч хандаач. Их Хурлаас ч гэсэн бас энэ дээр бодлогын

зохицуулалт хийх дээр нь хамтраад оролцоод явъя гэдэг саналыг л хэлэх гэж байгаа юм.

1 дүгээрт, өвс тэжээлийн үнэтэй холбоотой. Өвс тэжээл хивээг нэг хөдөө орон нутагт нэг 30 мянгатай, боодол өвс нэг 18 мянгатай, шуудай тэжээл нэг 40-50 мянгатай ч гэдэг юм уу. Төрлөөсөө хамаараад нэг ийм үнэтэй байгаад байгаа. Тэгэхээр өвс тэжээлийн үнийг бид нар аль болох хямд байлгах, малчид болоод юу гэдэг юм, үйлдвэрүүд хямд тэжээл хэрэглэх, малын тэжээл болоод энэ тэжээл авах энэ асуудал дээр нь яалт ч үгүй төрийн зохицуулалт болоод төрийн дэмжлэг хэрэгтэй байгаад байна. Төрийн зохицуулалт, төрийн дэмжлэг. Тэгэхээр бид нар тэжээл үйлдвэрлэгч нарт татварын бодлогоор дэмжлэг үзүүлбэл яасан юм бэ? Бид нар сая хэд хэдэн үндсэндээ Монгол Улсад тэжээл үйлдвэрлэж байгаа 5 ААН байна. Майн тек, Түмэн шувууд, Алтан тариа, Милл хаус, Баялаг Фийтс гээд бид нар хэд хэдэн ААН-үүдтэй нь уулзлаа. Түмэн шувууд болоод баялаг Фийтс болоод Майн текийнхэнтэй уулзлаа. Эд нарын хувьд ярьж байгаа зүйл бол бид нар энэ дээр энэ тэжээл үйлдвэрлэлтийн үнэ өртгийг бууруулахын тулд магадгүй юу гэдэг юм, дотоодын НӨАТ-ыг нь 10 хувийг нь зөвхөн дотоодод үйлдвэрлэсэн үндэсний тэжээл үйлдвэрлэл болоод энэ бүтээгдэхүүн дээр нь хөнгөлөлтийг бий болгох юм бол магадгүй өнөөдөр бид нар 30 мянгаар борлуулж байгаа тэжээлээ дахиад 10% бууруулаад 27 мянга ч гэдэг юм уу, энэ боломжийг бүрдүүлэх боломж бололцоо байгаа. Үүнийг импортоор орж ирж байгаа, Оросоос орж ирж байгаа, хямд тэжээлтэй өрсөлдөх боломж бололцоог нийлүүлж боломжийг бий болгож өгөөч гээд асуудлыг тавиад байгаа юм. Тэгэхээр энэ бол цэвэр үндэсний үйлдвэрлэлээ хамгаалж байгаа.

Нөгөө талдаа бид нар энэ зөвхөн тэжээл үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэлүүд үүгээр одоо юу гэдэг юм тодорхой үнээ бууруулж байгаа асуудлууд биш. Малчид тэндээс юу гэдэг

юм, хямд тэжээл авах асуудлууд биш. Энэ бол цэвэр хүнсний үйлдвэрлэлийг дэмжих бас бодлого болчхоод байгаа юм. Яагаад вэ гэхээр өндөг, сүү, тахиа, мал махны энэ асуудлууд чинь бүгд л бас тэжээлтэй холбоотой. Фермерийн аж ахуй бүгд тэжээлтэй явж байгаа. Тэгэхээр бид нар цаашидаа өндөгний ч үнэ дээр, сүүний ч үнэ дээр, дахиад тахианы махны ч үнэ дээр, мал махны дахиад энэ НӨАТ-аар дэмжих бодлого боломж бололцоо зөвхөн тэжээлээр дамжаад боломж бололцоо бүрдэх ийм бололцоо байна гэдэг зүйл харагдаад байгаа юм. Тэгэхээр үүнийг нэг анхаарч үзээч. Та бүхэн болж өгвөл ЗГ, Сангийн яам хамтарч байгаад Та бид бүхэн гарц гаргалгаа шийдийг нь ирэх 7 хоногт оруулж ирвэл УИХ ч гэсэн энэ дээр шуурхай хандаад явах боломж бололцоо байна гэсэн нэг санал байгаа юм, 1-д.

2 дахь асуудал нь мал махны борлуулалтын асуудал дээр нэг төрөөс бид нар зохицуулалт хийх асуудал бол яах вэ, одоо бол 70-80 мянгыг экспортод бид нар гаргах боломж бололцоо байна гэж байгаа юм. Энэ сайн. Квотгүй, хориогүй болчихсон. Одоо харин бид нар гадагшаа мал мах гаргаж байгаа үйлдвэрүүдийг энэ хүндэрсэн аймгууд дээрээс татан авалт хийх гэдэг юм уу тодорхой зохицуулалт чиглүүлэлтийг хийх боломж бололцоо байна уу, үгүй юү. 10 аймаг 100 гаран сумын асуудлууд байгаад байгаа юм. Нийт сум нь хүндэрчихсэн учраас, өвөлжилт хүндэрчихсэн учраас нийт малынхаа бараг 40-50 хувийг нь бойлчихсон байгаад байгаа юм. Одоо бид нар төрөөс энэ бойлчихсон байгаа мал махан дээр нь дэмжлэг тусалцаа үзүүлээд борлуулалт дээр нь жоохон зохицуулалт хийх л шаардлага байна гэж хараад байгаа юм.

Яг үүнтэй адилхан дизель түлшний хангамж нийлүүлэлт хомс байгаа энэ цаг үе дээр бид нар бас л саяын тэр нэг хүндэрчихсэн байгаа 10 аймаг болоод 100 гаруй сумууд дээр дизель түлшнийх нь нийлүүлэлтийг нь нэмэгдүүлж өгөөд, магадгүй төв суурин

газруудынх нь нийлүүлэлтийг нь бага зэрэг хязгаарлаад, хөдөөдөө хүндэрчихсэн, өвөлжилт хүндэрчихсэн сумууд дээр нь гэдэг юм уу, аймгууд дээр нь түлхүү анхаараад явах боломж бололцоо байна уу, үгүй юү гэсэн ийм л 3 саналыг хэлэх гэсэн юм.

Г.Занданшатар: Энэ саналуудыг Шадар сайд, Сангийн сайд нар судалж, Их Хуралд эргэж танилцуулна.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 7 хоногт бас орон нутагтаа ажилласан. Сая Бат-Эрдэнэ гишүүн бидний хувьд бас нөхцөл байдалтай яг л газар дээр нь танилцаж, мэдэрч явлаа. Олон хүндрэлүүд гарч байна. Энэ цаг агаарын нөхцөл байдал. Шатахуунтай холбоотой асуудлыг гишүүн болгон ярьж байна. Би эндээс нэг зүйлийг давхардуулахгүйгээр тодруулахад сая шатахуунтай холбоотой нэг 7, 8 хоногийн энэ асуудал гарахад ер нь хэнийх нь үгэнд итгэхээ мэдэхээ байлаа шүү дээ.

Нийлүүлэлт нь хэвийн ч юм шиг, хэвийн бус ч юм шиг, хоригт орсон ч юм шиг, ороогүй ч юм шиг гээд л нэг бужигнаж, бужигнаж, бужигнаж одоо л харин нэг жоохон цэгцтэй ойлголтууд өгч байна. Эдийн засгийн сайд хойшоо явах гэж байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг. Энэ олон бужигнаан дундаас нэг аюултай нэг юм гараад ирж байгаа нь үнэ нь суга өссөн, дизель түли. Хэрвээ нийлүүлэлт нь хэвийн байгаа бол үнэ нь яагаад ингэж өсөх юм? 3700 байсан түли 4500-аар арай чамай олдож байна. Тэгэхээр үнэ ер нь яах юм бэ? Нийлүүлэлт хэвийн байгаа юм бол, хориг нь цуцлагдаж байгаа юм бол үнэ ингээд өсөх юм уу гэдэг дээр. Эргээд буух уу гэдэг дээр тодорхой.

2 дугаарт, энэ махны борлуулалтаар би Хөдөө аж ахуйн яамыг бол сайн ажиллаж байгаа гэж хэлэх гээд байгаа юм. 70 мянга гэдэг чинь бас тийм

амархан тоо бас биш. Түүхий махаараа яривал энэ чинь бараг 100 гаруй мянга болох юм байна шүү дээ. Тэр квотыг нь цуцалчихсан байна. Энэ квот гэж нэг хүнд суртлын юм байж. Тэр механизмуудыг нь маш богинохон болгосон байна. Энэ бол сайн үзүүлэлт. Сая би Мал эмнэлгийн газрын даргын яриан дээрээс дахиад хүсэлтүүд ирээд байгаа гэж байна шүү дээ, ирээд байгаа. Тэгээд энэ хүсэлтүүдийг хангахад хаанаа ямар гацаа байгаа юм бол оо? Үүнийг нь хурдхан шиг гаргахгүй бол энэ бойлчихсон энэ олон махаа бид нийлүүлэхгүй бол сайхан өнтэй өвлийнх шиг тийм хэвийн нийлүүлэлттэй бол явахгүй нь. Үүнийг бол малчид маш ихээр ярьж байна.

Хивэг. Бас гишүүд ярьсан. Хивэг ер нь Монгол Улс экспортлох юм уу? Ер нь гаргаж байгаа юу, гаргахгүй байгаа юу? Энэ чинь 22 мянга байсан хивэг 30 мянга болчихлоо гэж байна шүү дээ. Тийм. Тэгээд ингээд үнэ нь өсөх юм уу, энэ чинь эрэлт багасаад л нийлүүлэлт нь гүйцэхээ болиод л үнэ өсдөг. Энэ зарчмаараа яваад байгаа юм уу, эсвэл зохиомол юм үүсгээд байгаа юм уу? Тийм. 22 гэдэг үнэ бол үйлдвэрлэчихсэн хивгийн хувьд бол нэлээн ашиг орлого хамаг юм нь шингэчихсэн үнэ болов уу л гэж ингэж бодох юм. Тэгэхээр энэ дээр ер нь ХААЯ ямар бодлоготой байх юм бэ?

Ганц нэг санал байгаа юм. УОК бол ингээд сануулга юмнуудаа өгөөд, газар дээр нь танилцаад л ингээд л явж байна. Асуудлыг нь зарим газар шийдээд, машин унаа ч бас зарим газраа шийдэж өгч байх шиг байна. Ер нь бид нар энэ гамигийн эсрэг, ялангуяа энэ өвөлжилт, хаваржилтын эсрэг энэ менежментээ өөрчлөхгүй бол хойтон ч гэсэн ийм юм яриад сууж байж магадгүй. Энэ байгаль цаг агаар, сая Онцгой, улсын Шадар сайдын танилцуулснаар. Ер нь ХАА-н салбар тэр дундаа МАА-н салбар өвөлжилт, хаваржилтыг гарз багатай даван туулахад малчдын өөрсдийнх нь оролцоог дэмжсэн ийм зүйлүүдийг бүр цогцоор нь авч үзэж, энэ Газрын хууль дээрээ ч гэсэн бас энэ талын юмыг нь

нэлээн нээж өгөх ийм бололцоонуудыг гаргаж өгмөөр санагдах юм.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Нугаар, Хужган гээд 2 бригад төрийн нэрийн газар дээрээ авчирсан газар дээрээ 100 га-д 30, 40-үүлээ нийлж тариад л 3, 400 боодол нэг айл аваад л ингээд л байж байх жишээнүүд байгаа. Гэтэл одоо хууль, эрх зүйн хүрээнд энэ маш хязгаарлагдмал байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнээс авхуулаад л бид энэ өвөлжилтийн бэлтгэлийг давж туулахыг бодохгүй бол болохгүй нь.

Сумын нөөц гээд нэг юм гаргадаг. Би сая бас энэ сум дээр явж байхдаа нэг сумын нөөцийг асуусан. Байх ёстой нөөц нь 1000 боодол гэж байна. Малчин айл нь хэд вэ? Мянган малчин айлтай, малын тоо хэд вэ, 430 мянган малтай. Тэгэхээр үүнийг ер нь яг нөөц гэж үзэх үү, айл болгонд нэгийг өгөх юм уу гээд л ийм мэтийн зүйлийг бид нар бас нэг цогцоор нь авч үзэж ярихгүй бол би бол болохгүй байгаа юм болов уу л гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр 3 ... /минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Гурван тамир” сургуулийн 12а ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт багш, сурагчдадаа сурлага спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе, Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Эхлээд Болорчулуун сайд хариулах уу? Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Махны борлуулалтын талаар ярьж байна. Цаашидаа махны борлуулалтдаа ямар арга хэмжээ авах вэ гэж. Хүнсний хангамж, аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын 6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох ийм хүнсний

болон ХАА-н бараа бүтээгдэхүүнүүд дээр. Эндээс 50 тэрбумыг энэ махан дээр дахиж гаргаж, хөнгөлөлттэй 6 хувийн хүүтэй зээл аж ахуйн нэгжүүдэд өгөх ийм төлөвлөгөө бодолтой байна гэдгийг бас хэлье. Одоо нийслэл 48 тэрбумыг гаргаад ААН-үүдтэй гэрээгээ хийгээд явж байгаа. Хувийн хэвшилүүдээ дэмжиж, хөнгөлөлттэй зээлээр махыг нь авхуулахаас биш, төр оролцоод төр махаа худалдаж аваад хадгалаад цаашаа борлуулна гэсэн асуудал бол байхгүй гээд хэлье. Гэхдээ ХХААХҮЯ махны бүх төрлийн квотыг байхгүй болгосон. Мөн нэг цонхны бодлогоор түргэн шуурхай, цахимаар үйлчилж ингээд экспортын зөвшөөрлийг ажлын 8 цагтаа гаргаж байгаа. Ийм ч учраас одоогийн байдлаар 70 мянган тонн мах буюу тэр чанасан махыг хэрвээ түүхийг нь шилжүүлбэл 106 мянган тонн мах гараад байна. Экспортод. Монгол Улс түүхэндээ 2018 онд л 70 мянган тонн л экспортод гаргасан байдаг юм билээ. Тэр хэмжээг бол даваад ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

2 дугаарт, хивэгний экспорт энэ олдоц үнэ өндөр боллоо гэж ярьж байна. Хивэгний экспортыг яах вэ гээд. Хивэг бас тодорхой хэмжээгээр үнэтэй болсон. Үнэтэй зарагдаж байгаа нь бол амьдрал дээр байгаа. Гэхдээ 20 мянган тонн тэжээл, хивэг л урагшаа экспортод гарсан байна. Үгүй ээ, гадаад руу. Тэгсэн мөртөө гаднаас 37 мянган тонн тэжээл импортоор авсан байна. Манайх. Экспортод гаргаснаасаа илүү тэжээл импортоор авсан. Ийм гаалийн мэдээ яг өнөөдрийн байдлаар байна.

Хивэгний экспортыг бол 12 сарын 10-наас 3 сарын 10-ны хугацаанд хаахаар онцгой байдлын шуурхай хурлаар бид нар бас ярилцаад ингэж шийдсэн гэдгийг бас хэлье. Гадагшаа экспортод хэвэг 12 сарын 10-наас хойш гарахгүй ээ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Идэрбат гишүүн ээ, нийлүүлэлт бол хэвийн байгаа. Та 102 мянган тонн дизель түли 11 сарын 01-нээс 11 сарын 25-ны хооронд орж ирсэн. Энэ бол өмнөх жилүүдтэй харьцуулахад 35 мянган тонноор илүү байгаа. Тэгэхээр нийлүүлэлт бол хэвийн байна. Оросын Холбооны Улсаас нийлүүлж байгаа нийлүүлэлт бол хэвийн байна.

Хэрэглээ уул уурхайн экспортын бүтээгдэхүүнүүдийн экспорт нэмэгдэж байгаатай холбоотойгоор хэрэглээ нэмэгдсэн. Тэр та ер нь бол хэвлэлийн мэдээ хараад байгаа юм шиг байна. Хэвлэлийн мэдээ чинь тэгээд асууж байгаа сурвалжлагч өөрийнхөө өнцгөөс миний яриаг тасдаж тавиад байгаа учраас. Тэгээд танд бас ойлголт нь тэгж хүрээд байна л даа. Та надаас асуугаад юм уу, УУЯ-наас асуувал бид бас тодорхой мэдээллийг хүргэнэ.

Хоригийн хувьд бол ээлж дараалсан одоо юу гэдэг юм тийм ээ, 92-ынхоо тавьж байгаа хоригийг 1 өдөр цуцалж байгаа юм. Зуны түли нэг өдөр цуцалж байгаа юм. Өвлийн түлиээ, өвлийн түлиний хувьд бол өнөөдөр Монгол Улсад 4 компани л нийлүүлж байна Оросын Холбооны Улсаас. 9 сарын 21-нээс өмнө бол 14 компани нийлүүлж байсан. Үүнийг тэгээд дэлгэрэнгүй энэ 5 минутад хариулахад боломжгүй байна. Дэлгэрэнгүй танд бол хариулахад бэлэн байна.

Үнийн хувьд бол 11 сарын үнэ бол Оросын Холбооны Улсаас зарласан үнэ бол 930 доллар, 12 сард 855 долларын үнэ өгч байгаа юм. Үнийг бол бид нар аж ахуйн нэгжүүдийг шууд очоод энэ чинь төрийн мөнгө гэж бол байхгүй шүү дээ, аж ахуйн нэгжүүд өөрсдөө авч байгаа юм. Тэгэнгүүт бид очоод шууд тэрийг энэ колонкоороо тэдийг зар, заавал үүгээрээ зар гээд бид нар Шударга бус өрсөлдөөний газраар л дамжуулж байгаа юм. Тэгээд яг таны хэлж байгаа бол үнэн. Колонкоороо хямдхан байгаа учраас зарахгүй, бөөнөөр үнэтэй байгаа учраас бөөнөөр зараад байгаа юм байна. Үүнийг

Шударга бус өрсөлдөөний газартай бид хамтраад л ажиллаж байгаа. Энд бол төрийн мөнгө хэрвээ байсан бол УУЯ тодорхой арга хэмжээнүүдийг аваад явна. Энэ чинь хувийн хэвшил өөрөө жилийн 2 тэрбум долларын эргэлттэй зах зээл байгаа.

Тэгээд үнийг би бол танд хэллээ. БНХАУ-аас бид авч байгаа үнэ бол 1080 доллар дизель түли, 92-ын хувьд бол бид бол Оросын Холбооны Улсын Роснефть компаниудтай тогтворжуулалтын гэрээтэй, 705 доллар. Би бас нэг аж ахуйн ажлыг нэг гадарладаг хүний хувьд бол аж ахуйн ажлыг зөвхөн нэг бичиг явуулсан байдлаар бол хийхгүй байгаа. Бүх хүмүүстэй нь тулж уулзаж байгаа. Тэгээд ЗГ болоод Их Хурал ялангуяа Занданишатар дарга бүх л талаас энэ асуудлыг шийдвэрлэхэд, зарим асуудал дээр бол үнэхээр УУЯ яг салбарынхаа яамтайгаа харьцахад бол салбарын яам, төмөр зам, бас шийдэх боломжгүй асуудлууд үүссэн, сая. Засгийн газрын хэмжээнд хүрэх, хүрч байж шийдэгдэж байгаа асуудлууд ч байна.

Тэгэхээр яах вэ, цаашидаа бол бид БНХАУ-аас авч байгаа дизелийн хэмжээг нэмэгдүүлж байна. Мэдээж Хятад улс өөрөө импортлогч улс учраас бид нарын хүссэн хэмжээгээр экспорт хийх боломжгүй байгаа. Заримдаа бол багыг өгч байна, заримдаа ихийг өгч байна. Оросын Холбооны Улсын хувьд бол нийлүүлэлтийг ноднин жилээс бүр давуулсан байдлаар өгч байгаа. Бид 8, 9 сард хангалттай нөөцийг хуримтлуулсны үндсэн дээр энд нэг 20 хоногийн огт ачигдаагүй зүйлийг бол давсан. Гэхдээ яг тэр 20 хоногт үүссэн асуудлаас л өнөөдрийг хүртэл гарч чадахгүй байна л даа. Тэгээд 12 сарын 15-наас эхлээд Оросын Холбооны Улсын дотоод тэр өвлийн түлиний хангалт дотооддоо сайжраад ирсэн үед манайх руу бол бид нарын захиалгын хэмжээнд илүү ачих боломжтой гэж хариулж байгаа юм. Одоо бол яг ноднингийн хэрэглээгээрээ бол хангалттай өгч байна. Тэрнээс давуулаад. Бид нарын хүсэж байгаа зүйл

бол 140 мянган тонн. Тийм их нэмэгдэж байгаа юм.

Г.Занданшатар: Идэрбат гишүүн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Үнийн өсөлттэй юман дээр шууд аж ахуйн нэгжүүд рүү тулгадаг, барьдаг тэр нийгэм биш. Тэрийг бол ойлгож байна. Харин энэ дээр үнэхээр бизнесийн зарчмаар явж байна уу, үгүй юү гэдгийг энэ ШӨХТГ-ын хийх ажил их байна даа гэж би Занданшатар дарга танд хэлэх гээд байгаа юм. Энэ гурилын үнэ гэж 100 гаруй хувиар өсчихсөн. Энэ асуудал дээр энэ ШӨХТГ нь таг. Гурилын үнэ өссөнөөс болоод инфляц нь өсчихсөн, инфляц нь өссөнөөс болоод Монголбанк нь бодлогын хүүгээ бууруулдаггүй, бодлогын хүү өндөр учраас бизнесийнх нь зээл авч чаддаггүй, өндөр хувьтай зээл авдаг. Тэгээд энэ чинь ганц гурилын үнийн асуудал биш болж байна шүү дээ. Одоо инфляц дээр тогтвортой байсан шатахууны үнэ ороод ирнэ. Энэ инфляц бууна гэдэг асуудал бол хүнд болох нь байна шүү дээ. Тэгэхээр Оросын Холбооны Улсаас үнэ нь хямдраад байхад Монголд үнэ нь яагаад өсөөд байна вэ гэдэг дээр тэр ШӨХТГ гэж ер нь дарга, цэрэг гэж байна уу, хүн байна уу. Тэр ер нь бас хийх юмаа хиймээр байна гэсэн саналыг бас хэлмээр байгаа юм. Ирэх 7 хоног ... /минут дуусав/

Г.Занданшатар: Шадар сайд Сайнбаянгийн Амарсайхан. Шударга өрсөлдөөний зохицуулах газар чинь танай харьяанд байгаа байх, тийм ээ. Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Энэ гурил, бараа бүтээгдэхүүний үнэ өртөг, түли түлээний зах зээлийн үнэ инфляцын асуудал дээр холбогдох байгууллагууд ажиллаж байгаа. ШӨХТГ бас хяналтаа тавьж ажиллаж байгаа. Ажил хэргийн журмаар мэдээллийг танд хүргүүлэе.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Өвөлжилтийн бэлтгэл гээд л жил бүхэн нэг уламжлалт нэг ийм л зүйл ярьдаг. Монгол нутагт өвөл болдог өвөл болохоор хүйтэн болдог гээд амны унилагаа шиг болчихсон үг байдаг. Тэгэхээр өвөлжилтийн бэлтгэл гээд л МАА-н салбараа яах юм, түли шатахуун яах юм эрчим хүч яах юм гээд л жил бүхний л яриа. Яг үнэндээ энэ нь өнөөдрийн ярьж байгаа бид нарын энэ ярьж байгаа яриа үнэхээр бас нэг ийм өрөвдөлтэй байна л даа. Өрөвдөлтэй. МАА-н салбар нь хэдэн зуун, хэдэн мянганы өмнөх харилцаа нь яг хэвээрээ. Энд бодлогоор энд өөрчлөлт шинэчлэлтийг нь лав л сүүлийн жилүүдэд, өнөө жил ямар ч бодлогын өөрчлөлт энэ байгаль цаг уураасаа хэрхэн яаж бага хамааралтай болох юм. Гадна дотнын хөрөнгө оруулалтыг ХАА-н салбарт яаж татах нөхцөл бололцоо нь бүрдэх юм. Татварын орчин нөхцөл нь ямар байх юм. Тэр нэг сайхан сайхан амласан элдэв янзын татаасуудаа хэрхэн яаж багасгаж зах зээл рүү нь шилжүүлэх юм. Ямар ч бодлогын шийдэл байхгүй. Дахиад тэр эрчим хүчний салбар бас яг адилхан. Яг л өнөөдөр гал алдахдаа тулчихсан, лаа барих тухай ярьчихсан, цахилгааны хязгаарлалтад орчихсон. Түли шатахууны салбар нь бас яг адилхан. Хөдөө орон нутагт, хөдөө, хот гээд гэж юу байх вэ дээ бүгдийг нь хязгаарлах тухай яриад эхэлчихсэн. Тэгэхээр энэ бүгдийн чинь цаана нийтлэг нэг л зүй тогтол байгаад байна л даа. Нэг ийм халамжийн сайхан улс татаас өгнө, үнийг нь тогтоож өгнө. Шударга өрсөлдөөний газар үүнийг нь тогтоогоод өгчих юм байна л даа. Уг нь үүнийг чинь хүн төрөлхтөн зах зээлийг нь зарчмаараа, иргэд бизнес нь илүү боломжийг нь олгоод, болж өгвөл гадна дотнын хөрөнгө оруулалтууд нь тэнд ороод ашигтай ажилладаг, энэ олон тэр төрөөс бага хамааралтай болгож байж л үүнийг нь уг нь хүн төрөлхтөн шийдэж явж ирсэн нь зантай л юм байна байна л даа. Тэгээд бид бүгд шал яг л өмнө нь

ярьж ирсэн, тийм зүйлээ л ярьсан. Одоо сүүлийн жилүүдэд ямарваа нэгэн энэ бодлогын шийдэл байхгүй. Яг өнөөдөр энэ эрх барьж байгаа улс төрийн хүчинд.

Энэ ХАА газар тариалан дээр бид нар юу өөрчлөгдчихсөн юм, юу ч өөрчлөгдөөгүй. Яг л өмнөх ярьдаг зүйлээ л бид нар ярьсан, өвөл болж байна хэцүү байна, үнийг нь барьж өг. Эрчим хүчний салбар нь яг л энэ. Ямар ч бодлогын, яг үнэндээ та нар яг энэ бодлогын салбарууд дээр үнэхээр ингээд цэнэг чинь дуусчхаад байгаа юм уу, ингээд аргацаагаад явахаар болдог гэж бодчихоод энэ шийдлээ гаргачхаад байгаа юм уу? Яг үнэхээр энэ ингээд энэ Монгол Улсын энэ 3 гэлтгүй л дээ. Бусад бүх салбар дээр. Тэр тусмаа яг ингээд тулчихсан асуудал дээр нэг тэдэн вагон, эдэн вагон ингэсэн, тэдэн тэрбум төгрөгөөр мах худалдаж авна, үгүй ээ, үүгээр юу ч шийдэгдэхгүй шүү дээ. Гол нь тулчихсан үед өнөөдөр энэ асуудлыг ч ярихдаа гол нь биш. Ер нь энэ сүүлийн жилүүдэд, ирэх жилүүдэд бодлогын яг ямар өөрчлөлт байх юм. Юу ч байхгүй бид нарт. Тэгэхээр энэ уламжлал болгоод л хэдүүлээ үүнийг ингээд ярьсаар л явах юм байна. Яг өнөөдөр энэ эрх барьж байгаа улс төрийн хүчин үнэхээр энэ дээр бодлогын өөрчлөлт хийхгүй юм байна. Тийм болохоор энэ дээр тийм ийм гэж асуугаад байх асуулт ч бол үнэндээ алга л даа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Цогтгэрэл гишүүний хэлдэг яг үнэн. Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэн. Гэтэл юм болгонд ингээд төр оролцоод ажил хийж байгаа юм шиг, арга хэмжээ авч байгаа юм шиг, асуудалд хандаад ялангуяа үнэнд оролцоод байж хэрхэвч таарахгүй. Зах зээлийн нийгэмд шилжсэн бол аливаа юмны үнэ тэр зах зээлийнхээ хуулиар л явах ёстой. Төр оролцоод ирвэл наанаа түр зуур ажил арга хэмжээ авсан юм шиг харагдаад цаагуураа бас сандаачилдаг. Болохгүй болдог. Тэр

үйлдвэрлэл хөгжих, юм голдирлоороо явах, энэ бүхэн дээр саад болдог. Тийм. Тэгэхээр сая ч нэг гишүүн хэллээ. Үгүй ээ, одоо энэ чинь юм үнэтэй байгаа юм биш үү, тэр гурил, будаа. Тэр Шударга бус өрсөлдөөний газар үнийг хянаж шалгаж өг, тогтоож өг гэж байна. Тийм байж болохгүй шүү дээ. Тэр гурил будааны юун дээр 3 сарын өмнө Шударга бус өрсөлдөөний газар хяналт шалгалт хийсэн шүү дээ. 10 гаруй гурилын үйлдвэр зохиомол үнэ үүсэх ямар ч боломжгүй байхгүй юу. Тэгээд аж ахуй эрхэлж үзээгүй, бизнес эрхэлж үзээгүй ийм гишүүд энэ тэр бас дураараа ярьж байна шүү дээ. Тэрнээс биш Монгол Улсад зохиомол үнэ үүсгээд, ингээд бизнес хийгээд байх явдал энэ зах зээлийн нийгэмд шилжчихээд яагаад ч байж болохгүй, тийм байдлыг бол өөгшүүлэн дэмжиж болохгүй гэж хэлэх байна.

Г.Занданшатар: Цогтгэрэл гишүүн ээ, ойрын болон дунд хугацааны шийдлийн талаар дараа нь эндээс ажлын хэсэг байгуулна. Та тэрэнд орж ажиллаарай.

Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Засгийн газартаа баярлалаа. Тэгээд бас энэ цаг үеийн асуудлаар хэлэлцье ээ гээд бас санал тавьсны дагуу өнөөдөр бас сайд нар маань суучихсан. Гишүүд бас тодорхой хэмжээнд тойргийнхоо асуудлуудыг яриад ингээд тойроод ярьж байна. Яг энэ асуудлаас бид нар ер нь Монгол Улсын эдийн засгийн тодорхой нөхцөл байдлуудыг бүгдийг нь олж харлаа. Импортлож байгаа бараа бүтээгдэхүүнийхээ асуудлыг ярилаа. Үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнээ ярилаа. Хэрэглээгээ ярилаа. Энэ бүх асуудлууд. Энэ дээр бид нарын өнөөдрийн яг эдийн засгийн бүтэц маань зөв явж байна уу, буруу явж байна уу гэдгийг саяын энэ гарч байгаа бүх асуудлууд тодорхой хэлж өгч байна. Тодорхой хэлж өгч байна.

Өнөөдөр бид нар нэг махаа малчид маань нэг 6-7 мянган төгрөгөөр зарчхаад, нэг боодол өвсийг 15-18 мянган төгрөгөөр худалдаж авч байна. Гурилын асуудал дээр ч гэсэн тодорхой асуудлууд яригдаж байна шүү дээ. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжээд байдаг, дэмжээд байдаг, үр дүнд нь үнэтэй гурил идээд байна гээд. Тэгэхээр бид нар энэ явж байгаа зам маань буруу байна. Энэ замуудыг бүгдийг нь засаж байж, өнөөдөр бид бүхэн бас энэ бодит зах зээлийнхээ зарчмаар явбал хэн хэн нь асуудалд орохгүй л дээ. Мэдээж махны экспортын асуудал ярингуут сая Болорчулуун сайд маань бас тэрэн дээр буруу л яриад байна л даа. Байгаа бүх нөхцөлүүдийг чинь бүрдүүлээд өгсөн байхгүй юу. Өнөөдөр энэ өвчнөөс эрүүл бүсийг байгуулах асуудлыг эхлүүлчихсэн, одоо Замын-Үүд дээр явж л байна.

2-т нь, тэр дулааны аргаар мах урд хөрш рүү гаргаж байгаа. Энэ чинь энэ протоколыг хөөцөлдөж, хөөцөлдөж энэ протоколыг уг нь бий болгосон юм. Одоо үүнийгээ сайжруулчих л даа. Тэгэхгүй энэ байгаа нөхцөл байдлаа та муулаад байх юм. Өнөөдөр та Вьетнам руу махны ямааны мах экспортолно оо гээд л хорио цээрийн протоколыг гарын үсэг зурчхаад л ирсэн. Гацаа нь юу байдаг вэ гэхээр Хятадын нутаг дэвсгэр дээгүүр түүхийгээр нь ямааны махыг дамжуулан өнгөрүүлдэггүй байхгүй юу. Энэ асуудлаа хөөцөлд л дөө. Өнөөдөр тэр олон Элчин сайдын сайд нар чинь юу хийдэг юм бэ. Тэр худалдааны асуудлыг бүгдийг нь авчхаад энэ махны экспортын асуудлыг ярьдаг хүн тэнд байна уу. Тэр протоколуудыг та бүхэнд та нарын гаргасан саналуудыг тэр дэмжээд улс орнуудтай холбож өгсөн тэр Элчин сайд байна уу? Үүнийг л төрийн бодлого гээд байгаа юм л даа.

Малчид дээр хэдэн асуудал байгаа. Сая Амарсайхан сайд бас бүх нутгаар яваад бас нөхцөл байдалтай танилцсан нь сайн хэрэг. Одоо хэдүүлээ нэг хэдхэн асуудлыг л шийдчихье. Энэ хаа сайгүй энэ малчид маань бол өвөлжөө рүүгээ зам нь

хаагдаж эхэлж байна. Энэ хавар бол ер нь хаалттай айлууд олон болно шүү. Энэ дээр УОК тэр бензин шатахууных нь хүрэлцээг нь нэмэгдүүлээд, тэр зам талбайг нээж өгөх тал дээр нь ажиллаж өгөөч.

Мэдээж өвс хадлан тэжээлийн хүрэлцээ муу байгаа гээд байгаа. Одоо тэр улсын фондод байгаа тэжээлүүдээ тэр хямдарсан үнээр нь байх юм уу, зах зээлийнх нь үнээр байх юм уу, хамаагүй гаргаач. Хавар муудсан хойно нь, мал муудсан хойно н, тэр өвс гараад, тэр тэжээл гараад хэрэг болдоггүй шүү гэдгийг бас хэлчихье.

Малын индексжүүлсэн даатгал байгаа. Өнгөрсөн жил улсын хэмжээнд 4,1 тэрбум төгрөгийн нөхөн олговор авсан. Харамсалтай нь индексжүүлсэн даатгалын мөн чанар чинь болохоороо маш өндөр хувиар тогтоогдсон. Өнөөдөр ХААЯ энэ асуудлаа яриад энэ хуулийг өөрчлөөч. Индексжүүлсэн даатгалын уг нь нийт малын 6 % хорогдсон бол тухайн сумын гэж байсныг, төрөл болгоноор нь болгочихсон. Ямаа, тэмээ гээд. Ингээд тэгэнгүүт нөгөөдөх чинь ингээд шууд утгаар нь үржүүлэх юм бол бараг 30 хувийн хорогдлын дараа нөхөн олговор олддог болгочихсон.

Г.Занданшатар: Малын индексжүүлсэн даатгалыг хэн хариулах юм. Гэлэгжамцын Наранчулуун ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Г.Наранчулуун: Сайн байцаана уу? Ганибал гишүүний асуултад хариулъя. Малын хэрэгжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, үнэлгээ өгөх ажлын хэсгийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолоор байгуулсан, энэ талаар ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, тайлан гарсны дараа ямар өөрчлөлтүүд орж болох вэ гэдэг талаар хэлэлцүүлэх болно.

Г.Занданишатар: *Наянтайн Ганибал гишүүн 1 минут тодруулъя.*

Н.Ганибал: *Тэгэхээр энэ бас малчдадаа бас би уриалмаар байгаа юм. Мал мах арай тэнхээтэй байгаа дээр нь бас нядалгаанд оруулаад, энэ борлуулалтын асуудал дээр ЗГ бас тодорхой арга хэмжээнүүдийг хийх байх. Тэр нөөцийн мах гэдэг үгээ хэдүүлээ больё оо. Тэртээ тэргүй мах хямдхан байгаа юм чинь хүн болгон нөөцлөх боломжтой. Харин тэр экспортын баримжаатай махны үйлдвэрүүддээ эргэлтийн хөрөнгө өгөөч. Нөөцийн мах гэдэг энэ хэлдэг чинь махны үнийг барих, махны үнийг тогтоох эргээд л эдийн засгийн буруу хөшүүрэг шүү. Тэгээд үүнийг бас та бүхэн анхааралдаа аваарай.*

Бензин шатахуун дээр Ганбаатар сайд аа. Тэр нэгэнт урд хөршөөс түлш шатахуун импортлож байгаа бол тэр Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт, Говь-Алтайн Бургастай, Ховдын Булганаар тэр шатахуун орж ирэх боломжийг нэн яаралтай Хятадын талтай хэлэлцэж, үүнийг бас нээж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданишатар: *Жамбын Батсуурь гишүүн. Жамбын Батсуурь гишүүнээр дуусгана. 3 гишүүн танхимд байхгүй байгаа учраас хасчихъя.*

Ж.Батсуурь: *Өчигдөр бас чуулган дээр гол санаагаа хэлсэн. Тэгээд ер нь хөдөөд бол өмнө нь болж байгаагүй ийм зуд болж байгаа юм. Жишээлэх юм бол 66 оны зуд, 80-аад оны зуд энэ тэр бол нэлээд орой болж байсан. Их цастай, дороо өвстэй байсан. Энэ жил бол намраараа байж байгаад анхны цас 11 сарын 4-нд маш их хэмжээгээр ороод, тэгээд дулаараад, тэр цас мөстөөд, ингээд 10-д гаргаад дахиж, тийм хэмжээний цас ороод ингээд мөс цас, мөс цас гэсэн ийм нөхцөл байдал үүсчихлээ. Тийм учраас үүнээс гарах гарц бол бид нарт байна гэж ингэж харж байгаа юм. Яагаад вэ гэхээр хаврын гэнэтийн шуурга*

бол гэнэтийнх л байдаг, хэдэн 100 мянгаар нь аваад явчихдаг. Одоо бол мал тархгатай байна, тэвээрэгтэй байна. Энэ байгаа үед нь бол ЗГ итгэл өгч хүмүүсийг хэрэглээнд оруулах, нядалгаанд оруулах асуудлыг шууд өөрсдийнхөө амаар өөрсдийнхөө юугаар Засгийн газрын нэрийн өмнөөс хэлээч ээ гэж энэ зүйлийг хэлж байгаа юм.

Дээр нь хөдөөд нядалгаанд оруулсан малыг сүүдэр газар, том гялгар уутаар бүтээх, урь идүүлэхгүй бай, муудуулахгүй байх. Ингээд байгалийн хөргөгчөөр 4 сар хүртэл авч явж байх хооронд ЗГ экспортолно уу, дахин боловсруулна уу, хагас боловсруулна уу. Үүнийг л ард түмэнд үнийг нь унахгүй өгөх хэрэгтэй. Ийм боломж бол Засгийн газарт байгаа. Яагаад вэ гэхээр 20 онд сонгуулийн жил байсан, та бүхэн ямаагаа самнаагүй байхад нь дансанд нь мөнгийг нь хийгээд байсан. Ноолуурын үнэ 60, 70 мянгаар тогтоож байхад ЗГ ойр ойрхон мэдэгдэл хийгээд дансанд нь 100 мянгаар хийгээд байсан. Тэгвэл энэ жил яг ядарч байхад нь, зүдэрч байхад нь энэ нөхцөл байдлыг махны үнийг унагахгүйгээр бид нар төдөөс доош унагахгүй гэдгээ зарлах хэрэгтэй. Тэгж байж ард иргэд хавар болтол баахан өвс тэжээлээр хамаг мөнгөө шавхаж, хамаг хүч хөдөлмөрөө шавхаж шавхчаад тэгээд хамгийн сүүлийн өдөр тэр малыг устгаж, тэмээн дээр ямаа, ямаан дээр нөгөө янгианы гарз гэдэг шиг ингэж зардал гаргахаас нь өмнө нядалгаанд оруулж нөөцөд оруулах хэрэгтэй.

2 дугаар зүйл. Нөөцийн мах бэлдэнэ гэж ярьдгаа болих хэрэгтэй. Ер нь махны үнийг чөлөөлөх хэрэгтэй. Өнөөдрийн энэ Улаанбаатар хотын утаа, түгжрэл, стресс энэ төвлөрөл юунаас болж байна вэ гэхээр хөдөөгийн бодлого, МАА-н бодлогыг, махны үнийг барьсантай шууд холбоотой. Өнөөдөр хилийн цаана килограмм мах 36 мянган төгрөг байна. Түүнээс ч илүү үнэтэй байна. Та бүхэн дарга сайд нар бол өдий чигнээс өшөөг онгоцоор авчраад 9 мянган төгрөгөөр авч байгаа, хуруун чигнээс

бусыг. Тэгсэн мөртөө хаврын хавсарга, зуны аагим халуун, өвөлжсөө хаваржаа, отор нүүдэл гээд хүний хамаг хүсэл хөдөлмөр шингэсэн махыг үнэ барьж, үнэ чөлөөлөхгүйгээр ингээж хүний хөдөлмөрийг шунгадгаа болих хэрэгтэй. Хэрвээ хөдөөгийн ард иргэд баяжих юм бол Улаанбаатарын хүмүүсийн амьдралын чанар, аймагт байгаа хүмүүсийн амьдралын чанар, сумд байгаа хүмүүсийн амьдралын чанар яг ижил түвшинд ирэх юм бол өнөөдрийн энэ түгжрэл чинь аяндаа байхгүй болно. Тэр автобусны хулгайч байхгүй болно, метро ярихгүй болно. Энэ зүйлийг хэлэх гэсэн юм.

3 дахь зүйл нь бол хөдөө түлш 5 мянга, 6 мянга хүрээд явчихлаа. Энэ мөстэй зуд дээр өвөлжсөөндөө бууж амжихгүй байна. Ийм учраас асуунгуут өнөө маргаашийг хамгаалсан байдлаар ирж байгаа хэмжээнээсээ их ирж байгаа гээд байх юм. Ямар нэгэн тайлбар хэрэггүй байна. Хөдөө тэр түлшийг, А-92 бензинийг зүгээр эхний ээлжид үнэ ярихгүйгээр ядаж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Батсуурь гишүүн асуулт асуулаа. Жамбалын Ганбаатар сайд хариулна.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Би бас ард иргэддээ хандаад бас УУЯ-ны түлш шатахуун хариуцаж байгаа сайдын хувьд бол нэг зүйл хэлье. Ер нь нийлүүлэлт бол хэвийн байна. Тийм учраас маргааши, нөгөөдөр, бүр шатахуун бүр үнэтэй болчих болов уу, эс үгүй бол бүүр ингээд хомсдолд орчих болов уу гэдэг байдлаар энэ юу гэдэг юм, үнэтэй зарж байгаа тэр буруу гараар гэдэг юм уу, бөөний үнээр зарж байгаа энэ асуудлыг дэмжихгүй байхыг бас анхаараач. Нийлүүлэлт бол хэвийн байгааг тоо баримт өөрөө УУЯ-наас гаргаж байгаа тоо биш шүү дээ. Энэ тоо баримт гаалийн мэдээгээр нийлүүлэлт бол хэвийн байгаа. Тийм, тийм. Тийм ээ, тийм ойлгож байгаа. Тэгэхээр би Батсуурь гишүүн ээ, тэгээд хариулаадахъя.

Тэгэхээр бид нарт бол үүсэж байгаа гол хүндрэл бол уул уурхайн салбарын өсөлт байгаа юм. Саяхан 15 юу, 19, 18 онд 1 тэрбум долларын нүүрс гаргая гээд ярьдаг байсан юм байна лээ. Батсуурь гишүүн ээ, 1 тэрбум долларын нүүрс гаргая гээд. Тэгээд би тэр бичлэгүүдийг зөндөө харсан л даа. Өнөөдөр 9,6 тэрбум долларын нүүрс экспортолж байгаа. Уул уурхайн салбарын өсөлт өөрөө мэдээж энэ төрийн данхайсан байдал бол өндөр байгаа л даа. Би энэ дээр бол шүүмжлэлтэй хандаж байгаа. Гэхдээ уул уурхайн салбар өсөлт бол зөв бодлого явуулсны үндсэн дээр маш их хэмжээгээр өссөн. Энэтэй бол нэг их маргаад байхгүй байх гэж бодож байна. Энэ хэрэглээг бид бас хангахын төлөө бол ажиллаж байна. Тэгэхдээ сая бол тавигдсан Оросын Холбооны Улсын тэр дотоод асуудалтай холбоотой хориг бол Монголд тавиагүй л дээ. Энэ бол дэлхий нийтэд тавигдсан зүйл байгаа. Тэрнээс маш хурдан хугацаанд гарсан. Гэхдээ тэр хүндрэлээс бид 21 хоногийн тэр хүндрэлээс гарах гээд л энэ олон асуудал давхацсан учраас үүнийг давах гээд л явж явж байгаа.

Ойрын үед бол БНХАУ-ын, тэгээд энэ дахин дахин яриад яах вэ. Энэ асуудлууд шийдэгдээд ирэхээр хөдөө орон нутгийн хангамж бол сайжирчих байх. Байна. Байх аа, биш байна. тэгэхдээ ААН-үүдээрээ дамжуулдаг. Та бас сая үгэндээ хэллээ. Ганибал гишүүн ч хэллээ, Цогтгэрэл гишүүн ч хэллээ. Ямар нийгэмд байгаа билээ, бид. Тэгэхээр хувийн хэвшлийн ААН-үүдэдээ л дамжуулж энэ түр шатахууны асуудал явж байгаа. Энэ хувийн хэвшилүүдээ дэмжих бодлого л барьж байгаа, төр. Түүнээс биш хажуугаар нь ороод л төр өөрөө импортолно, өөрөө бүх цэгүүдэд хүргэнэ гээд яваагүй байгаа. Тэгээд аж ахуйн нэгжүүдийн энэ асуудлыг бол тэр хэдийг л дэмжих ийм бодлого л төр яг үргэлжлүүлээд л явж байгаа. Тэгэхдээ яах вэ, уул уурхайн салбарын хэрэглээ бүр хэд дахин өндөр болсон байна л даа. Тоо баримтыг өөрөө хараад бол та бүхэн өөрөө хараад уншиж байгаа байх. 30

мянган тонн шатахуун хамгийн максимумдаа сардаа хэрэглэдэг байсан бол өнөөдөр хэдхэн уурхай нийлээд л 50 мянган тонн шатахуун сардаа хэрэглэдэг болсон. Тэгээд бид бол үүнийг нэг талаараа сайн тоо ч гэсэн, нөгөө талаараа бол үнэхээр эдийн засагт үнэхээр мундаг дэвшилттэй тоо ч гэсэн нөгөө талдаа бол хэрэглээ энэ хэмжээгээр өссөн. Оросын Холбооны Улсаас нийлүүлдэг шатахуунаа л нийлүүлээд байгаа. Үгүй ээ, та нарт бид нар өгдөг юмаа өгч байна шүү дээ гээд байгаа юм. Бид бол дотоод хэрэглээ бол энэ хэмжээгээр өссөн байна. Энд бэлтгэлтэй байсны үндсэн дээр хоригийг бас бид бас бүр тасалчихгүй гарсан. Гэхдээ энэ үүсэж байгаа шокоос бид ойрын хугацаанд гарахаар бүх талаас нь ажиллаж байна. Би түрүүний гишүүдийн асуултад хариулахдаа бол тодорхой хэлсэн. Аж ахуйн асуудлаар л хандаж байгаа. Түүнээс биш нэг зүгээр нэг төрийн нэг цагаан гартан шиг нэг 2 бичиг явуулчихаад л юм уу, утсаар ярьчихаад л сууж байгаа юм бол алга байна. Бүх талаас нь ажиллаж байгаа. Үүнийг бол хариуцлагатайгаар хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Манай улс дээд тал нь 17-18 сая толгой мал эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой. Тэгэхээр эдийн засгийг ингэж эргэлтэд оруулаад бүгдийг дотооддоо хэрэглэх боломжгүй. Тийм учраас 50 % түүнээс дээших нь бол гадагшаа экспортод зайлшгүй гарах ийм шаардлагатай. Үүнийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бүхий л талаар дэмжиж, тэр түрүүнд нэг биш удаа хэллээ дээ, квотыг байхгүй болгосон. Бүх төрлийн махан дээр. Нэг цонхны бодлогоор цахимжуулж шуурхай, экспортын зөвшөөрөл бүх юмыг гаргаж байгаа. Үүний үр дүнд ч махны экспорт бол өнгөрсөн жилийнхээс 4 дахин нэмэгдсэн. Гэхдээ бид нар үнэ дээр хэтэрхий зах зээлийн үнэ дээр хатуу оролцож, яам

болж чадахгүй. Болохгүй ээ. Өөрөө сая хэллээ. Батсуурь гишүүн. Махны үнийг тэдэд барина. Тэдээс хойш буулгахгүй ээ гэж амламаар байна гэж. Тэгж амлахгүй. Өнөө Улаан сайд ноолуур үнийг 100 мянга түүнээс дээшээр авна гээд нэг буруутдаг. Түүн шиг зах зээлийн үнэд тэр хэтэрхий оролцох нь бол өөрөө утгагүй гэдгийг хэлье.

Харин бүхий л борлуулах экспортлох ийм боломжийг хангаж ажиллана. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хуучин 2 ашиг сонирхлын дунд байсан, нэг нь болохоор үндсэн манай малчид, хөдөө орон нутгийнхныхаа эдийн засгийг чадавхжуулах, махны үнийг үнэтэй болгох ийм сонирхол яамны үндсэн сонирхол байдаг. Мал махны үнийг. Гэтэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр бол нийслэлийг хямд махаар ханга, нөөцийн махыг бэлтгэ гэдэг ийм үүрэгтэй явж ирсэн. Бид 24 оны 01 сарын 01-нээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, нийслэлийн махны тэр нөөцийн мах бэлтгэх үүргийг хүлээхгүй. Нийслэлд нь ч Засгийн газрын тогтоолоор шилжүүлсэн. Тэр бол нийслэлийн үүрэг. Яагаад гэвэл нийслэлд нь бүх зорь нь байна, худалдааны сүлжээ нь байна, нийслэлийн аж ахуйн нэгжүүд, компаниуд авч байна. Тэгэхээр энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд үндсэн хөдөө орон нутгийнхаа малчдын мал махыг үнэтэй байлгах, экспортод үнэ цэнтэй гаргах энэ тал дээр бодлого болгон ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна.

Ж.Батсуурь: Хориг, доллар янз бүрийн тайлбар сонсмооргүй байна. Яг энэ саналыг сарын өмнө тавьж байсан. Яг л ийм тайлбар өгч байсан. Сарын дараа байдал нөхцөл хэвийн болохгүй улам дордож байна. Ахиад л ийм хариу авч байна. Түүн дээр бас анхаарах ёстой байх гэж ингэж бодож байна. Энэ жил бол сонгуулийн жил. Та бүхэн ноолуурыг

хүн өөрөө 60, 70 мянгаар тогтчихоод байхад нь бид нар 100 мянгаар авна гээд хүсээгүй байхад нь дансанд нь мөнгө нь ороод л байсан. Тэгэхээр энэ жил бас сонгуулийн жил л дээ. Тийм болохоор энэ хүмүүсийг ядарч зүдэрч байхад нь олон жилийнхээ хөдөлмөрийг жалга руу устгачихаас нь өмнө энэ махны үнийг нэг удаа бол барих боломжтой. Өдий төдий их наядаар нь ямар ямар юманд зарцуулагддаг билээ. Бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй гэж ингэж ... /минут дуусав/

Г.Занданишатар: Санал хэллээ. Байхгүй, дууссан. Харин та хугацаандаа дуусчихсан байсан.

13 цагаас даргын дэд зөвлөлийн хуралтай. Тэмүүлэн гишүүн, Одонтуяа дарга нар 13 цагийн хуралтай болно.

Тэгээд ямар санал хэлэх гэсэн юм та. 2 минут. Содномын Чинзориг гишүүн сайд.

С.Чинзориг: Тэгэхээр энэ өвөлжилтийн асуудал жилийн жилд л яригддаг. Тэгээд дандаа өвөлжилт хүндэрсэн хойно л бид нар араас нь хөөцөлдөөд л олон жил боллоо. Манай Өвөрхангай аймаг 17 оноос эхлээд 22 он хүртэл сүүлийн нэг 6 жил дандаа бас өвөлжилт, хаваржилт хүндрээд, гаднын аймгууд асар их хэмжээний олон тооны малчид бас гаднын аймагт оторлож, өвөлжиж хаваржин маш хүнд байдалтай бол явж байна шүү дээ. Энэ жил арай гайгүй зуншлага гайгүй болсон. Арай гайгүй нутагтаа өвөлжих нь үү гэж байтал бас цаг хүндрээд цас их орсон учраас бас өвөлжилт хүндрэх тийшээгээ л болчихлоо л доо. Энэ жилийн нэг онцлог нь эхний цас орохын өмнө бороо орж байгаад цас орчихсон, дараагаар нь жоохон дулаараад нэлээн бас гөлөө үүсээд мөстлөг бас үүсчихсэн. Энэ давхар давхар мөсөн бүрхүүл тогтчих, мал цаашидаа ингээд жоохон хүндэрвэл өвөл бэлчээрлэх боломж хязгаарлагдмал ийм юм руу л явах нь

нэлээн онцгой хүндрэхээр гэж. Тэгэхээр энэ дээр нэг санал байгаа юм, дарга аа. Би байнга л ярьдаг юм.

Одоо бид нар ингээд цаг хүндэрсэн хүн л яриад байх юм. Ер нь энэ МАА-н талаар баримтлах нь төрийн бодлогоо шинэчлэх цаг болсон юм биш үү? Би байнга ярьж байгаа. ХААЯ тодорхой юм хэлэхгүй юм. Малчдын талаар баримтлах бодлогоо бас шинэчилмээр байна. Алийн болгон бидний ярьдаг энэ уламжлалт аргаар хаяа багадвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг зарчмаар чинь энэ МАА-н үйлдвэр чинь явах боломжгүй болчихоод байна шүү дээ. Энэ МАА-н талаар төрөөс баримтлах бодлого, малчдын талаар төрөөс баримтлах бодлогоо шинэчилж авч үзмээр байна. Энэ малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, механикжуулах асуудал ч гэсэн яримаар байна шүү дээ. Бүхий л үйл ажиллагаа нь дандаа гар үйл ажиллагаатай, хөдөлмөр зарцуулалт бол асар ихтэй ийм хүнд хөдөлмөр. Тийм учраас дарга аа, би нэг санал хэлэх гээд байгаа юм.

Ер нь Их Хурал даргын захирамжаар нэг МАА-н талаар төрөөс баримтлах бодлогын бичиг баримт боловсруулах, малчдын талаар баримтлах бодлого боловсруулах ажлын хэсэг гаргамаар байна. Тэгээд яаралтай үүнийг шинэчилмээр байна. Төрийн бодлого авч үзэхгүй бол ... /минут дуусав/

Г.Занданишатар: Зүйтэй. Чуулганы нэгдсэн хуралдаанаар өвөлжилтийн нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын мэдээллийг сонслоо.

Үүнтэй уялдуулан 2 чиглэлээр ажлын хэсэг байгуулж, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

1 дүгээрт, ойрын хугацааны шийдэл, арга хэмжээний чиглэлээр.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хамтраад энэ чиглэлээр хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж, ЗГ, Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нар, Сангийн сайд нар энэ хэрэгжилтийг яаралтай хангаж энэ арга хэмжээ ав. Ирэх 7 хоногт багтаж хэрэгжүүлнэ.

1 дэх асуудал бол энэ дизель түлшний хангамжийн асуудлаар. Дизель түлшний хангамжийн асуудал бол нэг мөр зөв ойлголт өгөх нь олон улсын харилцаа, эдийн засгийн харилцаа бүх талдаа чухал байгаа юм. Манай улсын экспорт түүхэн дээд амжилтад хүрч 11 дүгээр сарын 15-ны байдлаар 13,1 тэрбум доллар болсон. Энэ дундаа нүүрс экспорт 7,5 тэрбум доллар болж үндсэндээ бараг 2 дахин өслөө. 2 жилийн өмнөхөөсөө бол.

Газрын тосны экспорт 320 сая долларт хүрсэн. Ингээж нөгөө уул уурхайн үйлдвэр сэргэхээр чинь 1,5 дахин сэргэхээр дагаад дизель түлшний импорт 1 тэрбум долларт хүрч өнгөрсөн оны биет хэмжээнээсээ бол 40 %-аар өссөн байгаа юм, 40%-аар өссөн, бараг 1,5 дахин өссөн гэсэн үг. Энэ бол эдийн засгийн төлөвлөлт буруу хийгдэж, энэ экспорттойгоо уялдуулж, дизель түлшнийхээ захиалгыг л дутуу өгсөнтэй холбоотой. Ийм хомсдол үүссэн байна.

Дээр нь энэ дизель түлшний нэмэгдэл захиалгуудыг өөр газраас татаж байгаа учраас тээвэрлэлтийн асуудал гарсан. Тээвэр ложистикийн улмаас. Тэгээд энэ бол цэвэр зохион байгуулалтын асуудал шүү. Өөрөөр хэлбэл дизель түлшний зөвхөн хэрэглээ 1,5 дахин нэмэгдээд байна шүү дээ. Тэрнийгээ хангах хэмжээний нийлүүлэлт нь тогтвортой байхад ингээд янз бүрийн тайлбар байдаг. Ийм учраас яг тээвэрлэлт, захиалгын асуудлыг эдийн засгийн төлөлтийг маш сайн хийж, яг графикийн дагуу нийлүүлэхээр ийм тохиролцоо хийгдээд сая Оросын төмөр замаас, Засгийн газраас бүр тусгай

хүмүүс томилж нийлүүлэлтийг тогтворжуулах ажлыг бидний өмнөөс хийж өгч байна. Манайх харин захиалгаа бүрэн дүүрэн өгч энэ өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээндээ тохируулж захиалгаа өгч хэвших хэрэгтэй байна.

Дунд хугацааны шийдэл нь бол энд газрын тосны үйлдвэрээ яаралтай ашиглалтад оруулах талаар ЗГ идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй байна. Энэ удаад байна.

2 дугаарт нь, энэ цаг агаарын мэдээ, урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах, хүлээн авах, хүргэх энэ ажлын нэгдсэн ийм тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Аймаг, сумын Засаг дарга нар, багийн дарга нар хүртэл хүргэдэг. Мэдээллийн технологи хөгжсөн энэ эрин үед зөвхөн зурагт, радио, телевиздээ найдаад суух биш бүхий л арга хэрэгслээр нэг тохироод энэ цаг агаарын ийм мэдээ, мэдээллийг дамжуулдаг тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Үүнийг Шадар сайд ахлаад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийн төвтэйгөө уялдуулаад, үүнийг түргэн шуурхай хүн болгондоо хүргэдэг, малчдадаа хүргэдэг, энэ гар утас, мэдээллийн технологи бүх сүлжээг ашигласан энэ тогтолцоогоо яг биелүүлж малчид ч гэсэн тэрүүгээр байнга мэдээгээ хүлээж авдаг хэвшил соёлыг нь бий болгох, яг энэ шугамаар нь хүргэдэг энэ цаг агаарын мэдээний цаг уур мэдээллийн албаныхан тохиролцож нийтэд зарлаж мэдээлэх хэрэгтэй. Тайван цагт энэ мэдээллийнхээ тогтолцоог тодорхой болгох хэрэгтэй.

3 дугаарт, энэ мал, мах бэлтгэлийн тогтолцоо, эрүүл мэндийн үйлчилгээ. Энэ тогтолцоо, энэ бэлтгэлийн ажил, экспортын асуудал, мал махны борлуулалтын асуудал дээрээ түүхий эд бэлтгэлийн тогтолцоогоо шуурхай ажиллуулах хэрэгтэй. Тэгээд бие бие рүүгээ чихээд нөөцийн мах байхгүй гэж ярьж байна. Дэлхийн бүх улсад улирлын шинж чанартай хангамж борлуулалтын асуудлыг төрөөс

зохицуулдаг. Тэгээд энэ чинь эцсийн дүндээ энэ нөөц бэлтгэхгүй малчид 2, 3 жил малынхаа хойноос хөөцөлдөж явж, хөдөлмөрөө зарцуулж байгаад, зарсан тэр үнээс дунд нь ченжийн олж байгаа ашиг нь их байдаг. Ийм учраас энэ мал мах бэлтгэлийн тогтолцоогоо их оновчтой болгох, эцсийн хэрэглэгч болон үйлдвэрлэгч 2-ын холбоог бий болгож, аль алинд нь ашигтай байх энэ нөхцөлөө бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байгаа юм.

2 дугаарт, 1 дэх өдөр бүлгийн хурлын дараа хөдөөгөөс сонгогдсон гишүүд нэгдэж, энд энэ талаар Тэмүүлэн гишүүн үг хэллээ. Цогтгэрэл гишүүн үг хэллээ. Чинзориг гишүүн ч үг хэллээ. Энэ ойрын хугацааны шийдлээс гадна дунд хугацаа, урт хугацааны шийдлийг ажлын хэсэг байгуулаад бид боловсруулсан байгаа. Малчин өрхүүдийн нэгдсэн холбоо буюу Мөнххолбоог байгуулах ТЭЗҮ-ийг ХААИС, МУИС-ийн эрдэмтэн судлаачидтай хамтарч Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүдийн хамтарсан ажлын баг бол төсөл боловсруулсан. Үүнийг нэг дэх өдөр танилцуулна. Энэ Мөнххолбоо энэ малчдын түүхий эд бэлтгэлийн систем, энэ цаг агаар, нийгмийн хамгааллын асуудал, зээл, санхүүгийн үйлчилгээ, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үүнийг бүгдийг нь цогцоор хангах энэ Үндсэн хуулийн зарчимд нийцүүлсэн шинэ төсөл боловсруулж байгаа юм. Энэ бол зөвхөн хуучин нэгдлийг сэргээе гэсэн үг биш. Монгол Улсын Үндсэн хуулийн 58.1-д сум бол нийгэм эдийн засгийн цогцолбор байна гээд заачихсан. Нийгэм эдийн засгийн цогцолбор. Үүнийгээ Чимэд гуай бол юу гэж тайлбарласан бэ гэхээр корпорац гэдэг үгийг корпорат боди буюу корпорацын шинж чанартай өөрөө өөрийгөө санхүүжүүлэх байгууллага байна гэсэн ийм агуулгатай томъёолол юм гэж тайлбарласан байдаг. Сүүлд нь.

Өөрөөр хэлбэл бол сум өөрөө өөрийгөө авч явдаг эдийн засгийн нэгж биш нийгэм эдийн засгийн нэгж биш, төсвөөс дандаа бүх асуудлаа шийддэг

байх. Өнгөрсөн 70 жилийн хугацаанд бол бүх сум өөрийнхөө өөрийнхөө хөрөнгөөр бүх асуудлаа шийдсэн юм байна лээ. Барилга байшингуудаа, газар тариалан, малчдын нийгмийн асуудлаар шийдэж байсан ийм нэгж байсан байгаа юм. Тэгээд энэтэй нийцүүлээд энэ Мөнх гэдэг холбоог шинээр байгуулах асуудлыг Хэнтий, Баянхонгор гээд нэлээн олон аймгуудад байгуулчихсан. Үүнийг улсын хэмжээний байгууллага болгох шаардлага байгаа юм.

Ингээж байж энд малыг эрүүлжүүлэх асуудал нэгдсэн зохион байгуулалтад орно. Мал эрүүл бол үүнийгээ экспортлох ажилд нэгдсэн зохион байгуулалтад орно. Энэ Мөнх холбооны дэргэд банкны үйлчилгээ, малчдад үзүүлэх банкны үйлчилгээ, малчдын даатгалын үйлчилгээ, сая индексжүүлсэн даатгал гээд байна. Даатгалын үйлчилгээ, түүхий эд бэлтгэл, маркетингийн тогтолцоо, ноос ноолуур, арьс шир, мах махан бүтээгдэхүүнийг бэлтгэж нийлүүлдэг үндэсний үйлдвэрлэлүүд хөгждөг. Ингээд эцсийн дүндээ малчдын нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдсэн ийм тогтолцоо бий болгож байж энэ малчдын нийгмийн асуудлыг дунд, урт хугацаанд шийднэ. Энэ Монгол Улсын нийт иргэдийн хүнсний хангамжийн асуудлыг ч шийднэ. Энэ бол дэлхий нийтийн чиг хандлага, дэлхий нийтийн чиг хандлага үүнийг бол шийдэж байгаа юм. Яагаад вэ гэхээр дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалаад дэлхий өөрчлөгдөж байна. Үүнийг жалгын нэг, талын нэг тарсан малчин дангаараа, ганцаараа шийдэх ямар ч бололцоогүй. Нэгдэж, хамтарч корпорацын шинж чанартай болж байж Үндсэн хуульд заасан зарчимтай нийцүүлж байж, энэ бэрхшээлийг давж туулна. Газар хөдлөлт, цасан шуурга, дэлхийн энэ байгалийн гамшиг үзэгдлийн тоо эрс нэмэгдэж байна. Тэрэнтэй дасан зохицох өөрчлөлт хийх шаардлага ийм л хэлбэрээр хийгдэж байна. Дэлхий дээр.

2 дугаарт нь, зах зээлийн үеийн нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд

нийцсэн ийм зохион байгуулалтад орохгүй бол феодалын үеийн талын нэг тарсан, амиа аргацаасан аж ахуйн нэгжүүд зах зээлийн хөгжилд нэгдэн орох бололцоогүй гэдэг онолын хувьд МУИС, ХААИС-ийн эрдэмтэд ч гэсэн нотолж байгаа. Үүнийг хоршооны сүүлийн үеийн хөгжлийн загваруудаар хоршоодтой хамтарсан уулзалт зохион байгуулж тодорхойлсон. Тэгээд үүнийг ажил болгох хэрэгтэй байгаа юм. Энэ бол дунд, ойрын хугацааны шийдэл. Тэгэхгүй бол ингээд л цасан шуурга, өвөл болгоны үеэр өмнө нь нэг ингэж эхэлж халти ярилцаад л тэгээд 1 гал унтраасан арга хэмжээ авч, авсан төдийгөөр дэлхийн хэмжээгээр өөрчлөгдөж байгаа цаг уурын өөрчлөлт, дэлхийн дулааралтай тэгээд нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй уялдаж энэ МАА оршин тогтнох асуудал бол хүндрэлтэй болж байна. Залуу малчдын халаа үндсэндээ байхгүй болж байна. Дөнгөж хорин тавхан хувь болсон, 50 % байдаг байсан бол. Малчдын нийгэм эдийн засгийн асуудал алдагдаж байна. Малыг эрүүлжүүлэх асуудал, мал үржлийн асуудал алдагдаж байна. Эрүүл мэндийн үйлчилгээ алдагдаж байна. Боловсролын үйлчилгээ алдагдаж байна. Тэгэхээр энэ бол ер нь бол тэр өнгөрсөнтэй зууралдах юм бол маш олон алдаа дутагдлыг ярьж болно. Одоо ирээдүйгээ харсан энэ шийдлийг бол бид анхаарч шийдэх шаардлагатай байна.

Ийм 2 чиглэлээр ойрын хугацааны асуудлууд, дунд, урт хугацааны шийдэл гэсэн 2 чиглэлээр нэг дэх өдөр ажлын хэсгүүд байгуулагдаж, тодорхой шийдлүүд гарна.

Түлшний хангамжийн асуудал бол тогтворжиж байгаа. Бид яриад, тээвэрлэлтийн асуудал, зохицуулалтын асуудал, нийлэлтийн асуудлыг нэмэгдүүлсэн. Харин энэ төлөвлөлтөө сайн хийж, захиалгаа өгөх хэрэгтэй. Аль ч аж ахуйн ажил захиалга дээрээ үндэслэж байтал нийлүүлэлт хийгдэнэ шүү дээ. Энэ дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Ийм 2 чиглэлийн ажлын

хэсэг байгуулна. Энэ чиглэлээр Тэмүүлэн гишүүний гаргасан саналыг Сангийн яам. Энэ өвөл бол урт болно шүү. Цаг уурын дарга ирсэнгүй. Түүнээс биш ийм эрт цас орсон, шилэн мөсөн зуд гэж яригддаг ийм шилэн мөсөн зудын нөхцөл байдал бий болохоор эрт цас орсон юм дарагдахаар. Тэгээд энэ цаг уурын дарга сая ирсэн байна. Энэ иргэдэд яаж мэдээлэл хүргэж байх юм, яаж хариуг нь авч байх юм, яаж энэ дээр урьдчилан сэргийлж байх юм гэсэн тогтолцоогоо гараад яриад та хэд нийт ард иргэд мэдэгд. Гэнэтийн асуудал болдог, дараа нь ахиад л ниргэсэн хойно хаширчихсан сууж байж таарахгүй. Ийм ойрын хугацааны шийдэл, дунд хугацааны шийдлээр нэг дэх өдөр эргэж бид ярилцана. Нэг дэх өдөр хөдөөгөөс сонгогдсон 50 гишүүн байгаа, 50 гишүүн, бүлгүүдийн хурлын дарга аа. Энэ ойрын болон дунд хугацааны шийдлүүдийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсоно.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар цаг үеийн асуудлаар мэдээлэл сонслоо.

Ажлын хэсэгт баярлалаа.

13.18 цаг

Одоо даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай. Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд.

Дууслаа. 14 цагаас чуулган үргэлжилнэ.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

С.Одонтуяа: Үдээс хойших чуулганы хуралдаанаа эхэлье.

Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршилага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан тус Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргалыг нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Жигжидийн Батжаргал нь 1976-1986 онд Төв аймгийн Зуунмод сумын 2 дугаар дунд сургууль, 1986-1990 онд МУИС-ийг Банкны эдийн засагч мэргэжлээр, 1994-1996 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерээр тус тус төгссөн.

Жигжидийн Батжаргал нь 1992-1994 онд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын орлогч, 1996-2000 онд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, 2000-2002 онд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг дарга, 2002-2012 онд Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, 2016-2020 онд Төв аймгийн Засаг дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд даргаар сонгогдон ажиллаж байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их

Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүд 76,9 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тлеуханы Аубакир танилцуулна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны дарга сонгох тухай асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Энхтайваны Бат-Амгалан танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан нь нийслэлийн ерөнхий боловсролын 51 дүгээр сургуулийг 1991 онд, Багшийн сургуулийн хөгжмийн ангийг багш мэргэжлээр, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 1999 онд Монголын хэвлэлийн хүрээлэнг сэтгүүлч

мэргэжлээр төгссөж, 2004 онд Удирдлагын академид Нийгмийн ухааны магистр зэрэг хамгаалсан байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан нь 1995-1997 онд МҮОНТ-ийн хөтлөгч, редактор, 1997-2000 онд Монгол Улсын Дээд шүүхэд хэвлэлийн төлөөлөгч, 2000-2002 онд Эм Си Эс группт менежер, 2002-2004 онд Ийгл телевизийн Борлуулалт маркетингийн албаны дарга, 2004-2014 онд Ийгл телевизийн гүйцэтгэх захирал, 2015-2016 онд Олон улсын пресс клубүүдийн холбооны ерөнхийлөгч, 2016-2020 онд Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2020 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг нэр дэвшүүлсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Одонтуяа: Баярлалаа. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийн Улсын Их Хуралд сонгогдон ажилласан турилага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад улируулан сонгохоор нэр дэвшүүлэх тухай Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн саналыг Улсын Их Хурлын гишүүн Энхболд танилцууллаа.

Баттөмөр нь 1979 онд ХААИС-ийг инженер механик мэргэжлээр, 1991 онд ОХУ-ын Москва хотын Нийгэм, улс төрийн дээд сургуулийг Эдийн засагч, улс төр судлаачийн мэргэжлээр, 2001 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн.

2003 онд Эдийн засгийн ухааны доктор, 2008 онд Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан. 1980-1986 онд Ой модны аж үйлдвэрийн яаманд мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1986-1989 онд Хөнгөн үйлдвэрийн яаманд хэлтсийн дарга, 2000-2008 онд Гаалийн ерөнхий газрын дэд дарга, дарга, 2011-13 онд Монголын Үндэсний татварын ерөнхий газрын дарга, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар тус тус ажилласан.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийг

нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүд 66,7 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Батсүхийн Саранчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Инновац, цахим бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн гишүүн Идэрбат Монгол Ардын намын бүлгээс Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад Энхбаярын Батиугарыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан улируулан сонгохоор нэр дэвшүүлж байгаагаа танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.Батиугар нь 1994 оноос 2000 онд Нийслэлийн 14 дүгээр дунд сургууль, 2000-2004 онд АНУ-д бүрэн дунд боловсрол эзэмшиж, 2004-2008 онд АНУ-ын Бенглигийн их сургуулийг Эдийн засагч, санхүүч мэргэжлээр тус тус төгссөн.

Э.Батиугар нь 2008-2011 онд Жэй Пи Морган банканд Хөрөнгө оруулалтын банкир, 2011-12 онд МАХН-ын Гадаад харилцаа хариуцсан нарийн бичгийн дарга, 2012-2016 онд Монголбанкны дэд ерөнхийлөгч, 2016 оноос 21 онд Медиа Холдинг ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, 2021 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар тус тус ажилласан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны даргад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Э.Батиугараас асуулт асууж, үг хэлээгүй болно. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугарыг Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар улируулан сонгох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Саранчимэг гишүүнд.

Нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Ингээд байхгүй байгаа учраас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Жигжидийн Батжаргалыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Дараа нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Балжсиннямын Баярсайханыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт, дараа нь Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар

Баагаагийн Баттөмөрийг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор, Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Энхбаярын Батиугарыг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллуудаар санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлэн байна уу?
Санал хураалт.

Энэ санал хураалт бол туршилтын санал хураалт биш, жинхэнэ санал хураалт байсан учраас Тогтохсүрэн даргын санал хураалтыг дэмжсэнээр тооцож, протоколд тэмдэглүүлье. Ингээд 23 гишүүн дэмжиж, 18 гишүүн татгалзсанаар тооцсугай.

Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Жигжидийн Батжаргалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явууллаа.

Одоо Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Балжиннямын Баярсайханыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар Баагаагийн Баттөмөрийг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Энхбаярын Батиугарыг дахин сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул зарим “Байнгын хорооны дарга нарыг сонгох,

чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1. Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалыг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханыг тус тус сонгосугай.

2. Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугарыг, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөрийг тус тус улируулан сонгосугай.

3. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

14.26 цаг

Дараагийн асуудалд орно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Эрхэм гишүүд ээ, өнөөдөр энэ хуулийг эцэслэн батлах шаардлагатай байгаа. Тийм учраас энэ хуулийн хэлэлцүүлгийн дараа эцэслэн батлах санал хураалт явуулах учраас намын бүлгийн дарга нар ирцийг бүрдүүлж, гишүүд иж бүрэн ирцтэйгээр чуулганы хуралдаанд оролцохыг дуудъя. Тамгын газар гишүүдийг дуудаж, ирцэд оруулна.

2 дугаарт нь, сая Даргын дэргэх зөвлөлөөр ирэх 7 хоногийн хэлэлцэх асуудлын тов дарааллыг баталсан. Нэг дэх өдөр бүлгийн хурлын дараа хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд өнөөдрийн хэлэлцсэн хэлэлцүүлэг, цаг үеийн шинжтэй өвөлжилтийн бэлтгэлийг хангах өвөлжилтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ойрын болон дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөөнтэй. Энэ асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар сонгогдсон Жигжидийн Батжаргал гишүүн зохион байгуулна. Танхим жич зарлана. Тэгээд гишүүд идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Ингээд Сарангэрэл гишүүнийг индэрт урьж байна. Үгээ хэлэхийг хүсэж байна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг

орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 4 санал, хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул мөн зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 3 саналаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Зочид танилцуулъя. “Хөгжилд эмэгтэйчүүд” зөвлөгөөнд оролцож байгаа Монголын эмэгтэйчүүдийн холбооны Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн гишүүд, бүсгүйчүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хонгор нутгаас зорин ирсэн Хонгор нутгийн бүсгүйчүүддээ эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эхчүүд, эмэгтэйчүүд маань энх амгалан, сайн сайхан бол эх орон энх амгалан сайн сайхан байна. Ингээд эмэгтэйчүүддээ, Хонгор нутгийн бүсгүйчүүддээ хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Протоколд тэмдэглэгдэх учраас ямар ч байсан ажлын хэсгийг танилцуулъя. Хожим хойно энэ тэмдэглэгдэж үлддэг гэдгийг сануулаад. Борхүүгийн Дэлгэрсайхан Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга. Дэлгэрсайхан сайд байхгүй бол хууль хэлэлцэхгүй шүү. Хууль хэлэлцүүлж байгаа сайд байхгүй бол асуудлыг хойшлуулдаг дэгтэй.

Ингээд сайд байхгүй учраас энэ асуудлыг хойшлуулаад дараагийн асуудал эхэлчихье. Тэгвэл тендер дуусахаар л хэлэлцэх юм байна даа. Чадахаараа л

яаралтай хэлэлцүүлээ. Өглөөнөөс авхуулаад л хэлэлцүүлээ. Одоо тэгээд сайд нар байхгүй бол дэг нь тийм юм.

Энэ хатгагч, амжигч нар бас тэгээд байх юм бол хэлэлцүүлгээ хэлэлцчихье. Юу ч болсон ажлын хэсгийг танилцуулж байя. Пүрэвийн Сайнзориг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан I дүгээр орлогч, Дорждэрэмийн Цолмон Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх, Дэндэвийн Энхтуяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, Жаргалсайханы Ичинноров Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга, Ганбатын Ганхүү Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга, Дангаагийн Авирмэд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч, Маньбазарын Говьсайхан Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал, Мөнхбаярын Уранбилэг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төслийг хэрэгжүүлэх нэгж Улсын тооцоот үйлдвэрийн газрын Гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн.

Энэ татвар тооцоотой асуудал дээр Сангийн яамны Бямбарагчаагийн Тэлмүүн байсан. Байхгүй байна. Өчигдөр байсан ажлын хэсэг байхгүй. Сангийн яам энэ дээр чинь хамгийн чухал энэ дээр чинь. Ажлын хэсэг байхгүй. Тэлмүүн. Тэгээд энэ дээр тэр 5, 6 асуудал дээр Ерөнхий архитектурын эрх үүргийг шилжүүлэх асуудал, дараа нь хэн хариуцлагыг хүлээж тэр хот төлөвлөлт, Улаанбаатар хотын төлөвлөлт, тэгээд тэрэнтэй холбоотой зөвшөөрлийн журам энэ тэрийг яаж хэрэгжүүлэх юм. Олон маргаантай асуудал байна гэж бас надад хэлээд байгаа. Манай Тамгын газар энэ дээр эрх зүйн дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзээд байгаа юм. Тэгтэл энэ холбогдох Сангийн яам энэ тэр хүмүүс байхгүй учраас хэлэлцэхэд хэцүү байна.

*Ийм учраас асуудлыг хойшлууллаа.
Энэ 2 хүнээ авчирч байж хэлэлцүүлнэ.*

14.34 цаг

Дараагийн асуудалд орно.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Алх цохисон, өнгөрсөн. Дэлгэрсайхан сайд байхгүй. Хамгийн гол нь Сангийн яам алга байна. Сангийн яамны Бямбарагчаагийн Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Тлеуханы Аубакир танилцуулна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр

сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, хаана байна? Ирсэн байна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун хаана байна? Аюушжавын Нарантуяа Мал

эмнэлгийн ерөнхий газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Басангийн Батсүх Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ баталгаажуулах газрын дарга, Гончигжавын Батмөнх Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтсийн дарга, Хөхөөгийн Алтангэрэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлагч шинжээч, Гончигдоржийн Шүрэнчулуун Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтсийн гаалийн улсын байцаагч, Пүрэвийн Түмэнбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Худлаа хэлцгээсэн. Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандсан. Автобусны тендер шалгаруулж байгаа гэж худлаа хэлсэн. Хойно хуралтай явж байхыг би дөнгөж хараад сая орж ирж байхад Тендерийн хорооны хурал, үгүй ээ тендерийн хуралтай хот дээр байгаа гэж сая мэдээлэл өгсөн. Энэ асуудал хэлэлцэж байна. Үүний дараа ярилцъя. Хэлэлцэх эсэхээ бодъё.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд асуулт. Гишүүд асуулт байхгүй байна. Тийм ээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамлын тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх буюу хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

Энэ эцэслэн батлах бэлтгэл хангуулах юм бол дараа нь ойлгож байна.

Өнөөдөр тэгээд энэ нийслэлийн хууль байна шүү дээ. Нийслэлийн хууль эцсийн хэлэлцүүлэг хийлээ гэхэд эцэслэн батлагдах ирц бүрдүүлэх хэрэгтэй байна. 39-өөс дээш гишүүний ирцтэй болж байж энэ хуулийг эцэслэн батална шүү дээ. Тийм учраас 39 гишүүний ирц бүрдүүлж байж энэ асуудал бараг хэлэлцэх болчихоод байна шүү дээ.

Ажлын хэсэгт баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлчихсэн. та бүхэнд амжилт хүсье.

14.39 цаг

Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх буюу хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

39 гишүүнийхээ ирцийг бүрдүүл, Дэлгэрсайхан гишүүн ээ. Тэгвэл танайхыг хэлэлцүүлнэ. 39-өөр эцэслэн батална. Зургаахан санал хураалттай.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тлеуханы Аубакир хэлж танилцуулна. Аубакир гишүүн л урагшаа дайруулаад өгье. Малгайгаа өмсөөд ирчихсэн гээд байгаа учраас.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга. эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал. амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасныг баримтлан Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрөөтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн анхны төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг

та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүд түрүүчийнхтэй мөн адил.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсэг Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Аюушжавын Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Басангийн Батсүх Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт баталгаажуулалтын газрын дарга, Гончигжавын Батмөнх Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хэлтсийн дарга, Хөхөөгийн Алтангэрэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч, Гончигдоржийн Шүрэнчулуун. Шүрэнчулуун алга байна. Пүрэвийн Түмэнбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Байнгын хороо Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Баярлалаа, дарга аа. Би сая дарсан, миний энэ нөгөө аппарат жоохон буруу ажиллачих шиг боллоо. Би уг нь дэмжээд байгаа юм. Дэмжсэн

санал өгсөн юм. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгоод, дахиж санал хурааж өгөхийг хүсье. Горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна.

59,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт.

56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжжүүлъя.

14.45 цаг

Болорчулуун гишүүн ээ, танай дараагийн хууль юу билээ?

Түгжрэлийн хууль хэлэлцэхгүй ээ, 39 гишүүнээ бүрдүүлж байж хэлэлцэнэ. 39 гишүүн бүрдүүлнэ гэж бүлгийн дарга нар бүрдүүлбэл хэлэлцье. 39-өөс нааш хэлэлцэхгүй.

“Хөгжилд эмэгтэйчүүд” зөвлөгөөнд оролцож буй Монголын эмэгтэйчүүдийн холбооны Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Алтай нутгийн бүсгүйчүүддээ амжилт бүтээл, алдар нэр, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

39 гишүүний ирц бүрдүүлж чадах уу? Хичээхгүй ээ, яг бүрдүүлнэ гэвэл Дэлгэрсайхан сайд ажлын хэсэг бүрэн үү. 39 гишүүнээ бүрдүүл.

Ардчилсан намын бүлэг дэмжиж байгаа юм уу?

Ингээд Дэлгэрсайхан сайд хүрэлцэн ирсэн бөгөөд 39 гишүүн болгоно гэж байгаа учраас.

Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Энэ Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явна.

Ажлын хэсгийг оруулъя. Энэ Тэлмүүн дарга удаа дараа Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандаж байгаа учраас сануулга өгч байна. Дараагийн удаа Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцох ёстой шүү. Төрийн албанаас чөлөөлөх хүртэл хариуцлага тооцохоор ёстой. Удаа дараа энэ 3 дахь удаагаа давтагдаж байгаа юм. Чуулган дээр худлаа ярина, худлаа мэдээлэл өгнө.

Одоо ингээд энэ дээр нэг асуулт байна. Энэ сайд, дарга нарыг байж байхад асуух гэсэн шалтгаан нь бол энэ Нямбаатар сайд хариулах байх. Энэ аймаг, нийслэлийн ерөнхий архитектурын эрх үүргийг мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр хэрэгжүүлнэ ээ гэсэн ийм заалт байгаа. Энэ чинь хувь хүн гарын үсэг зурдаг, хариуцлага хүлээдэг ийм харилцаа шүү дээ. Тийм ээ. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлт. Тэгээд тэр ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссаны дагуу газар олголттой холбоотойгоор барилга барих зөвшөөрөл ингээд бүх юм л ингээд явж байдаг. Тэгээд энэ бас нэг компанид өмнө нь энэ өндөр барилгын зөвшөөрөл өгдөг болоод бас л нэг баахан авлига, хээл хахууль тэгээд 1 баахан шан харамж авдаг гэсэн ийм л асуудлууд үүсдэг юм. Тэгээд энэ маань сүүлдээ нэг баахан ашиг сонирхлын зөрчлийн асуудал

үүссэн хэл ам болох юм биш биз дээ? Энэ эрхийг нь шилжүүлчихлээ, үүргийг нь шилжүүлчихлээ. Хариуцлага энэ тэртэй уялдаад энэ эцсийн эцэст тэр зөвшөөрлүүдийг чинь хэн гарын үсэг зурж авах юм бэ. Үүнийг яаж зохицуулах юм бэ гэдэг талаар асуулт байгаа.

Ингээд Нямбаатар сайд, Нямбаатар дарга, Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг дарга Нямбаатар хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Занданшатар даргын асуултад маш товчхон хариулахыг хичээе. Манайх энэ нэр томъёоны алдаатай яг өнөөдрийг хүртэл явсан гэж мэргэжлийн байгууллагууд дүгнэдэг. Архитектур гэдэг бол тухайн барилгын хэлбэр хийц, гадаад дүр төрх, тухайн орчиндоо цогцолбор тодорхойлдог албан тушаалтныг хот төлөвлөгч гэдэг албан тушаалтантай хольж хутгаж, өнөөдрийг хүртэл ирсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл Урбан планер гэдэг энэ албан тушаал Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд нь хяналт тавьдаг. Ийм албан тушаал байх ёстой. Гэтэл манай хууль дээр Нийслэлийн ерөнхий архитектор гэсэн ийм нэр томъёогоор орж ирсэн. Тэгээд манай яг өнөөдрийн нийслэлд үүсээд байгаа нөхцөл байдал дээр нийслэл хот маань ерөнхий төлөвлөгөөгүй явж байгаа. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө 2020 дууссан, хэрэгжилт нь дууссан.

Бид нар дотоодын мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар 2040 буюу 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөгөө боловсруулах ажил хийгдсэн боловч БХБЯ, ЗГ дээр өгсөн чиглэлийн хүрээнд гаднын хот төлөвлөлтийн өндөр мэргэжлийн мэргэжилтнүүдээр дахиж 2050-ийг боловсруулж 2040-ийг боловсруулж ирэх үүрэг өгсөн байгаа. Тэгэхээр ингээд 2040-ийг бид нар удахгүй оруулж ирэхээр 2040-ийн манаач нь хэн байх вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр яг өнөөдөр манай бэлтгэгдсэн ийм хот

төлөвлөлтийн ийм өндөр мэргэжлийн бүтэн баг бүрэлдэхүүн манай улсад байхгүй байгаа гэж маш товчхондоо хэлье. Өөрөөр хэлбэл төрийн албаны зохих эрхэлсэн түшмэлийн болзол, шалгуур хангасан, дээр нь энэ 2040-ийн хэрэгжилтэд хяналт тавих ийм боловсон хүчний хомсдолд орсон.

Ийм учраас бид нар 2040-ийг гадаадын өндөр мэргэжлийн байгууллагуудаар боловсруулах тендер зарлаж байгаа. Үүнд хяналт тавьж ажиллах хотын ерөнхий архитектор одоогийн нэр томъёогоор, бид нарын томъёолж байгаагаар хотын ерөнхий төлөвлөгч түүний баг бол илүү өндөр мэргэжлийн албан тушаалтнууд байх боловсон хүчин байх учраас бид нар гаднын инженерингийн компаниудын дунд зөвлөх үйлчилгээ зарлаж, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний чиг үүргийг гэрээ, хуулийн үндсэн дээр гаднын инженерингийн томоохон нэр хүнд бүхий компанид эрх шилжүүлэн ажиллахаар ингээд төлөвлөж байгаа.

Үүнтэй холбоотой зөвшөөрлийн эцсийн хариуцлага бол гэрээлэгч байгууллагын танилцуулсан саналыг үндэслэж, Нийслэлийн Засаг даргад Хот байгуулалтын тухай хуулиар хүлээсэн үүргээрээ эцэслэн баталгаажуулдаг ийм хосолсон хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр бид нар энэ хуулийн заалтыг бичиж оруулж ирсэн гэдгийг хэлье.

Тэгэхээр манай энэ дотоодын ААН байгууллагууд бол энэ саяын тэр хот төлөвлөлтийн баг бүрэлдэхүүнээр үйл ажиллагаагаа явуулах манайд тийм боловсон хүчний нөөц байхгүй ээ гэдгийг би хэлье.

Г.Занданшатар: Ер нь тэгэхдээ Жайкагийн тусламжтайгаар байх аа, нэг Улаанбаатар хотыг 2040 хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө, суурь үзэл баримтлалыг батлаад 17-19 онд суурь үндэслэлийг нь батлаад, тэгээд

үүнийхээ дагуу дүгнэлт гаргаад, суурь үзэл баримтлал, тогтолцоо бүрдээгүй байна гэсэн нэг дүгнэлт гаргаад яваад байсан шүү дээ. Тэгэхээр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө тэр Жайкагийн тусламжтай хийсэн судалгаа, төлөвлөгөө чинь болоогүй гэсэн үг үү, болсон гэсэн үг үү. 20 онд хүртэл хийсэн ерөнхий төлөвлөгөөний чинь хэрэгжилтийг бас хянаж шалгаад 29,6 хувь энэ тэр гээд дүгнэчихсэн. Тэгээд хэрэгжээгүй шалтгаан энэ тэрийг тодорхойлчихсон байгаа шүү дээ. Энэ бүхэнтэй энэ яаж уялдаж байгаа юм бэ?

Хэн хариулах уу. Энх-Амгалан сайд суу, битгий хурал үймүүлээд бай. Энх-Амгалан сайд нааш ир.

Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Тийм. Би энэ 2040-ийн хэрэгжилтийн тайланг уншсан дарга аа. Тэгээд 2040-ийн тайлан үндсэндээ бараг 30 хувь ч хүртэл, 30 хувьдаа ч хүрч хэрэгжээгүй байгаа нэг 4 үндсэн шалтгааныг судлаачид тайлбарласан.

1 дүгээрт, засаглалын тогтворгүй байдал гэдэг зүйлийг хэлсэн.

2 дугаарт, энэ хот төлөвлөлтийн чиглэлийн байгууллага хоорондын уялдаагүй байдал энэ төлөвлөлтийн алдаа гарахад нөлөөлсөн гэдгийг хэлсэн.

3 дугаарт, юуны санхүүгийн хангалттай тийм чадавх бүрдээгүй учраас энэ 2020 хэрэгжээгүй ээ гэдэг ийм үндсэн шалтгааныг хэлсэн.

Одоогийн бид нарын боловсруулчхаад байгаа 2040-ийн манай дотоодын боловсон хүчний баг бүрэлдэхүүний боловсруулаад байгаа 2040-ийн үндсэн концепц бол одоо байгаа Улаанбаатар хотын суурьшлын бүсийн барилгажих дээд хязгаарын хүрээ хязгаарыг тогтоох, барилгажихгүй бүсийн бас хүрээ хязгаарыг тогтоох, цаашид өргөжин тэлж суурьшил шинээр

бий болох бүсчлэлийг 3 түвшинд гаргаж ирэх ийм байдлаар 2040-ийг боловсруулах ажил үндсэндээ боловсруулалтын шатдаа хийгдэж дууссан.

Өмнөх Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийсэн. Засгийн газрын хуралдаан дээрээс энэ 2040-тэй холбоотой боловсруулалтын ажлыг гаднын мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авч байж, гүйцээн боловсруулах ийм чиглэл өгсний үндсэн дээр дараагийн тендер зарлах ийм шатдаа явж байгаа. Бид нар ирэх 7 хоногт гаднын энэ инженерингийн компаниудын дунд хот төлөвлөлтийн туршилага зэргийг харгалзан үзэж, 2040-ийг гүйцээн боловсруулах чиглэлээр нээлттэй тендер, олон улсын нээлттэй тендер зарлаж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Тухайн үед Улсын Их Хуралд танилцуулж байснаар Японы Жайка төслийн шугамаар Алмэк корпорац, Ориентал гэдэг корпорацууд энэ Улаанбаатар хотын хэтийн төлөвлөлт 2040 хүртэлх төлөвлөгөөнөөс судалгааны ажлыг хийж гүйцэтгээд бүр 2009 онд 40 он хүртэлх төлөвлөгөөний суурь үзэл баримтлалыг танилцуулаад ингээд энэ ажил нэлээн л явчихсан л. Тэгээд үүнтэйгээ уялдах юмнууд нь тэгээд үүнтэй л их сайн уялдах ёстой байх шүү. Нөгөө хуульдаа шууд заачхаж байгаа учраас хэцүү болчихоод байна л даа.

Ингээд Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Үүнийг протоколд тэмдэглүүлээд үүнийгээ их сайн анхаарч ажиллахгүй бол нүсэр судалгааны ажил шүү дээ, энэ чинь.

Яах вэ, тэр модификаци хийх юм, ханишийг 1177-гоор тэр тухайн үеийн ханишаар тооцож барьчихсан, тэгээд л тэр үед чинь нөгөө метроны төсөл хүртэл яригдаад л бас нэлээн л нэг иж бүрэн л юмнууд байгаа байх. Тэгэхээр үүнийг уялдуулж Их Хурлаар батлуулж

явах ёстой л доо. Ондoo багтааж та хэд ерөнхий төлөвлөгөөгөө Их Хуралд оруулж ир ээ гээд саяын тогтоолд чинь заачхаж байгаа байхгүй юу. Тийм. Тэгээд би нөгөө гайхаад байгаа юм нь энэ ондоо багтааж ерөнхий төлөвлөлтийг Улсын Их Хурлаар оруулж ирж батлуул гэсэн ийм тогтоол Улсын Их Хурлын тогтоолд заалт орчихсон. Тэгээд ахиад тендер зарлуулаад энэ хугацаанд ерөнхий төлөвлөлтөө хийж амжих энэ хугацаанууд чинь яаж уялдах юм? Тэгээд ерөнхий архитект, тийм, тэгээд энэ тогтоол дээрээ яг тэгээд заачихсан байгаа шүү. Та хэд тэрнийгээ яагаарай. Тэгэхгүй бол бас ахиад л ийм нөгөө олон жоохон зөрчилтэй юмнууд гараад байгаа учраас эднүүсийг нэлээн чамбай анхаарахгүй бол бид нар хэдийгээр яаравчлан нэн яаралтай горимоор хэлэлцэж баталж байгаа ч гэсэн бас хийдэл зөрчил гаргахгүй байхад сайн анхаарах ёсто.

Үүнийг ингэж анхааруулаад ингээд санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу буюу хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулсан санал хураалтуудаар санал хураалт явуулна.

1-т, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсгийг нэмэх:

18.2 Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын эрх, үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

22.1. Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

5 гэдгээ больчихсон уу, тийм ээ. 15-наар оруулах. Санал хураалт.

62,2 хувийн саналаар санал.

Аубакир гишүүн та бүлгийн дэд дарга болох боломжгүй юм байна. Гишүүдийн картмыг сугалаад яваад байж та болохгүй, сануулга өглөө, Танд.

2. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

9.3. Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн эрхийн архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-д заасан мэргэжлийн зэрэгтэй архитектор, Хот төлөвлөлтийн мэргэжилтэн эс үгүй бол мэргэжлийн байгууллага хуулийн этгээд оролцож болно.

9.4. Аймаг, нийслэлийн эрхийн архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5. Энэ хуулийн 9.4-д заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж хариуцлага хүлээнэ. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр үг тасаллаа. Үг хэлнэ Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ хууль дотор бас тэр Авто тээврийн үндэсний төв байдаг гэвэл хаана билээ? Замын дугуй, машин, автомашины дугаар өгч байгаа асуудал. Тэгээд үүнийг бас яг энэ хот руу авчиръя гэдэг ийм бас нэг асуудал явж байсан. Тэгээд энэ дээрээ цаана нь юу байна вэ гэхээр тэндээс орж байгаа орлогыг бас хот руу авъя л гэсэн ийм л зорилго, бодлоготой ийм бодлого юу орж ирж байх шиг байна. Тэгээд энэ дээр чинь тэр авто тээврийн машины дугаарыг олгохдоо бас тодорхой хэмжээний өндөр үнээр борлуулаад тэндээсээ хүүхдийн эрхийн төлөө зарцуулдаг, хүүхдийн асуудлын сайн сайхны төлөө зарцуулдаг ийм зохицуулалтыг бас хийж өгсөн байж байгаа. Тэгээд энэ орлого бас тийшээ ороод явчих юм биш биз дээ. Энэ дээрээ бас яг хэлэлцүүлгийн явцад хассан юм уу, хасаагүй юм уу? Энэ асуулт асууж бас болохгүй байна л даа. Яагаад гэвэл эцсийн хэлэлцүүлэг учраас.

Тэгээд 1 зүйлийг бас хэлэхэд яг энэ танхимд бол өнөөдрийн байдлаар хотоос сонгогдсон гишүүд чинь маш цөөхөн байна шүү. Манай хотоос сонгогдсон ганц гишүүн маань Одонтуяа гишүүн маань сууж л байна. Хотоос сонгогдсон гишүүд ирж энэ хотынхоо түгжрэлийн асуудал энэ тэрийг ярьж, асуудалдаа тодорхой байр суурьтай, дэмжлэгтэй оролцох ёстой шүү дээ. Тийм юмаа хийхгүй байна.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Мөнх-Оргил гишүүн суудалдаа. Хотоос сонгогдсон гишүүдийг дууд. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн хаана байна.

Санал хураалт.

Надад байхгүйг нь зарласан нь амар байна л даа.

Санал хураалт.

66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дэлгэрсайхан сайд аа, энэ Бямбацогт сайд, Ганбаатар сайд, Содномын Чинзориг сайд, Болорчулуун сайд, Даваасүрэн сайд Засгийн газрын гишүүдийг дууд. Санал хураалт дараа нь явуулъя.

Тэгээд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад өгч зарлуул, Пүрэвдорж гишүүн.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн тогтоолын төслийн талаар.

1. Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон Эдийн засгийн байнгын хороо гэсний өмнө Төсвийн байнгын хороо Г.Тэмүүлэн, Төрийн байгуулалтын байнгын хороо Н.Энхболд гэж нэг дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4, 5, 6, 7 дахь дэд заалт тус тус нэмэх,

3. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал Нийтийн зориулалттай орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын орон сууцын байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/ шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх,

4. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,

5. Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-д заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх тохиолдолд Ерөнхий архитекторын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулах,

6. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.3-д заасан журамд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг хамруулах талаар тусгах,

7. Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг цахим платформд бүртгэлтэй зорчигч тээвэрлэдэг иргэн хамаарахгүй байхаар зохицуулах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

62,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Дамдины Цогтбаатар гишүүний яриад байсан нөгөө үүбэрийн асуудал энэ цахим платформд бүртгэлтэй гэдгээр явж байгаа юм байна гэж ойлгож байна.

Нэг. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1. Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

4 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн удирдах гэснийг хассугай. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. санал хураалт.

Тэгэхдээ хуулиа л дагана шүү дээ, Пүрэвдорж гишүүн ээ.

62,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг болон 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.2.4 дэх заалтын аймаг гэснийг тус тус хасаж, 2 дугаар зүйлийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 гэснийг 23 дугаар зүйлийн 23.2.6 гэж өөрчлөх. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төсөл дор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

5 дугаар зүйл. Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын эзэмших ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг Нийслэл, дүүргийн Засаг дарга, Газрын тухай хуулийн 33.1, 44.8 44-ийн итрих 1.5-д заасны дагуу шийдвэрлэнэ. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт явуулна.

Энэ нөгөө силкүүдийг нөгөө харснаараа яг хийсэн биз дээ. Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт явуулъя.

Мягмар дарга тэр силкүүдийг тулгаж үзээрэй. Эцсийн найруулга дээр.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эцсийн найруулга дээр уншаад тулгачхаарай, Энхболд дарга аа, та хэд бас.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

15.09 цаг

Мягмар дарга эцэслэн батлуулахад бэлэн үү?

Одоо хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Эрүүгийн хууль болон дагасан 5 хууль байгаа.

Дэлгэрсайхан гишүүн ээ, гишүүд олж ир, одоо санал хураалт явуулахгүй бол болохгүй шүү.

Баталсан хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонсгоё.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /15:10/

Хууль тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн 24 хууль тогтоолын төслийг эцэслэн батална, бас.

Түүний өмнө Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батална.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулах учраас Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлтгэнэ.

Тогтохсүрэн дарга аа, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу эцэслэн батлах шаардлага хангахаар ирцтэй бол хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах бөгөөд нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Энэ дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 24 хуулийн төслийг эцэслэн батална.

Ингээд Нийслэлээс сонгогдсон гишүүдийг бүртгэнэ. Пүрэвдорж гишүүн бүртгээд зарлана.

Ирцэд 45 гишүүн бүртгэлтэй байна. Танхимд 26 гишүүн байна. 19 гишүүнийг дуудаж ирүүлбэ.

Тогтохсүрэн дарга байхгүй байгаа 16 гишүүний нэрийг гаргаж өгье. Би дуудъя. Пүрэвдорж 18 гишүүнийхээ нэрийг гаргаж өг.

Дараагийн асуудалд оръё.

“Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Өнөөдөр манай СБД-ийн 3 гишүүн онцгой идэвхтэй оролцож байгааг тэмдэглээд асуудлыг ажил хэрэгч хэлэлцэнэ.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаарх Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайланг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцсэн.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасныг баримтлан “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний тогтолцоо бүрдүүлэх, салбар бүрийн үүрэг, оролцоог тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, боловсон хүчний нөөц, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн стандартыг дээшлүүлж, үдийн хоол хөтөлбөрт 1-12 дугаар ангийн сурагчдыг тэгш хамруулах, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын дэргэд цэцэрлэг байгуулахад төрөөс тавих шаардлага, нөхцөлийг уян хатан болгох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээг үзүүлэхэд тухайн асуудлаар мэргэжисэн төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах боломжийг бий болгох зэрэг саналуудыг тогтоолын төсөлд тусгахаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, тогтоолын төсөлд тусгасан болно.

“Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 90 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар, Ням-Осорын Учрал, Пүрэв-Очирын Анужин нарын урилгаар СХД-ийн ЕБС-ийн 143, 151 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж

байна. Эрхэм хүндэт багш, сурагчид та бүхэндээ сурлагын спортын өндөр амжилтыг хүсэн ерөөж, сур сур бас дахин сур хэмээн ерөөгөөд, сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөрөө тогтоно шүү гэдгийг хүсэн ерөөе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Балжиннямын Баярсайхан гишүүнээр тасаллаа.

Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Хэдхэн хоногийн өмнө хүүхдийн эрх Монгол Улсын хэмжээнд ямар хэмжээнд хангагдаж байгаа юм. Бид нар хүүхдээ хайрлаж хамгаалж чадаж байна уу? Энэ тал дээр УИХ дээр Монголын идэвхтэй, санаачилгатай, зүтгэлтэй ажилладаг төрийн бус байгууллагууд, холбогдох төрийн байгууллагууд, Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хороо, Хүчирхийллийн эсрэг лобби бүлэг гээд энэ хяналтын сонсголыг зохион байгуулсан. Үүнтэй холбогдоод энэ ирэх жилийн төсөвт тавигдаж байгаа хүүхэд хамгааллын зардлыг үр дүнтэй зарцуулах, бодитоор хүүхдээ хамгаалах, хүүхэд хамгаалах, хүүхдийн эрхийг хангах энэ бодлогодоо өөрчлөлт оруулах талаар маш олон хяналтын сонсголд оролцож байсан хүмүүс үг хэлж санал гаргасан. Ялангуяа энэ дотор энэ Хөдөлмөрийн хуульд эцэг, эхчүүдийг ажлын бус цагаар цалингүй ажиллуулахгүй байх, эцэг эхчүүдийг насанд хүрэгчдийг хүүхэд, гэр бүлдээ байх цаг хугацаагаар нь хангаж өгөх энэ асуудлыг бас нэлээн дурдсан байгаа.

Тэгээд энд өнөөдөр холбогдох бас сайд нар нь байвал яг энэ хяналтын сонсголоос цааш, хойш өнөөдрийг хүртэл юу хийж байгаа талаар бас мэдээлэл сонсмоор байна. Өнөөдөр би онцгойлон Цахим харилцаа, холбоо, хөгжлийн яаманд бас талархал илэрхийлж байна. Өнөөдрийн энэ Монгол хүүхдүүдийн гар

утасны хэрэглээ дэлхийн олон улсын хүүхдүүдийн, Монгол насанд хүрэгчдийн гар утасны хэрэглээ, интернэтэд байх цаг хугацаа дэлхийн хүмүүсийн өдөрт хэрэглэж байгаа энэ цахим хэрэглээтэй харьцуулахад маш өндөр байгаа. Энэ дотор бид нар цахимаар хүүхдээ хамгаалах, цахим орчинд хүүхдийн эрхийг хангах асуудал бол онцгой ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Энэ Цахим харилцаа, хөгжлийн яамнаас сар гаруйхан өмнө энэ и-кидс, и-Монголиад и-кидс аппликэйшнийг суулгаж хүүхдүүдээ хаана байгааг хянах ийм боломж нөхцөлийг Монголын эцэг, эхчүүдэд бүрдүүлж өгсөн. Энэ ажлын хэрэгжилт бас ямар түвшинд байгаа талаар бас сонсмоор байна.

Эцэст нь энэ Зайсангийн хүүхдийн хорих анги гэж байсан. Энд орон сууц бариад тэнд хоригдож байсан хүүхдүүдийг Хонхорын хүүхэд, хонхорт нэг хорих ангид өнөөдөр хүмүүжүүлж байгаа нөхцөл байдал бол миний ажлын хэсгээ ахлаад явж байгаа шалгалтын үеэр бол маш хүнд хэцүү нөхцөлд байсан. Үүнийг бас энэ тухайн үед бас хөндөж байсан. Энэ ажил бас ямар түвшинд шинэчлэгдэж байгаа юм бэ гэсэн иймэрхүү асуултууд байна.

Тэгээд Хүний эрхийн дэд хороон дээр энэ талаар ирсэн мэдээлэл байна уу, үгүй юү?

Г.Занданиатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга хариулах уу? Ням-Осорын Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Баярсайхан гишүүнд баярлалаа. Бид 2 сар гаруй хугацаанд иргэнийг таньж мэдэж байгаа энэ Нийтийн мэдээллийн хуульд заасан дан системийн тусламжтайгаар хүүхдийг анх удаа бас таних бололцоотой болсон. Тэгэхээр хүүхэд и-Монголд бүртгүүлээд таньсны дараа эцэг, эхийн зөвшөөрөлтэйгөөр и-кидс гэж аппликэйшнд бүртгүүлж байгаа. Ингээд

хүүхэд байршилаа эцэг эх рүүгээ явуулдаг болсон. Өнгөрсөн хуга хугацаанд яг өнөөдрийн байдлаар 15 мянган хүүхэд и-кидсийг хэрэглэж байна. Тэгээд мэдээж 15 мянган хүүхэд эцэг, эхдээ байршилаа зааж, илгээж, хэрэглэж хэвшиж байгаа нь бол цахим орчинд хүүхдүүдээ хамгаалах хийгээд хүүхдийнхээ байршилг тогтоох, мөн онцгой яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай үед эцэг, эхээсээ гадна мөн бусад байгууллага руу хүсэлтээ илгээх бололцоо бол бүрдсэн байгаа.

Яг өчигдөр Ерөнхий сайдын Америкт хийсэн айлчлалтай холбогдуулаад Монгол Улсад Гүүгл компани ирлээ. Тэгээд Дэлхийн Гүүгл компани Монгол Улсад албан ёсоор орж ирэх ийм шийдвэрээ гаргаад, өчигдрийн байдлаар хүүхэд хамгаалал дээр хамгийн сайн хэрэглэгддэг Гүүгл Фамили Линк гэдэг аппликэйшн Монгол хэлээр нэвтрүүлнэ гэж Та бүхэнд амласныхаа дагуу өчигдөр Гүүгл албан ёсоор Гүүгл Фамили Линкийг Монгол Улсад нутагшуулсан гэдгийг зарласан. Ингээд Гүүгл Фамили Линк болбол Монгол хэлтэй болсон гэсэн үг. Тэгэхээр таны үр хүүхэд бүгдээрээ нөгөө жи мэйлийн мэйлтэй байвал Гүүгл Фамили линкийг Монгол хэл дээр татаж аваад, хүүхдүүдээ бүгдийг нь бүртгэчихвэл хүүхдийнхээ аппликэйшнүүдийг хэдэн цаг хэрэглэхийг нь шууд хязгаарлах бололцоо эцэг, эхчүүдэд үүсчхэж байгаа юм. Жишээ нь фэйсбүүкийг 30 минут хэрэглэнэ, ютүбийг нэг 30 минут үзнэ. 10 цагаас хойш интернэт орохгүй. Дээрээс нь байршлуудыг нь илгээнэ гээд. Ингээд Гүүглтэй бид нар хамтарч ажиллаад 2 дугаар сарын 1-нд Эмерженси Локэйшн сервис гээд нөгөө үүрэн операторын аль утас хэрэглэж байгаагаас нь үл хамаараад андройд утастай болбол дуут дохио өгдөг системийг Гүүглтэй албан ёсоор өчигдөр нэвтрүүлэхээ зарласан. Ингээд 2 сарын 1-нд нээх гэж байна.

Ингээд Гүүгл компани бол манай улсыг бас хүндэтгээд албан ёсоор ирсэн байгаа нь маш том дэвшил. Тэгэхээр эцэг, эхчүүддээ уриалахад эцэг, эхчүүд

хүүхдүүдийнхээ цахим орчинд хэрэглээг хязгаарлахад хуучин шиг гэртээ миний хүү өдөрт нэг цаг л интернэт үзнэ шүү, 10-аас хойш интернэт орохгүй шүү гэж ийм дүрэм зохиодог байсан бол өнөөдөр шууд Гүүгл фэмили линкээр бүртгээд л хязгаарлах бололцоо бүрдэж байна гэсэн үг. Тэгэхээр одоо бол Монгол хэл дээр нэвтэрчхэж байгаа болохоор ийм сайн боломжийг Гүүгл компанитай Монгол Улсын Засгийн газар хамтраад, эхлүүлээд энэ ажил үр дүнгээ өгч байна. Тэгээд эцэг эхчүүддээ хэлэхэд хүүхдүүдийнхээ цахим орчин дахь хэрэглээг Гүүгл Фамили линкээр хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг уриалж байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Адъяаа гишүүн суугаарай. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Энэ санал хураалт дэмжигдсэнгүй. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Би сая хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулга уулзалтад оролцоод 5 минутын дараа орж ирсэн шүү. Их Хурлын даргад энийгээ бас мэдэгдчихье. Албан ёсоор чөлөө аваад явсан байгаа. Хотын түгжрэлийн хууль дээр хамгийн хариуцлагатай байгаа гишүүн шүү. Өчигдөр 10 хүртэл сууж ингэж ажиллаж байгаа гэдгээ хэлчихье.

Тэгээд сая кноп маань нөгөө дарагдсан, тэгэхдээ дутуу дарагдсан юм болов уу минийх сөрөг гарсан байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй

болгоод, дахин явуулж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Энэ тогтоол дэмжигдэхгүй байна.

Балжиннямын Баярсайхан гишүүн санал гаргая. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Энэ маш олон гишүүдийн төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас саяын саналыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгнө үү, дарга аа. Баярлалаа.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Энэ санал дэмжигдэхгүй байна. Тийм учраас ирэх 7 хоногийн хурал дээр дахин боловсруулаад тэгээд бас энэ Хүүхэд хамгааллын тухай хуулиа өргөн барьчихсан байгаа шүү дээ. Тэрнийгээ хуультайгаа хамт хэрэгжүүлэх, хуулиа хэлэлцэж эхлэх ажилд оръё доо. Засгийн газраас хүлээгээд яахгүй бол эмэгтэй гишүүдийн санаачилсан Хүүхэд хамгааллын тухай хууль байгаа шүү дээ, тийм ээ. Засгийн газрынхыг хүлээгээд хэлэлцэхгүй байгаа юм.

Ингээд энэ Улсын Их Хурлын тогтоолын төслийг хойшлууллаа. Дахин боловсруулаад Хүүхэд хамгааллын тухай хуультайгаа бас уялдуулаад тэгээд эцэслэн баталъя. Хүүхэд хамгааллын тухай хуультайгаа хамт батлах нь зүйтэй.

Ганбаатар гишүүн байж байгаарай. Энэ Амартүвшин гишүүн өөрөө хаачив.

Улсын Их Хурлын гишүүд ээ, намын бүлгийн дарга нар, Улсын Их Хурлын дэд дарга нар дараагийн 7 хоногт

чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулиуд эцэслэн батлах санал хураалтад идэвхтэй оролцож, ирцийг бүрдүүлэхийг сануулж, анхааруулж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ